



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР  
ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

---



Улаанбаатар  
2025

# АГУУЛГА

УДИРТГАЛ .....	4
НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ .....	6
1.1.Үнэлгээ хийх шалтгаан.....	6
1.2.Үнэлгээ хийх хүрээ .....	6
1.3.Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тогтоох.....	8
1.4.Үнэлгээний харьцуулах хэлбэр.....	9
1.5.Шалгуур үзүүлэлтийг томъёолох .....	10
1.6.Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.....	12
ХОЁР.ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ .....	12
2.1.Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах.....	12
2.2.Судалгааны аргаар цуглуулсан мэдээлэл .....	12
ГУРАВ.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ.....	13
3.1.Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэлд хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ.....	13
Хуулийн зорилт .....	13
Хуулийн нэр томъёоны тодорхойлолт .....	14
Хөгжлийн банкны эрх зүйн байдал.....	15
Баримтлах зарчим .....	20
3.2.Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 2 дугаар бүлэг. Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:.....	22
Хөгжлийн банкны үйл ажиллагаа .....	22
3.3.Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн гуравдугаар бүлэг. Хөгжлийн банкны удирдлагад хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:.....	27
Хүний нөөцийн тогтворгүй байдал нь засаглалд нөлөөлсөн эсэх.....	27
Санхүүжилтийн шийдвэр гаргасан байдал .....	29
Өнөөгийн нөхцөл байдал .....	29
Компанийн сайн засаглалын зарчимд нийцэж буй эсэх .....	30
3.4.Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн дөрөвдүгээр бүлэг. Хөгжлийн банкны талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, хамтын ажиллагаанд хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:.....	34
Төрийн байгууллагуудын гаргасан шийдвэрүүд .....	35

Төрийн байгууллагаас гаргасан шийдвэрүүдийн хэрэгжилт .....	36
<b>3.5.Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн тавдугаар бүлэг. Хөгжлийн банкны хяналтын тогтолцоо, үйл ажиллагааны хязгаарлалтад хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ: .....</b>	<b>41</b>
УИХ, Монголбанк, Засгийн газар, Үндэсний аудитын газраас хийсэн хяналт, үр дүн .....	41
Хяналт шалгалтуудын хэрэгжилт .....	56
Дотоод хяналт .....	60
<b>3.6.Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн зургаадугаар бүлэг. Санхүүгийн тайлагнал, ил тод байдалд хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:.....</b>	<b>62</b>
<i>Санхүүгийн тайлагнал</i> .....	62
<i>Ил тод байдал</i> .....	65
<b>3.7.Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 31 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагад хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ: .....</b>	<b>66</b>
Зөрчлийн тухай хуультай давхардсан тухай .....	66
<b>ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ .....</b>	<b>67</b>
<b>4.1.Дүгнэлт .....</b>	<b>67</b>
<b>4.2.Зөвлөмж .....</b>	<b>69</b>

# МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## УДИРТГАЛ

Засгийн газрын 2010 оны 195 дугаар тогтоолоор Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Хөгжлийн банк (цаашид “Хөгжлийн банк” гэх) байгуулахаар шийдвэрлэж байсан.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг 2017 онд шинэчлэн баталж, банкны эрх зүйн байдлыг “Хөгжлийн банк нь үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой, энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий ашгийн төлөө хуулийн этгээд байна” гэж тодорхойлсон.

“Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг ЗГХЭГ 2016 оноос эхлэн хэрэгжүүлж байсныг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 122 дугаар тогтоолоор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж байгаад Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 25 дугаар тогтоолоор Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж эхэлсэн байна.

Судалгааны дүнгээр банкны үйл ажиллагааны үр дүнг голчлон хариуцах удирдлага болон удирдлагын багийн гишүүн нэг бүрийн ажилласан хугацаа тогтвортой бус, банкны үндсэн бүтээгдэхүүн болох томоохон төслийн хэрэгжилтийн үр дүнтэй холбон авч үзвэл ажиллах хугацааны гэрээний хэрэгжилт, ажлын үр дүнг тооцох тогтолцоо хангалтгүй үйлчилж ирсэн, нөгөө талаас хараат бус байдалд нөлөөлөхүйц байсан талаар Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хянан шалгах Түр хорооноос хийсэн “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц, байдал”-ыг шалгасан шалгалтын тайланд дурджээ<sup>1</sup>.

Хөгжлийн банкны зохион байгуулалтын бүтэц, хүний нөөцийн хөдлөл өөрчлөлт өнгөрсөн хугацаанд дараах байдалтай байсан. Үүнд:

Хүснэгт 1. Хөгжлийн банкны бүтцийн өөрчлөлт хүний нөөцийн хөдөлгөөн

Д.д	Өөрчлөлт оруулсан тухай тогтоол, шийдвэр	Бүтэц (газар, нэгж, алба)	Батлагдсан орон тоо	Ажиллаж буй орон тоо	Чөлөөлөгдсөн ажилтан	Шинээр ажилд орсон ажилтан
1	ТУЗ-ийн 2012 оны 10 дугаар тогтоол	Газар – 4 Хэлтэс – 11	47	78	8	35
2	ТУЗ-ийн 2012 оны 54 дугаар тогтоол	Газар – 4 Хэлтэс – 12 Нэгж – 3	87	79	13	14
3	ТУЗ-ийн 2014 оны 11, 12 дугаар тогтоол	Газар – 5 Хэлтэс – 19 Алба – 1	168	131	20	45
4	ТУЗ-ийн 2016 оны 69 дугаар тогтоол	Газар – 4 Хэлтэс – 13 Алба – 1	149	134	33	109
5	ТУЗ-ийн 2017 оны 91 дүгээр тогтоол	Газар – 4 Хэлтэс – 13 Алба – 3	149	146	39	59

1 Хянан шалгах Түр хорооноос хийсэн “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц, байдал”-ыг шалгасан шалгалтын тайлан., 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдөр дараах хаягт нийтлэгдсэн.

<https://www.parliament.mn/files/c02d669c1686437a83235768cd005000/?d=1>

6	ТУЗ-ийн 2019 оны 35 дугаар тогтоол	Газар – 4 Хэлтэс – 13	149	138	66	77
7	ТУЗ-ийн 2020 оны 16 дугаар тогтоол	Газар – 6 Хэлтэс – 11	110	106	27	19
8	ТУЗ-ийн 2021 оны 21 дүгээр тогтоол	Газар – 5 Хэлтэс – 15 Алба – 2	131	100	41	4

Банкны бүтцийн нэгжүүдэд ажиллаж ирсэн болон чөлөөлөгдсөн, шинээр ажилд орсон ажилтнуудын тоо нийт батлагдсан орон тооны хэмжээнд харьцуулснаар өндөр хувьтай, тогтвортой бус байдалтай, энэ нь тухайн хугацаанд томилогдсон удирдлагын шийдвэртэй холбоотой, нөгөө талаас томилгоо дагасан хүний нөөцийн өөрчлөлт банкны үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулаагүй, засаглалын алдаанд хүргэсэн байна.

Эдгээр нөхцөл байдалд үндэслэн Улсын Их Хурлын даргын 2022 оны 20 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын тайланд дурдсаны дагуу, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг шинэчлэн найруулах талаар нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай болсон.

Иймд 2017 онд батлагдаж, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох үүднээс Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу “хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ”-г **төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх** гэсэн гурван үе шаттайгаар гүйцэтгэлээ.

Үнэлгээг бие даасан, хараат бус байдлаар, судалгааны арга зүйг ашиглан хийж, судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах зарчмаар гүйцэтгэсэн болно.

## НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

### 1.1.Үнэлгээ хийх шалтгаан

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 2017 оны шинэчилсэн найруулгын хүрээнд “Хөгжлийн банкны үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой” байхаар өөрчилсөн.

Тус өөрчлөлт нь Хөгжлийн банкнаас санхүүжүүлж болох төсөл, хөтөлбөрийн хүрээг хумьж, төсвийн хөрөнгө оруулалтаар хийх боломжгүй төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй эдийн засгийг төрөлжүүлэхэд шаардлагатай эрчим хүч, зам харилцаа, аж үйлдвэрлэлийн цогцолбор, хот төлөвлөлтийн болон боловсруулах үйлдвэрүүдийн томоохон төслүүдийг санхүүжүүлэх боломжгүй бөгөөд зөвхөн тэргүүлэх салбаруудад хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт хамаарах болсон.

Ингэхдээ 2011 оны Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-т заасан “Засгийн газрын баталсан Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий салбарт хамаарах төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх гэснийг хасаж 2017 оны Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Засгийн газар хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл хөтөлбөрийг тусгайлан батлахгүй” гэж оруулсан нь “тэргүүлэх салбар” гэдэгт ямар төсөл, хөтөлбөрийг хамруулан санхүүжүүлэхийг Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын зүгээс дур мэдэн шийдвэрлэх боломж бүрдсэн.

Өнгөрсөн хугацаанд дээрх тодорхойгүй байдлын улмаас Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн дийлэнх нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “үндэсний эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөр”-т хамаарахгүй, түүнчлэн арилжааны банкнаас санхүүжүүлэх бүрэн боломжтой эсхүл тэдний олгосон чанаргүй зээлийг дахин санхүүжүүлсэн, мөн эдийн засгийн үр ашиггүй төслүүд байсан ба үүний улмаас тус банкны санхүүгийн үзүүлэлтүүд хүндрэх, холбогдох албан тушаалтан, зээлдэгчийн зүгээс гэмт хэрэг үйлдэх урьдчилсан нөхцөл болжээ.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль нь 2017 онд шинэчлэгдэж батлагдсанаас хойш хугацаанд буюу хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад хуулийн эрх зүйн зохицуулалт бодит байдалтай нийцээгүй, нийгмийн харилцааны өөрчлөлт хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүйгээс сөрөг үр дагаврууд гарах болсон зэргийг харгалзан хэрэгжилтийн үр дагаварт нь үнэлгээ хийх шаардлагатай гэж үзсэн.

Түүнчлэн уг хуулийг хэрэгжүүлэх явцад орхигдсон, давхардсан, цаг үеэ олоогүй болон хэрэгжих тогтолцоо нь бүрдээгүй зохицуулалтыг тодорхойлох зэрэг цаг үеийн хэрэгцээ шаардлагын дагуу энэхүү үнэлгээг хийсэн.

Уг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийж буй үнэлгээ нь хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход чиглэгдэнэ. Өөрөөр хэлбэл, хуулиар зохицуулсан харилцаа нь зорилгодоо хүрч чадаж байгаа эсэхийг судалж, хэрэгжилтийн явцыг тодорхойлон хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо оновчтой байгаа эсэх, хариуцлагын тогтолцоо үүргээ гүйцэтгэж байгаа эсэхийг тогтоохыг зорилго болгосон.

### 1.2.Үнэлгээ хийх хүрээ

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн хэрэгжилтийн байдлыг дараах байдлаар үнэлэх бөгөөд шаардлагатай зүйл, хэсгийг хүснэгтээр үзүүлбэл;

Хүснэгт 2. Үнэлгээ хийх хэсгүүд

д/д	Үнэлэх бүлэг	Үнэлэх зүйл хэсэг	Үнэлэх эсэх	Тайлбар
1	Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт	Тийм	Хуулийн зохицуулж буй харилцаа нь бусад хуультай давхардаж зөрчилдөж буй эсэх, шаардлагатай харилцааг бүрэн тодорхойлсон эсэхийг тодорхойлох
		2 дугаар зүйл. Хөгжлийн банкны хууль тогтоомж	Үгүй	Шаардлагагүй
		3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ	Үгүй	Шаардлагагүй
		4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт <i>/Энэ зүйлийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./</i>	Тийм	Тайлбарлах шаардлагатай нэр томъёог бүрэн тодорхойлж чадсан эсэх, хэрэгжилтийн үр нөлөөг тодорхойлох
		5 дугаар зүйл. Хөгжлийн банкны эрх зүйн байдал	Тийм	Хөгжлийн банкны эрх зүйн байдлын тодорхойлолт бүрэн дүүрэн эсэх, хэрэгжилтийн үр нөлөөг тодорхойлох
		6 дугаар зүйл. Хөгжлийн банкны өөрийн хөрөнгө	Тийм	Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн тодорхойлолт бүрэн дүүрэн эсэх, хэрэгжилтийн үр нөлөөг тодорхойлох
		7 дугаар зүйл. Хөгжлийн банкны баримтлах зарчим	Тийм	Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн тодорхойлолт бүрэн дүүрэн эсэх, хэрэгжилтийн үр нөлөөг тодорхойлох
2	Хоёрдугаар бүлэг Хөгжлийн банкны үйл ажиллагаа	8 дугаар зүйл. Хөгжлийн банкны үйл ажиллагааны хүрээ	Тийм	Хөгжлийн банкны үйл ажиллагааны хүрээ бүрэн тодорхойлогдсон эсэх, хэрэгжилтийн үр нөлөөг тодорхойлох
		9 дүгээр зүйл. Зээл авах		
		10 дугаар зүйл. Төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх		
		11 дүгээр зүйл. Төлбөр тооцоо хийх		
		12 дугаар зүйл. Баталгаа, батлан даалт гаргах		
		13 дугаар зүйл. Үнэт цаас гаргах, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, хадгалуулах		
		14 дүгээр зүйл. Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулах		
		15 дугаар зүйл. Компанийн хувьцаа эзэмших, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийх		
16 дугаар зүйл. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх				
17 дугаар зүйл. Экспорт, импортын санхүүжилт хийх				
3	Гуравдугаар бүлэг Хөгжлийн банкны удирдлага	18 дугаар зүйл. Хөгжлийн банкны удирдлага	Тийм	Засаглалын зарчимтай нийцэж байгаа эсэх, хэрэгжилтийн үр нөлөөг тодорхойлох
		19 дүгээр зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл	Тийм	Засаглалын зарчимтай нийцэж байгаа эсэх, хэрэгжилтийн үр нөлөөнд нөлөөлсөн эсэх
		20 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх	Тийм	Засаглалын зарчимтай нийцэж байгаа эсэх, хэрэгжилтийн үр нөлөөг тодорхойлох
		21 дүгээр зүйл. Гүйцэтгэх удирдлага, түүний бүрэн эрх	Тийм	Засаглалын зарчимтай нийцэж байгаа эсэх, хэрэгжилтийн үр нөлөөг тодорхойлох
4	Дөрөвдүгээр бүлэг Хөгжлийн банкны талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, хамтын ажиллагаа	22 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх	Тийм	Хэрэгжилтийн үр нөлөөг тодорхойлох
		23 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх		
		24 дүгээр зүйл. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх		
	Тавдугаар бүлэг	25 дугаар зүйл. Хөгжлийн банканд тавих хяналт	Тийм	Хэрэгжилтийн үр нөлөөг

5	Хөгжлийн банкны хяналтын тогтолцоо, үйл ажиллагааны хязгаарлалт	26 дугаар зүйл. Хөгжлийн банкны дотоод аудит 27 дугаар зүйл. Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт 28 дугаар зүйл. Хөгжлийн банкны үйл ажиллагаанд тавих хязгаарлалт		тодорхойлох
6	Зургаадугаар бүлэг Санхүүгийн тайлагнал, ил тод байдал	29 дүгээр зүйл. Санхүүгийн тайлагнал 30 дугаар зүйл. Ил тод байдал		Хэрэгжилтийн үр нөлөөг тодорхойлох
7	Долдугаар бүлэг Бусад зүйл	31 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага	Тийм	Хэрэгжилтийн үр нөлөөг тодорхойлох
		32 дугаар зүйл. Хүчин төгөлдөр болох	Үгүй	Шаардлагагүй

Үнэлгээ хийх хүрээг тогтоох зорилгоор Хөгжлийн банкны хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байсан болон байгаа төрийн захиргааны төв байгууллагууд, тус банканд хяналт тавьдаг Монголбанк, Үндэсний аудитын газар, Хөгжлийн банкнаас санхүүжилт авсан хуулийн этгээдүүд, банкны үе үеийн удирдлага, ажилтнуудын төлөөлөлтэй уулзаж, тандалтын судалгаа хийсний үндсэн дээр үнэлгээний хүрээг тогтоосон.

Үнэлгээ хийх явцад урьдчилан тогтоосон үнэлгээний хүрээг өргөжүүлэх, эсхүл багасгах нөхцөл байдал үүсэж болно.

### 1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тогтоох

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн байдлыг тогтоохдоо Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6-р хавсралтын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтээс үнэлэх зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийг бодитойгоор илэрхийлж чадах шалгуур үзүүлэлтийг энэ үе шатанд харгалзан сонгов. Үнэлгээ хийх ажлын төлөвлөлтийн шатанд хийгддэг шалгуур үзүүлэлтийг тогтоохдоо хуулийн зорилт болох "Хөгжлийн банкны үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндэс болон эрхлэх үйл ажиллагааны хүрээг тогтоож зохицуулахад оршино" гэх зорилтоо бүрэн хангаж, зорилгодоо хүрсэн эсэхийг тогтоож, түүний хэрэгжилтийн явцыг тодорхойлохоор шалгуур үзүүлэлтийг сонгов.

Аргачлалын дагуу «зорилгод хүрсэн түвшин», «практикт нийцэж байгаа байдал», «хүлээн зөвшөөрөгдсөн байдал» гэсэн үндсэн шалгуур үзүүлэлтийг үнэлгээний хамрах хүрээнд тухайн зохицуулалтын хэрэгжилтийг шалгаж чадах, тэдгээрийг хэмжих боломжтой гэдгийг харгалзан үзэж сонгож авсан.

Шалгуур үзүүлэлтийг сонгохдоо тухайн зүйл, хэсэг, заалтын "хэрэгжилтийг хамгийн сайнаар илэрхийлэн гаргаж ирэх" гэсэн шаардлагаар сонгосон бөгөөд тухайн хуулийн зохицуулалтад төдийлөн ач холбогдолтой бус шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

Хүснэгт 3. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

д/д	Үнэлэх бүлэг	Үнэлэх зүйл хэсэг	Шалгуур үзүүлэлт
1	Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны- төдөрхөйлөлт <i>/Энэ зүйлийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./</i> 5 дугаар зүйл. Хөгжлийн банкны эрх зүйн байдал 6 дугаар зүйл. Хөгжлийн банкны өөрийн хөрөнгө 7 дугаар зүйл. Хөгжлийн банкны баримтлах зарчим	Зорилгод хүрсэн байдал Практикт нийцэж байгаа байдал
2	Хоёрдугаар бүлэг Хөгжлийн банкны үйл ажиллагаа	8 дугаар зүйл. Хөгжлийн банкны үйл ажиллагааны хүрээ 9 дүгээр зүйл. Зээл авах 10 дугаар зүйл. Төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх 11 дүгээр зүйл. Төлбөр тооцоо хийх 12 дугаар зүйл. Баталгаа, батлан даалт гаргах	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал Практикт нийцэж байгаа байдал



		13 дугаар зүйл. Үнэт цаас гаргах, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, хадгалуулах 14 дүгээр зүйл. Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулах 15 дугаар зүйл. Компанийн хувьцаа эзэмших, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийх 16 дугаар зүйл. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх 17 дугаар зүйл. Экспорт, импортын санхүүжилт хийх	
3	Гуравдугаар бүлэг Хөгжлийн банкны удирдлага	18 дугаар зүйл. Хөгжлийн банкны удирдлага 19 дүгээр зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл 20 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх 21 дүгээр зүйл. Гүйцэтгэх удирдлага, түүний бүрэн эрх	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал Практикт нийцэж байгаа байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
4	Дөрөвдүгээр бүлэг Хөгжлийн банкны талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, хамтын ажиллагаа	22 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх 23 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх 24 дүгээр зүйл. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал Практикт нийцэж байгаа байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
5	Тавдугаар бүлэг Хөгжлийн банкны хяналтын тогтолцоо, үйл ажиллагааны хязгаарлалт	25 дугаар зүйл. Хөгжлийн банканд тавих хяналт 26 дугаар зүйл. Хөгжлийн банкны дотоод аудит 27 дугаар зүйл. Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт 28 дугаар зүйл. Хөгжлийн банкны үйл ажиллагаанд тавих хязгаарлалт	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал Практикт нийцэж байгаа байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
6	Зургадугаар бүлэг Санхүүгийн тайлагнал, ил тод байдал	29 дүгээр зүйл. Санхүүгийн тайлагнал 30 дугаар зүйл. Ил тод байдал	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал Практикт нийцэж байгаа байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
7	Долдугаар бүлэг Бусад зүйл	31 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага 32 дугаар зүйл. Хүчин төгөлдөр болох	Практикт нийцэж байгаа байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал

#### 1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр

Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний үндэс нь судалж буй зохицуулалтын талаарх ажиглагдаж буй болон хэмжиж болохуйц мэдээллийг цуглуулж, түүний зарим үзүүлэлтийг хооронд нь харьцуулах явдал юм.

Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг тогтоох ажиллагаа нь практикт тухайн хуулийн үйлчлэх хүрээ, тухайн салбарт гарсан хөгжил, өөрчлөлтийг болон бусад холбогдох мэдээллийг тогтоож, тэдгээрийг хооронд нь харьцуулах ажиллагаанд үндэслэнэ.

Өөрөөр хэлбэл, хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн зохицуулалтын үр дүн, үр нөлөөг зөвхөн нэг талаас нь үнэлэх учир дутагдалтай тул өмнөх үе шатанд тогтоосон шалгуур үзүүлэлт бүрд тохирсон харьцуулах хэлбэрийг сонгон үнэлгээ хийх болно.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг үнэлэх сонгож авсан «зорилгод хүрсэн түвшин», «практикт нийцэж байгаа байдал», «хүлээн зөвшөөрөгдсөн байдал» шалгуур үзүүлэлтүүд нь хууль хэрэгжүүлэх явцад бий болсон бодит үр дагавар нь анх хуулиар тавьсан зорилгоо хангаж чадаж байгаа эсэхийг харьцуулах аргаар буюу уг хуулийн дагуу хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын тайлангаар өгсөн дүгнэлт, зөвлөмж, статистик, шүүхийн шийдвэр, судалгааны бүтээл зэргийг ашиглаж тодорхойлох болно.

Түүнчлэн Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн практикт хэрэгжиж буй байдлыг үнэлэхдээ хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацааг «харьцуулалтын арга»-ын тусламжтайгаар тогтоох бол «хүлээн зөвшөөрөгдсөн байдал»-ыг хууль хэрэгжиж эхэлснээс хойших тоо баримтыг «байх ёстой болон одоо байгаа» гэсэн харьцуулалтын аргыг ашиглан тогтооно.

Дээрх харьцуулалтын хэлбэрийн хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулиар тогтоосон хөгжлийн банкны бүтэц зохион байгуулалт, засаглал, эрх мэдлийн хуваарилалт, эрхлэх санхүүгийн ажил үйлчилгээ, зохион байгуулалтын үндэс нь өнөөгийн өөрчлөгдөн буй эдийн засаг, нийгмийн өөрчлөлт, хөгжлийн хандлагад нийцэж байгаа эсэх, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг хэрхэн зохицуулж байгаа болон уг хуулийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг судалж тогтоох юм.

Хүснэгт 4. Үнэлгээний арга зүй

д/д	Үнэлэх бүлэг	Үнэлэх зүйл хэсэг	Харьцуулах хэлбэр
1	Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны- төдөрхөйлөлт <i>/Энэ зүйлийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./</i> 5 дугаар зүйл. Хөгжлийн банкны эрх зүйн байдал 6 дугаар зүйл. Хөгжлийн банкны өөрийн хөрөнгө 7 дугаар зүйл. Хөгжлийн банкны баримтлах зарчим	Хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын тайлангаар өгсөн дүгнэлт, зөвлөмж  Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших тоо баримт
2	Хоёрдугаар бүлэг Хөгжлийн банкны үйл ажиллагаа	8 дугаар зүйл. Хөгжлийн банкны үйл ажиллагааны хүрээ 9 дүгээр зүйл. Зээл авах 10 дугаар зүйл. Төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх 11 дүгээр зүйл. Төлбөр тооцоо хийх 12 дугаар зүйл. Баталгаа, батлан даалт гаргах 13 дугаар зүйл. Үнэт цаас гаргах, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, хадгалуулах 14 дүгээр зүйл. Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулах 15 дугаар зүйл. Компанийн хувьцаа эзэмших, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийх 16 дугаар зүйл. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх 17 дугаар зүйл. Экспорт, импортын санхүүжилт хийх	Хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын тайлангаар өгсөн дүгнэлт, зөвлөмж  Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших тоо баримт  Тохиолдол судлал
3	Гуравдугаар бүлэг Хөгжлийн банкны удирдлага	18 дугаар зүйл. Хөгжлийн банкны удирдлага 19 дүгээр зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл 20 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх 21 дүгээр зүйл. Гүйцэтгэх удирдлага, түүний бүрэн эрх	Хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын тайлангаар өгсөн дүгнэлт, зөвлөмж  Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших тоо баримт  Тохиолдол судлал
4	Дөрөвдүгээр бүлэг Хөгжлийн банкны талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, хамтын ажиллагаа	эрх 22 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх 23 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх 24 дүгээр зүйл. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх	Хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын тайлангаар өгсөн дүгнэлт, зөвлөмж  Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших тоо баримт  Тохиолдол судлал
5	Тавдугаар бүлэг Хөгжлийн банкны хяналтын тогтолцоо, үйл ажиллагааны хязгаарлалт	25 дугаар зүйл. Хөгжлийн банканд тавих хяналт 26 дугаар зүйл. Хөгжлийн банкны дотоод аудит 27 дугаар зүйл. Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт 28 дугаар зүйл. Хөгжлийн банкны үйл ажиллагаанд тавих хязгаарлалт	Хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын тайлангаар өгсөн дүгнэлт, зөвлөмж  Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших тоо баримт  Тохиолдол судлал
6	Зургадугаар бүлэг Санхүүгийн тайлагнал, ил тод байдал	29 дүгээр зүйл. Санхүүгийн тайлагнал 30 дугаар зүйл. Ил тод байдал	Хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын тайлангаар өгсөн дүгнэлт, зөвлөмж  Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших тоо баримт  Тохиолдол судлал
7	Долдугаар бүлэг Бусад зүйл	31 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших тоо баримт  Тохиолдол судлал

## 1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Энэ үе шатанд үнэлгээ хийх зүйл, хэсэг, заалт бүр дээр тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглал дэвшүүлж, асуулт тавих замаар шалгуур үзүүлэлтээ томьёолох юм.

Шалгуур үзүүлэлтийг томьёолох хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулиар зохицуулсан зүйл тус бүрийг шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавихдаа аль болох товч, тодорхой томьёолох зарчим баримтлан ажиллалаа.

Хүснэгт 5. Шалгуур үзүүлэлтийн томьёолол

д/д	Үнэлгээний хүрээ	Шалгуур үзүүлэлтийн зорилго	Харьцуулах хэлбэр	Шалгуур үзүүлэлтийн томьёолол
1	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт <i>/Энэ зүйлийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./</i> 5 дугаар зүйл. Хөгжлийн банкны эрх зүйн байдал 6 дугаар зүйл. Хөгжлийн банкны өөрийн хөрөнгө 7 дугаар зүйл. Хөгжлийн банкны баримтлах зарчим	Зорилгод хүрсэн байдал  Практикт нийцэж байгаа байдал	Хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын тайлангаар өгсөн дүгнэлт, зөвлөмж  Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших тоо баримт	Хуулийн зорилт хангагдаж чадсан уу?  Уг зорилт нь цаг үетэйгээ нийцэж чадаж байгаа эсэх буюу практикт нийцэж буй байдал хэр байна вэ?  Хуулийн нэр томьёоны тодорхойлолт хангалттай эсэх?  Хөгжлийн банкны Хуулийн өнөөгийн эрх зүйн байдал, баримтлах зарчим нь олон улсын сайн туршлагад нийцэж байгаа эсэх?
2	8 дугаар зүйл. Хөгжлийн банкны үйл ажиллагааны хүрээ 9 дүгээр зүйл. Зээл авах 10 дугаар зүйл. Төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх 11 дүгээр зүйл. Төлбөр тооцоо хийх 12 дугаар зүйл. Баталгаа, батлан даалт гаргах 13 дугаар зүйл. Үнэт цаас гаргах, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, хадгалуулах 14 дүгээр зүйл. Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулах 15 дугаар зүйл. Компанийн хувьцаа эзэмших, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийх 16 дугаар зүйл. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх 17 дугаар зүйл. Экспорт, импортын санхүүжилт хийх	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал  Практикт нийцэж байгаа байдал	Хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын тайлангаар өгсөн дүгнэлт, зөвлөмж  Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших тоо баримт  Тохиолдол судлал	Хөгжлийн банкны үзүүлж буй санхүүгийн ажил үйлчилгээг бүрэн дүүрэн тодорхойлж чадсан эсэх?  Эрхлэх үйл ажиллагааны төрөл бүрд тавигдах хуулийн болон бусад шалгуурууд бүрэн дүүрэн эсэх?  Хөгжлийн банкны өнөөгийн нөхцөл байдалд хүргэхэд нөлөөлсөн эсэх?
3	18 дугаар зүйл. Хөгжлийн банкны удирдлага 19 дүгээр зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл 20 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх 21 дүгээр зүйл. Гүйцэтгэх удирдлага, түүний бүрэн эрх	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал  Практикт нийцэж байгаа байдал  Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын тайлангаар өгсөн дүгнэлт, зөвлөмж  Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших тоо баримт  Тохиолдол судлал	Хүний нөөцийн тогтворгүй байдал нөлөөлсөн эсэх?  Санхүүжилтийн шийдвэр гаргалтын талаар?  Компанийн засаглалын сайн зарчим, туршлагад нийцэж байгаа эсэх?
4	22 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх 23 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх 24 дүгээр зүйл. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал  Практикт нийцэж байгаа байдал  Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын тайлангаар өгсөн дүгнэлт, зөвлөмж  Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших тоо баримт  Тохиолдол судлал	Хөгжлийн банкны үйл ажиллагаанд оролцох төрийн байгууллагууд хангалттай ажилласан эсэх?  Хөгжлийн банкны өнөөгийн нөхцөл байдалд хүргэхэд нөлөөлсөн эсэх?
5	25 дугаар зүйл. Хөгжлийн банканд тавих хяналт 26 дугаар зүйл. Хөгжлийн банкны дотоод аудит	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал	Хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын тайлангаар өгсөн	Хяналт шалгалтын тогтолцоо бүрэн дүүрэн эсэх?  Олон улсын сайн туршлагад нийцсэн

	27 дугаар зүйл. Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт 28 дугаар зүйл. Хөгжлийн банкны үйл ажиллагаанд тавих хязгаарлалт	Практикт нийцэж байгаа байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	дүгнэлт, зөвлөмж Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших тоо баримт Тохиолдол судлал	эсэх? Үр дүнд хүрч байсан эсэх?
6	29 дүгээр зүйл. Санхүүгийн тайлагнал 30 дугаар зүйл. Ил тод байдал	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал Практикт нийцэж байгаа байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын тайлангаар өгсөн дүгнэлт, зөвлөмж Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших тоо баримт Тохиолдол судлал	Олон улсын сайн туршлагад нийцсэн эсэх? Хэрэгжих боломжтой байсан эсэх? Үр дүнд хүрч байсан эсэх?
7	31 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага	Практикт нийцэж байгаа байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших тоо баримт Тохиолдол судлал	Хэрэгжих боломжтой байсан эсэх? Үр дүнд хүрч байсан эсэх?

## 1.6.Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Үнэлгээ хийх шалтгаан, үнэлгээний хүрээ, тогтоосон шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэр, томъёолсон шалгуур үзүүлэлтүүдээс хамаарч тоон болон чанарын мэдээллийг ашиглаж дараах мэдээлэл цуглуулах аргыг ашигласан болно. Үүнд:

- **Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах.** Хуулийн хэрэгжилттэй холбоотой судалгааны болон хуулийн дагуу хийгдсэн хяналт шалгалтаас өгсөн дүгнэлт, зөвлөмжүүд, статистик тоо баримт, хуулийн үзэл баримтлал, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эх сурвалж зэргийг ашигласан.
- **Холбогдох субъектүүдээс судалгаа авах.** Уулзалт, ярилцлага зохион байгуулах, шаардлагатай чанарын болон тоон мэдээллийг цуглуулах аргаар хийнэ.

## ХОЁР.ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон мэдээлэл цуглуулах аргыг ашиглан 2024 оны 10 дугаар сарыг 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хооронд хэрэгжилтийн үе шатыг хийж гүйцэтгэв. Энэ үе шатанд холбогдох төрийн байгууллагатай уулзалт ярилцлага хийж, холбогдох тоо баримт, судалгааны ажил зэргийг судалж, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулав.

Мөн нийтлэг ашиглагддаг дээрх аргуудаас гадна баримт бичгийн судалгааны болон харьцуулалтын аргыг ашиглах, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Үндэсний аудитын газар, Монголбанк зэрэг хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагаас авсан албан ёсны мэдээллийг ашигласан болно.

### 2.1.Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах

Монгол Улсын Хөгжлийн тухай хуульд хамаарах Монгол Улсын 8 хууль, Засгийн газрын 156 тогтоол, Монголбанкны ерөнхийлөгчөөс баталсан 2 журам, Хөгжлийн банкны дотоодод мөрдөгдөж буй 108 дүрэм, журам, заавар зэрэг эрх зүйн баримт бичиг, хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагаас хяналт шалгалтуудаас хийсэн тайлан, банкны дотоод тоон мэдээлэл зэрэг бэлэн байгаа мэдээлэлд тулгуурласан болно.

### 2.2.Судалгааны аргаар цуглуулсан мэдээлэл

Хуулийн хэрэгжилтийн явцын талаар тандалтын судалгааг Хөгжлийн банкны хувьцаа

эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байсан болон хэрэгжүүлж буй төрийн захиргааны төв байгууллагууд, тус банканд хяналт тавьдаг Монголбанк, Үндэсний аудитын газар, Хөгжлийн банкнаас санхүүжилт авсан хуулийн этгээдүүд, банкны үе үеийн удирдлага, ажилтнуудын төлөөлөлтэй уулзалт, ярилцлага зохион байгуулж, шаардлагатай чанарын болон тоон мэдээллийг цуглуулсан.

## ГУРАВ.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатанд Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулиас сонгож авсан үнэлэх зүйл, хэсэг, заалт бүрийг хэрэгжүүлэх үе шатанд олж авсан мэдээлэл дээр тулгуурлан үнэлнэ.

### 3.1.Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэлд хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

Үнэлэх хэсэг	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл
Томьёолсон шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"><li>- Хуулийн зорилт хангагдаж чадсан уу?</li><li>- Уг зорилт нь цаг үетэйгээ нийцэж чадаж байгаа эсэх буюу практикт нийцэж буй байдал хэр байна вэ?</li><li>- Хуулийн нэр томьёоны тодорхойлолт хангалттай эсэх?</li><li>- Хөгжлийн банкны Хуулийн өнөөгийн эрх зүйн байдал, баримтлах зарчим нь олон улсын сайн туршлагад нийцэж байгаа эсэх?</li></ul>

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн нийтлэг үндэслэл гэсэн нэгдүгээр бүлэг нь дараах агуулга бүхий 7 зүйлээс бүрдсэн. Үүнд:

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

2 дугаар зүйл. Хөгжлийн банкны хууль тогтоомж

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

*/Энэ зүйлийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./*

5 дугаар зүйл. Хөгжлийн банкны эрх зүйн байдал

6 дугаар зүйл. Хөгжлийн банкны өөрийн хөрөнгө

7 дугаар зүйл. Хөгжлийн банкны баримтлах зарчим

### Хуулийн зорилт

Монгол Улсын хөгжлийн банкны тухай хуулийн 1 дүгээр зүйлд “1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Хөгжлийн банк (цаашид “Хөгжлийн банк” гэх)-ны үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндэс болон эрхлэх үйл ажиллагааны хүрээг тогтоож зохицуулахад оршино” гэж заасан.

Хуулийн зорилт хэсэг нь тухайн эрх зүйн актын хамрах хүрээг тодорхойлсон хэсэг тул өөр бусад хуулиар зохицуулж буй харилцаатай давхардаагүй, зөрчилдөөгүй байх, тухайн зохицуулах гэж буй харилцаагаа бүрэн хамарсан байх шаардлагатай байдаг. Иймд хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн зорилт хэсэгт тодорхойлсон үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндэс болон эрхлэх үйл ажиллагааны хүрээ гэх харилцаанууд нь дээрх шаардлагад нийцэж байгаа эсэхийг доорх хүснэгтээр харуулав.

*Хүснэгт 7.Хөгжлийн банкны тухай хуулийн зохицуулах харилцаа*

д/д	Зохицуулах харилцаа	Бусад хуультай давхардсан эсэх	Зөрчилдсөн эсэх	Бүрэн хамарсан эсэх
1	Хөгжлийн банкны үйл ажиллагааны зарчим	Үгүй	Үгүй	Тодруулах
2	Хөгжлийн банкны удирдлага	Үгүй	Үгүй	Тодруулах
3	Хөгжлийн банкны зохион байгуулалтын эрх зүйн үндэс	Үгүй	Үгүй	Тодруулах
4	Хөгжлийн банкны эрхлэх үйл ажиллагааны хүрээ	Үгүй	Үгүй	Тодруулах

Хуулийн зорилт хэсэгт дурдсан харилцаанууд нь зөвхөн Хөгжлийн банктай холбоотой байх тул бусад хуулиар зохицуулагдсан болон зөрчилдсөн гэх үндэслэл тогтоогдсонгүй. Харин зохицуулах ёстой харилцааг бүрэн хамарч чадсан эсэх нь эргэлзээтэй байна.

Тодруулбал, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль нь 7 бүлэг 32 зүйлээс бүрдэх бөгөөд эдгээр зүйлүүдээс хуулийн зорилт хэсэгт дурдагдаагүй агуулгыг зохицуулсан дараах зүйлүүд байна. Үүнд:

- 6 дугаар зүйл. Хөгжлийн банкны өөрийн хөрөнгө
- 25 дугаар зүйл. Хөгжлийн банканд тавих хяналт
- 26 дугаар зүйл. Хөгжлийн банкны дотоод аудит
- 27 дугаар зүйл. Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт
- 28 дугаар зүйл. Хөгжлийн банкны үйл ажиллагаанд тавих хязгаарлалт
- 29 дүгээр зүйл. Санхүүгийн тайлагнал
- 30 дугаар зүйл. Ил тод байдал

### **Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль нь анх батлагдахдаа дараах хоёр ойлголтыг тодорхойлсон байсан. Үүнд:

4.1.1."Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал" гэж Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 4.1.7-д заасныг;

4.1.2."дунд хугацааны хөгжлийн бодлого" гэж Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 6.3, 6.4-т заасан баримт бичгийг.

Гэвч 2015 онд батлагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль нь анх батлагдахдаа 2020 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс эхлэн хүчингүй болохоор зохицуулсан байсан. Мөн Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд дээрх тодорхойлолтоор тодорхойлогдсон ойлголт нь тусгагдаагүй байсан.

Улмаар 2020 оны 05 сарын 07 өдөр батлагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулахдаа Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцжээ.

Үүнээс үзэхэд хуулийн нэр томъёоны тодорхойлолт нь анхнаасаа хэрэгжих боломжгүй үр нөлөөгүй байсан тул хэрэгжилтийн үр нөлөөг тооцох боломжгүй байна.

Гэсэн хэдий ч хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хүрээнд дараах нэр томъёо болон ойлголтуудыг тодорхойлох шаардлагатай байна. Үүнд:

- Хуулийн 8.1.1-д тусгагдсан “төсөл, хөтөлбөр” гэх ойлголт нь мөн хуулийн 10 дугаар зүйлд зааснаар ижил шалгууртай байгаа нь төслийн санхүүжилтэд тавигдах шаардлагыг хөтөлбөрийн санхүүжилтэд мөн ижил тавих агуулгатай болсон. Улмаар Төсвийн тухай хуулийн 4.1.16-д заасан “төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээ” болон Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5-д заасан “тухайлсан нэг эсхүл хэд, хэдэн эдийн засгийн салбарыг хөгжүүлэх зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаа”-г санхүүжүүлэхдээ хуулийн 10.1-д заасан шаардлагыг хангуулах шаардлагатай эсэхийг

тодорхойлоход хүндрэл үүсгэж байна.

- Төслийн санхүүжилт болон байгууллагын санхүүжилтийн ялгааг гаргалгүйгээр “тендерт оролцогч аж ахуйн нэгжид Өрийн удирдлагын тухай хуулиар тавьдаг шалгууртай ижил стандарт”-ыг баримталж хэт ерөнхий бөгөөд уян хатан бус шаардлагууд тавьсан нь Хөгжлийн банкиг зорилтот бус салбарын буюу нийгэм эдийн засгийн үр ашиггүй төслийг санхүүжүүлэх боломжийг бий болгосон байна.

- Санхүүжилтийн төрөл, арга хэрэгслүүдийг нэг бүрчлэн тодорхойлоогүйгээс төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зарчим, нөхцөл, шаардлагыг тодорхойлж эрсдэл, өгөөжийн зохистой түвшинд активын багцыг бүрдүүлэх боломжийг бууруулсан.

Эдгээрээс гадна хуулийг өөрчлөн найруулах тохиолдолд шаардлагатай ойлголтуудыг мөн хуульд тусган түүнийг хэрхэн ойлгох талаар тодорхойлох нь зүйтэй.

### Хөгжлийн банкны эрх зүйн байдал

Олон улсад амжилттай үйл ажиллагаа явуулж буй хөгжлийн банкуудын эрх зүйн байдлыг авч үзвэл дараах байдалтай байна.

	Хятадын хөгжлийн банк	Казакстаны хөгжлийн банк	Солонгосын хөгжлийн банк
<b>Өмчлөл</b>	БНХАУ-ын Төрийн Зөвлөл (State Council of the People's Republic of China)-ийн удирдлага дор үйл ажиллагаагаа явуулдаг, төрийн өмчит, бодлогын банк.	Төрийн өмчит Baiterek National Managing Holding Joint Stock Company-ны 100%-ын удирдлага (Sole shareholder) дор үйл ажиллагаа явуулдаг.	Financial Services Commission (FSC) - ны хяналт дор үйл ажиллагаагаа явуулдаг төрийн өмчит банк.
<b>Үйл ажиллагааны бүрэн эрх /Mandate</b>	Хятадын дунд, урт хугацааны эдийн засгийн хөгжлийн үндсэн стратегид нийцүүлэн үйл ажиллагаа явуулах	Их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай, урт хугацаат төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх замаар эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтыг үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах	Аж үйлдвэрийн хөгжлийг түргэтгэх, үндэсний эдийн засгийг өргөжүүлэх зорилгоор томоохон аж үйлдвэрийн төслүүдийг санхүүжүүлэхэд шаардагдах хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах
<b>Голлох үйл ажиллагааны чиглэлүүд /Key areas</b>	<ul style="list-style-type: none"> <li>•Нийгэм-эдийн засгийн хөгжлийн асуудлууд, тухайлбал дэд бүтэц, үндсэн салбарууд, тулгуур салбарууд, төрийн үйлчилгээ, удирдлага</li> <li>•Хотжилт, хот ба хөдөөгийн интеграци, бүс нутгийн тэнцвэртэй хөгжил</li> <li>•Үндэсний өрсөлдөх чадварт чухал ач холбогдолтой хөтөлбөрүүд, үүнд уламжлалт салбаруудын өөрчлөлт, шинэчлэл, бүтцийн өөрчлөлт, эрчим хүчний хэмнэлт, байгаль орчны хамгаалалт, дэвшилтэт тоног төхөөрөмж үйлдвэрлэл</li> <li>•Төрийн халамжийн асуудлууд, үүнд орлогод нийцсэн орон сууц, ядуурлыг бууруулах санхүүжилт</li> <li>•Стратегийн чухал салбарууд, тухайлбал шинжлэх ухаан, технологи</li> <li>•"Бүс ба Зам" санаачилга (BRI), аж үйлдвэрийн хүчин чадал, тоног төхөөрөмж үйлдвэрлэл, дэд бүтцийн холболт, эрчим хүч, нөөц баялгийн олон улсын хамтын ажиллагаа болон Хятадын бизнесүүдийн "дэлхий даяар гарах"</li> <li>•Хөгжил болон эдийн засаг, санхүүгийн шинэчлэлийг дэмжих санаачилгууд</li> <li>•Улсын хөгжлийн стратеги, бодлогоор дэмжигдсэн бусад салбарууд.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>•Нийгэм-эдийн засгийн өндөр нөлөөтэй, импортын орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон экспортын чадамжтай үйлдвэрлэлийн төслүүдийг санхүүжүүлэх</li> <li>•Үндэсний эдийн засгийн хөгжлийн хувьд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхэд туслах</li> <li>•Төсөл санхүүжүүлэхэд нөөцийн суурийг өргөжүүлэх</li> <li>•Улсын дэд бүтцийн хөгжлийг дэмжих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>•Үйлдвэрлэлийг хөгжүүлэх ба дэмжих</li> <li>•Жижиг болон дунд үйлдвэрүүдийг дэмжих</li> <li>•Нийгмийн дэд бүтцийн өргөжилт ба бүс нутгийн хөгжил</li> <li>•Эрчим хүч ба нөөц баялгийн хөгжүүлэлт</li> <li>•Аж ахуйн нэгжүүд болон үйлдвэрлэлийн гадаад зах зээл рүү өргөжих</li> <li>•Аж ахуйн нэгжүүдийн бүтцийн өөрчлөлт</li> <li>•Засгийн газраас бодлогоор дэмжих шаардлагатай гэж үзэж буй зорилтот салбарууд</li> <li>•Санхүүгийн салбар болон үндэсний эдийн засгийн хөгжлийг дэмжих, шинэ өсөлтийн хөдөлгөгч хүчтэй салбаруудыг хөгжүүлэх, тогтвортой өсөлтийг дэмжих зэрэг үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилт гаргах бусад салбарууд.</li> </ul>

Ерөнхийдөө хөгжлийн санхүүгийн байгууллагыг хөгжлийг хурдасгах төслүүдэд урт хугацааны санхүүжилтийг олгох гэж тодорхойлогддог боловч бодлогын хувьд дараах байдлаар ангилах боломжтой. Үүнд:

Аж үйлдвэрийн бодлого	Нийгмийн	Улс төрийн
Хөгжлийн банкууд нь аж үйлдвэржилт, ЖДҮ, өндөр бүтээмжтэй аж үйлдвэржилтийг хангах эдийн засгийг бий болгоход шаардлагатай дэд бүтцийг санхүүжүүлэх зорилготой.	Хөгжлийн банкууд ашгийг нэмэгдүүлэхийн эсрэг нийгмийн асуудлыг зохих ёсоор эрэмбэлж, цэвэр ашгийн төлөө биш нийгэм, байгаль орчны хүчин зүйлсийг шийдвэрлэхэд чиглэсэн төслүүдэд нөөцийг хуваарилах зорилготой.	Хөгжлийн банкуудыг улстөрчид үндсэндээ хувийн зорилгодоо хүрэх, улс төрийн мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд ашигладаг тул үүнийг хаахад чиглэсэн бодлого шаардлагатай.

Олон улсын хөгжлийн банкнуудын түүхийг авч үзвэл үйлдвэрлэлийн хувьсгалын эхэн үетэй холбогдох ба харин хөгжлийн үе шатуудын хувьд нэгдсэн ерөнхий замнал байхгүй бөгөөд улс орны, бүс нутгийн онцлогоос хамааран буюу улс орны хөгжлийн бодлогоор хувьсан өөрчлөгдөж иржээ.

	Чили	Канад	Герман	Бразил	Солонгос	Хятад
Байгуулсан он	1939	1944	1948	1952	1954	1994
Одоогийн зорилго	“Хөрөнгө оруулалт, инноваци, хувиараа бизнес эрхлэлтийг дэмжих замаар улс орны өрсөлдөх чадварыг сайжруулах, үр ашигтай төрөлжилтийг бий болгох, түүнчлэн тогтвортой, нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжлийг хангах хүний нөөц, технологийн чадавхийг бэхжүүлэх”	Жижиг, дунд үйлдвэрүүдэд анхаарлаа хандуулж, санхүүжилт, зөвлөх үйлчилгээ, үнэт цаасжуулах замаар Канадын хүчирхэг бизнесийг бий болгох, хөгжүүлэхэд туслах	Герман, Европ болон дэлхий даяар өөрчлөлтийг дэмжиж, ирээдүйд чиглэсэн санааг дэмжих	Бразилийн эдийн засагт тогтвортой, өрсөлдөх чадвартай хөгжлийг дэмжих, ажлын байр бий болгохын зэрэгцээ нийгэм, бүс нутгийн тэгш бус байдлыг бууруулах	Солонгосын санхүү эдийн засгийн салбарт хөгжилд хувь нэмэр оруулах	Эрүүл, өсөж дэвжсэн нийгэм, хүчирхэг эдийн засгийг хөгжүүлэхэд туслах
Байгуулсан этгээд	Чилийн Конгресс (Ерөнхийлөгч Сердагийн бүрэн эрхээр)	Канадын парламент	Холбоотнуудын нөлөөтэй, Баруун Германы засгийн газар	Бразилийн Засгийн газар, Бразил-АНУ-ын хамтарсан хорооны харьяа (CMBEU)	Солонгосын хууль тогтоох байгууллага	Хятадын засгийн газар, Төрийн зөвлөлийн харьяа
Байгуулах шалтгаан	Их хямралын нөлөө (1930-аад он) 1939 оны 1-р сарын газар хөдлөлт	Дэлхийн 2-р дайны дараах сэргээн босголт: - Ахмад дайчдыг ажлын байраар хангана - Аж үйлдвэрийн пүүсүүдийн шилжилт	Дэлхийн 2-р дайны дараах сэргээн босголт: - Биет хөрөнгө - Дэд бүтэц	Нөлөөлөл: - АНУ-ын дайны үеийн тусламж	Солонгосын дайны дараах сэргээн босголт	Дэд бүтцийн өөрчлөлт, хотжилтыг дэмжих бодлогын хэрэгсэл
	Чили	Канад	Герман	Бразил	Солонгос	Хятад



Анхны зорилт	Үйлдвэрлэлийг дэмжих корпораци (CORFO) 1939-1973 он	Аж үйлдвэрийн хөгжлийн банк 1944-1975	Германы хөгжлийн банк (KfW)	Бразилийн Эдийн засгийн хөгжлийн банк (BNDE)	Солонгосын хөгжлийн банк 1950-1970	Хятадын хөгжлийн банк 1994-1998
Зорилтот салбарууд	Импортыг орлох бодлого: - Уул уурхай - Хэрэглээ (Цахилгаан) - Хөдөө аж ахуй - Үйлдвэрлэлийн салбар - Худалдаа	Аж үйлдвэрийн салбарт дутагдалтай ажил үйчилгээ: - Машины дэлгүүрүүд - Хөрөө тээрэм - Гурилын тээрэм - Нэхмэлийн үйлдвэрүүд - Авто эд анги үйлдвэрлэгчид - Металл цутгах	Сэргээн босголт: орон сууц, эрчим хүч, хөдөө аж ахуй - Аж үйлдвэрийн (ган, уул уурхай) - ЖДҮ-ийн санхүүжилтэд шилжих (1950-иад он) - Европын илүү өргөн хүрээтэй тогтворжилт (1960-аад он)	Импортыг орлох бодлого: Нийтийн дэд бүтцэд (төмөр зам, усан цахилгаан станц) анхаарлаа хандуулах Гангийн үйлдвэр (1960-аад он) - Өргөн хэрэглээний бараа - Технологи - Хувийн пүүсүүдэд олгох санхүүжилтийг нэмэгдүүлэх - Экспортод тулгуурласан өсөлт (1970-аад он)	Экспортод тулгуурласан өсөлт: - Дэд бүтэц: Цахилгаан - Уул уурхай: нүүрсний - Үйлдвэрлэл: ган, усан онгоцны үйлдвэрлэл, машин механизм - Хүнд химийн бодис (1970-аад он) - Үйлдвэрийн тусгайлсан охин компаниуд: орон сууц, загас агнуур, хөрөнгийн	Дотоодын дэд бүтэц: - “Үндэсний тэргүүлэх ач холбогдол бүхий” төсөл: Бээжин-Ковлуны төмөр зам, Гурван хавцлын далан, Шанхайн Пудун олон улсын нисэх онгоцны буудал - Суурь болон шинээр хөгжиж буй үйлдвэрүүд
2-р үе шат	Цэргийн дэглэмийн дор дахин анхаарал хандуулах (Pinochet) 1973-1989	Холбооны бизнесийн хөгжлийн банк 1975-1995 он	Дахин санхүүжүүлэх, сэргээн босгох 1970-1990	Өмч хувьчлал ба нийгмийн хөгжил 1980-1990 он	Рационалчлал ба даяаршил 1980-1990 он	Хурдтай өсөлт 1998-2008
Зорилтот салбарууд	Экспортод тулгуурласан өсөлт: ·ТӨҮГ-ын хувьчлал ·Зах зээлийн чөлөөлөлт	· Бизнесийг тогтворжуулах хүч ·Аж ахуй эрхлэхэд анхаарал хандуулсан	·Дотоодын үйлдвэрлэлд дахин анхаарах болсон (1970-аад он) · Зүүн Германд дахин нэгдсэний дараах орон сууцжуулалт (1990-ээд он)	·ТӨҮГ-ын хувьчлал ·Хөрөнгө, үндсэн материалд дахин шинээр анхаарал хандуулсан · Эрчим хүч · Агробизнес ·Нийгмийн хөгжил тэргүүлэх байр суурь эзэлдэг	·Хүнд үйлдвэрүүд: автомашин, электроник (80-аад он) · Өндөр технологийн салбарууд: харилцаа холбоо, мэдээллийн технологи (90-ээд он) · Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал (90-ээд он) ·Хөрөнгө оруулалтын банкны үүрэг	· Хотжилт ·Төлөвлөгөөт бүс нутгийн хөгжил ·Үйлдвэрлэлийн бүтцийг шинэчлэх ·ЖДҮ зорилтот ·Хямд үнэтэй, орлогод нийцсэн орон сууц ·Олон улсын хамтын ажиллагаа
	Чили	Канад	Герман	Бразил	Солонгос	Хятад
3-р үе шат	“Бүтээмж, инноваци, өсөлт” 1990 оноос хойш	Канадын Бизнес хөгжлийн банк 1995 оноос хойш	KfW Групп 2000 оноос хойш	Бразилийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн банк (BNDES) 2000 оноос хойш	Шинэ зуун 2000 оноос хойш	Хятадын Хөгжлийн банкны корпораци 2008 оноос хойш

Зорилтот салбарууд	·ЖДҮ, үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжих ·Инноваци, технологийн дэвшлийг урамшуулах	·ЖДҮ-д анхаарлаа хандуулах ·Аж үйлдвэрлэлийн бус компаниудад үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх ·"Иж бүрэн" санхүүжилтэд анхаарлаа хандуулна	·Мөчлөгийн эсрэг бодлогыг тогтворжуулах ·Тогтвортой хөгжилд анхаарал хандуулах	·Аж үйлдвэржилтэд дахин анхаарал хандуулах (2000-аад он) ·Инноваци ·Нийгэм, хүрээлэн буй орчны хөгжил ·Бүс нутгийн хөгжил	·ЖДҮ-д анхаарлаа хандуулах ·Өндөр өсөлттэй үйлдвэрүүд: сэргээгдэх эрчим хүч, мэдээллийн технологи/цахим	·Дотоодын болон олон улсын дэд бүтцэд анхаарлаа хандуулах ·Үйлдвэрлэл эрхлэлт, инновацийг хөгжүүлэхэд анхаарах ·Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, хөнгөвчлөх · "Ногоон санхүү"-ээр тэргүүлэгч · Хотжмилт, ядуурлаас ангижрах
--------------------	--	---	---	--	--	--

Эх сурвалж: ADFIAP 2016; Almeida, Lima-de-Oliveira, and Schneider 2014; Amsden 1989; Bank of Korea 1973; BDC 2014, 2016a, 2016b; BNDES 2002, 2016, 1987; CDB 2014, 2015; CIA 2016; Clark 1985; Corfo 2016;(Corfo 2016, Díaz 2010, Nazer, Camus and Muñoz 2009) Fergusson, 1948; Frank Jr. and Suk Kim 1975; IDFC 2015; KDB 2014; KfW 2014a, 2014b, 2016; Kim 2013; Meighen and Hervieux-Payette 2010 Min 2004; Min-Ji 2015; Nazer, Camus, and Muñoz 2009; Sanderson and Forsythe 2013; Siedenbiedel and von Petersdorf 2012. CDB column developed with feedback from the bank's staff.

Монгол Улсын Хөгжлийн банкны хувьд дараах байдлаар зорилгыг тодорхойлсон байдаг.

- 2011 оны хуульд: 4.1.Хөгжлийн банк нь энэ хуулийн 8.1-д заасан Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилго бүхий энэ хуульд заасан үйл ажиллагааг эрхлэх тусгайлсан чиг үүрэгтэй ашгийн төлөө төрийн өмчит хуулийн этгээд байна.
- 2017 оны хуульд: 5.1.Хөгжлийн банк нь үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой, энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий ашгийн төлөө хуулийн этгээд байна.

Монгол Улсын Хөгжлийн банк нь 2012-2016 онуудад Чингис, Самуурай, Евро бондын хөрөнгөөр дунд болон урт хугацааны санхүүжилтийг олгож байсан ба бодлогын хувьд экспортыг дэмжих, импортыг орлох чиглэлд санхүүжилтийн дийлэнх хэсгийг олгосон байна.

Олон улсын бодлогын банкны жишгийн дагуу дэд бүтцийн санхүүжилтийг олгож байсан ч энэ дунд хэт төсвийн шинжтэй төсөл, арга хэмжээнүүд ЗГ-ын тогтоолын хүрээнд санхүүжигдэж байсан сул талтай. Мөн Хөгжлийн банкны бодлогын чиглэлд хамаарах ч төсөл бэлэн болоогүй байхад төслийн санхүүжилтийн зарчмыг алдагдуулж, төслийн удирдлагыг хэрэгжүүлэхгүйгээр төслийн зөвлөх үйлчилгээний зардал, ТЭЗҮ хийх зардал зэргийг олгож байсны тод жишээ нь Сайншанд АҮЦ-ын төслийн санхүүжилт юм.

Түүнчлэн, олон улсын туршлагаар амжилттай Хөгжлийн банкнууд нь эдийн засгийн хөгжлийг дэмжих бодлогын хэрэгсэл болж байдгаараа онцлогтой.

Манай улсын хувьд Хөгжлийн банкаа үндсэн үүргээр нь ажиллуулах механизмыг анхнаасаа алдагдуулж зах зээлийг гажуудуулж байсны тод жишээ нь ЗГ-аас 2012-2016 онд “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ыг буруу хэрэгжүүлсэн явдал юм. Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний, барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны, шатахууны жижиглэнгийн худалдааны зэрэг үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд 2012 оны 11 дүгээр сараас 2016 оны 7 дугаар сар хүртэл хугацаанд Монголбанкнаас нийт 4.87 их наяд төгрөгийн санхүүжилт олгосноос орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийг хасаж тооцвол 1.17 их наяд төгрөгийн санхүүжилтийг арилжааны банкаар дамжуулан зах зээлд нийлүүлсэн байдаг.

Хөгжлийн банкны бодлогын үүргийг мартаж, Монголбанкны үйл ажиллагааны бие даасан

байдлыг алдагдуулсан улс төрийн энэ шийдвэрийн нөлөө нь сөрөг байснаас макро болон санхүүгийн эрсдэлийг нэмэгдүүлж, улмаар тухайн үед эдийн засгийн хүндрэлээс манай орон өөрийн дотоод эх үүсвэрээр гарах боломжгүй болоход нөлөөлсөн байдаг.

Хүснэгт. Хөгжлийн банкны 2012-2024 оны санхүүжилт, бодлогын чиглэлээр (тэрбум төгрөг, сая ам.доллар, сая евро)

Бодлогын чиглэл	2012-2016 оны санхүүжилт				2017-2024 оны санхүүжилт					2012-2024 оны нийт олгосон дүр	2024.12.31 Зээлийн үлдэгдэл	
	MNT	USD	EUR	Нийт (€)	MNT	USD	EUR	JPY	CNY	Нийт (€)	Нийт (€)	Нийт (€)
<b>I.ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ИМПОРТЫГ ОРЛОХ</b>	1,093.0	801.1	13.0	2,446.4	822.6	86.4	8.4	4,175.7	-	1,158.5	3,604.8	1,447.9
1 Алтны экспортыг нэмэгдүүлэх	-	-	-	-	44.8	-	-	2,054.2	-	89.5	89.5	51.3
2 Барилгын материалын импортыг орлох	20.0	225.8	13.0	455.0	-	34.3	-	-	-	91.9	546.9	687.0
3 Боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх	894.7	4.1	-	902.1	531.2	8.8	-	688.5	-	567.1	1,469.2	317.2
4 Хүнсний экспортыг нэмэгдүүлэх	174.6	491.7	-	934.5	170.4	-	-	754.5	-	187.3	1,121.8	220.4
5 Төмрийн хүдрийн экспортыг нэмэгдүүлэх	5.6	71.3	-	139.4	-	-	-	678.6	-	14.8	154.2	12.3
6 Хөвөө аж ахуйг дэмжих	-	-	-	-	-	10.0	8.4	-	-	48.5	48.5	-
7 Хүнсний үйлдвэрлэлийн импортыг орлох	-	-	-	-	76.3	30.8	-	-	-	153.2	153.2	99.2
8 Цахилгаан, дулааны тогтвортой ажиллагааг хангах, шинэ эх үүсвэр бий болгох	-	8.2	-	15.4	-	2.4	-	-	-	6.0	21.5	60.6
<b>II НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖИЛ</b>	681.5	295.1	-	1,196.8	27.6	0.0	107.5	2,199.7	-	400.6	1,597.4	360.5
1 Замын түүгэрэл, агаарын бохирдол, утааны асуудлыг шийдвэрлэх	164.5	62.7	-	260.5	24.6	0.0	-	-	-	24.7	285.2	-
1 Гудамж, гэр хороолол хий бүтэц	128.7	4.4	-	136.7	2.1	0.0	-	-	-	2.2	138.9	-
2 Нүүрсжээх синтетик байгалийн хий үйлдвэрлэх төсөл	0.6	-	-	0.6	-	-	-	-	-	-	0.6	-
3 Авто зам-Нийслэл	35.2	58.3	-	133.2	22.5	-	-	-	-	22.5	145.7	-
2 Нийслэл цахилгаан, дулааны шинэ эх үүсвэр бий болгох	495.4	2.1	-	498.7	3.0	-	-	-	-	3.0	501.6	-
3 Орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх	-	50.0	-	95.9	-	-	-	-	-	-	95.9	-
4 Цахилгаан, дулааны тогтвортой ажиллагааг хангах, шинэ эх үүсвэр бий болгох	21.6	180.4	-	341.8	-	-	107.5	2,199.7	-	378.0	714.7	360.5
<b>III ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖИЛ</b>	765.7	146.7	-	975.1	77.6	-	-	-	0.4	274.6	1,249.7	194.4
1 Орон нутгийн авто сүлжээг нэмэгдүүлэх	765.7	146.7	-	975.1	77.6	-	-	-	-	77.6	1,052.7	-
2 Цахилгаан, дулааны тогтвортой ажиллагааг хангах, шинэ эх үүсвэр бий болгох	-	-	-	-	-	-	-	-	0.4	197.0	197.0	194.4
1 Чөйбөлсөнгийн дулааны цахилгаан станцийн хүчин чаллыг 50 МВт-аар өргөтгөх төсөл	-	-	-	-	-	-	-	-	0.4	197.0	197.0	194.4
<b>IV.АГААРЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫГ ДЭМЖИХ</b>	-	101.8	-	152.6	22.9	-	-	-	-	22.9	175.5	29.2
1 Бонинг 767 онгоц худалдаж авах**	-	101.8	-	152.6	-	-	-	-	-	-	152.6	-
2 Агаарын тээврийн үйл ажиллагааг өргөжүүлэх, экспортыг, импортыг дэмжих	-	-	-	-	22.9	-	-	-	-	22.9	22.9	29.2
1 Газар тариалангийн салбарыг дэмжих хөнгөлөлттэй зээл	24.3	-	-	24.3	-	-	-	-	-	-	24.3	-
2 Ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон борлуулалтыг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөр	56.2	-	-	56.2	113.7	-	-	409.0	-	122.6	178.8	-
3 Хүнсний улаан буудайн нөөц бүрдүүлэх төсөл	-	-	-	-	20.1	-	-	-	-	20.1	20.1	-
<b>VI.ХҮНИЙ ХӨГЖИЛ</b>	-	-	-	-	7.3	15.0	-	-	-	44.7	44.7	40.9
1 Эрүүн мэндийг дэмжих	-	-	-	-	7.3	15.0	-	-	-	44.7	44.7	40.9
1 Орлогд нийцсэн орон сууцны хөтөлбөр (дунаж орлоготой иргэд)	111.9	93.9	-	261.9	-	-	-	-	-	-	261.9	-
<b>VIII.БОДЛОГЫН БУС, ТӨСВИЙН ЭСХҮЛ АРИЛЖААНЫ ШИНЖ ЧАНАР ДАВАМГАЙЛСАН</b>	288.0	11.1	-	307.9	73.4	29.8	1.3	2,044.6	-	194.5	502.4	203.9
1 Агаарын бохирдол, утааны асуудлыг шийдвэрлэх	-	-	-	-	0.4	-	0.6	-	-	2.2	2.2	-
2 Барилгын материалын импортыг орлох	-	-	-	-	8.5	2.0	-	-	-	13.3	13.3	11.3
3 Бодлогын бус	266.0	1.5	-	268.7	2.1	-	-	-	-	2.1	270.8	2.5
4 Боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх	-	-	-	-	15.5	15.0	-	1,089.2	-	75.6	75.6	93.1
5 Ногоон зээл	-	-	-	-	2.0	-	0.6	955.4	-	24.9	24.9	25.2
6 Орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх	20.0	9.6	-	39.2	40.8	12.9	-	-	-	72.2	111.4	65.1
7 Экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийн чиглэлийн	-	-	-	-	4.1	-	-	-	-	4.1	4.1	6.9
	3,020.7	1,449.7	13.0	5,421.1	1,165.2	131.2	117.2	8,829.0	420.0	2,238.5	7,659.6	2,276.8

Хуулийн шинэчилсэн найруулгаар 2017 онд банкны шийдвэр гаргалтын хэт бие даасан байдлыг бий болгосноор санхүүжүүлсэн төслүүд нь хөгжлийн томоохон төслүүд гэхээс илүүтэйгээр арилжааны банкны санхүүжүүлэх боломжит хэмжээтэй боловч тэдний шалгуур, шаардлагыг хангахгүй төслүүдийг санхүүжүүлэх нөхцөлийг бий болгож эрсдэлийг нэмэгдүүлсэн.<sup>2</sup>

Хүснэгт. Хөгжлийн банкны зээлийн баацын үлдэгдэл, бодлогын чиглэлээр, чанарын ангиллаар (тэрбум төгрөг)

Бодлогын чиглэл	Хэвийн	Анхаарал хандуулах	Чанаргүй	2024.12.31 Зээлийн үлдэгдэл
<b>I.ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ИМПОРТЫГ ОРЛОХ</b>	288.5	124.9	1,034.5	1,447.9
<b>II.НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖИЛ</b>	360.5	-	-	360.5
<b>III.ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖИЛ</b>	194.4	-	-	194.4
<b>IV.АГААРЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫГ ДЭМЖИХ</b>	-	-	29.2	29.2
<b>V.КОВИД-19-ЫН СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ</b>	-	-	-	-
<b>VI.ХҮНИЙ ХӨГЖИЛ</b>	-	-	40.9	40.9
<b>VII.НИЙГМИЙН ХӨТӨЛБӨР</b>	-	-	-	-
<b>VIII.БОДЛОГЫН БУС, ТӨСВИЙН ЭСХҮЛ АРИЛЖААНЫ ШИНЖ ЧАНАР ДАВАМГАЙЛСАН</b>	-	-	203.9	203.9
<b>НИЙТ ДҮН</b>	843.4	124.9	1,308.6	2,276.8
<b>ЭЗЛЭХ ХУВЬ</b>	37.0%	5.5%	57.5%	100.0%

2017 оноос хойш олгосон арилжааны шинж чанартай зээлүүдийн дийлэнх нь зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй, төслөө хэрэгжүүлээгүй, чанаргүй болсон байдалтай байна. Банк өнгөрсөн хугацаанд чанаргүй зээлийг шүүхийн журмаар төлүүлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсээр ирсэн хэдий ч шүүхийн болон шийдвэр гүйцэтгэлийн шатанд практикийн дагуу цаг хугацаа маш их зарцуулж байна. Шүүхийн журмаар хэрэг маргаан шийдэгдэх хугацаа хамгийн ихдээ 70 сар буюу 5.8 жил зарцуулагдаж байна.

Энэ хугацаанд барьцаа хөрөнгө эргэлтэд орохгүй царцмал байдалд хэт удах, ингэснээрээ үнэ цэн буурах, банк зорилтот салбарынхаа төсөл хэрэгжүүлэгчдэд санхүүжилт олгох чадамж

<sup>2</sup> Жишээлбэл, Хөгжлийн банк нь 2018 онд 408.3 сая төгрөгийг “Дэвшилтэт технологи бүхий эрчим хүчний хэмнэлттэй халаагуур болон бойлуур үйлдвэрлэх төсөл”-д зориулан олгосон ба энэ төсөл нь хүртэл зөрчил үүсгэсэн буюу 2019.02.23-нд төлөгдөж дуусах байсан ч ТАХ-ийн ажиллагаагаар 2021.05.11-нд хаагдсан.

буурах, үндсэн үйл ажиллагаагаа эрхлэх хүртэл боломжгүй болох эрсдэлтэй байдалд оруулжээ.

Тухайлбал, Монголбанкны 2021 онд хийсэн хяналт, шалгалтын үр дүнд Хөгжлийн банкны зээлийн эрсдэлийн санг 0.76 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж 1.7 их наяд төгрөг болгох шаардлагатай гэж дүгнэснээр чанаргүй зээлийн харьцаа 55.3% болж өссөн байдаг ч *Хөгжлийн банк нь олон улсын хөрөнгийн зах зээл дээр арилжаалсан 500.0 сая ам.долларын бонд, Япон улсын зах зээлд хаалттай арилжаалсан 30.0 тэрбум иений Самуурай бондын эх үүсвэрүүдийн хугацаандаа буюу 2023 оны 10 болон 12 дугаар саруудад төлж барагдуулсан.*

Иймд цаашид Хөгжлийн банкны Монгол Улсын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд стратегийн ач холбогдол бүхий томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх үндсэн чиг үүргээ гүйцэтгэх талаар эрх зүйн байдлыг тодорхой болгох, банкны зорилт, эрх хэмжээ болон түүнийгээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээг хуульчлах нь зүйтэй байна.

### Баримтлах зарчим

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д дараах 7 зарчмыг хуульчилсан бөгөөд үүнийгээ компанийн сайн засаглалын зарчмууд хэмээн тодорхойлсон байдаг. Үүнд:

1. ашигтай ажиллах;
2. үйл ажиллагаагаа тогтвортой явуулах;
3. хараат бус байх;
4. ил тод байх;
5. хариуцлагатай байх;
6. Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбоотой шийдвэр нь хамтын удирдлагад үндэслэсэн байх;
7. хараат бус хөндлөнгийн хяналттай байх.

Энэхүү судалгааг гүйцэтгэх явцад цуглуулсан мэдээлэлд дүгнэлт хийж үзвэл Хөгжлийн банкны үйл ажиллагаанд баримтлахаар хуульчилсан зарчмуудыг агуулгын хувьд дараах байдлаар хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 12.Хөгжлийн банкны үйл ажиллагаанд баримтлах зарчмууд

д/д	Хуульд тусгасан зарчмууд	Тайлбар
1	ашигтай ажиллах;	<p>“Ашигтай ажиллах” гэх ойлголт нь санхүүгийн хувьд ашигтай ажиллах ойлголтыг илэрхийлдэг. Гэтэл Хөгжлийн банкны зорилго нь хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д зааснаар “үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх” байна. Ийнхүү хөгжлийн банкны үндсэн үйл ажиллагаа болон үйл ажиллагааны чиглэлтэй зөрчилдсөн байдлаар тайлбарлаж болохуйц байдлаар тус зарчмыг тодорхойлсон нь банкиг ашигтай ажиллах зарчмыг гол болгон арилжааны банктай өрсөлдөхүйц, Монгол Улсын улсын эдийн засагт нөлөөлөхгүй жижиг төслүүдийг санхүүжүүлэх үндэслэл болохоор байна.</p> <p>Хэрэв Хөгжлийн банк нь Засгийн газрын хэрэгжүүлж буй бодлогыг хүрээнд нийгэм, эдийн засгийн үр ашигтай томоохон төсөл, хөтөлбөрийг дэмжиж санхүүжүүлэх бол “ашигтай ажиллах” гэх энэхүү зарчмыг дахин тодорхойлох нь зүйтэй.</p>
2	үйл ажиллагаагаа тогтвортой явуулах;	<p>Үйл ажиллагаа тогтвортой явуулах зарчмын хэрэгжилт хангалтгүй байжээ. Учир нь Хөгжлийн банкны шийдвэр гаргалтын хуваарилалтыг хуулиар тодорхойлоогүй, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хараат бусаар сонгон шалгаруулах хуультай ч бодит байдал дээр хэрэгжүүлж байгаагүй зэргээс шалтгаалан удирдлагын багийн гишүүд болон ТУЗ-ийн гишүүдийг тогтвортой ажиллуулж чадаагүй байна. Мөн Засгийн газраас гаргасан улс төрийн аливаа шийдвэрийн нөлөө хэт их байсан, засгийн газрын бодлого сонгуулийн циклийг даган өөрчлөгдөж байснаас санхүүжүүлсэн төслүүд амжилтгүй болох нөхцөл бүрдсэн байна.</p>
3	хараат бус байх;	<p>“хараат бус байдал” гэдэг нэр томъёог тодорхойлоогүй, хараат бус байдлыг хангахад чиглэсэн заалтуудыг бодит байдалд хэрэгжүүлж байгаагүйгээс бодит байдалд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч байгууллага Засгийн газраас шууд хараат болж улмаар уг зарчим алдагдахад хүрдэг гэж үздэг. Ийм асуудал ялангуяа Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан бодлого шийдвэрийн хүрээнд олгогдсон санхүүжилтүүд олгогдсон байна. Энэ талаар УИХ-ын Хянан шалгах түр хорооноос “Улс төрийн хамааралтай зээлдэгчид нь Хөгжлийн банкнаас нийт 1.5 их наяд төгрөгийн дүн бүхий зээл авсан байгаа нь тус банкны нийт олгосон 7.5 их наяд төгрөгийн зээлийн 20 хувийг эзэлж байна. Тухайлбал, Түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах Нэг дэх сонсголын хүрээнд Хөгжлийн банкны шууд зээлдэгч 77 компаниас 15 нь улс төрийн хамааралтай. Улс төрийн хамаарал тогтоогдсон 15 компанид нийт 746.7 тэрбум төгрөгийн</p>

		дүн бүхий зээл олгосон нь нийт 3.5 их наяд төгрөгийн шууд зээлийн багцын 21.3 хувь болсон.” <sup>3</sup> гэж дүгнэсэн байна.
4	ил тод байх;	Ил тод байх зарчмыг хуульд тухайлан заасан боловч түүнийгээ хэрэгжүүлэх механизмыг хуульчлаагүйгээс тус зарчим бүрэн дүүрэн хэрэгжиж чадаагүй нь хөгжлийн банкны өнөөгийн нөхцөл байдлаас тодорхой харагдаж байна.
5	хариуцлагатай байх;	Хариуцлагатай байх зарчим нь хэрэгжихийн тулд засаглал болон эрх мэдлийн хуваарилалт компанийн сайн засаглалд зайлшгүй нийцсэн байх ёстой. Гэтэл хуулиар Засаглалын бодлогыг батлах үүргийг хэн нэгэнд хүлээлгээгүйгээс өнгөрсөн хугацаанд засаглалын бодлого баталж байгаагүй бөгөөд энэ талаар хараат бус хөндлөнгийн хяналт шалгалтуудаас удаа дараа зөвлөмж өгч байсан ч хэрэгжүүлээгүй байдаг.
6	Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбоотой шийдвэр нь хамтын удирдлагад үндэслэсэн байх;	Хөгжлийн банкны шийдвэр гаргах үйл ажиллагаанд хамтын удирдлагын зарчмыг баримтлах ёстой боловч өнөөдрийн үүссэн нөхцөл байдлаас дүгнэж үзэхэд хамтын удирдлагын зарчим хэрэгжсэн гэж үзэх боломжгүй байна. Тодруулбал, Хөгжлийн банкнаас олгосон санхүүжилттэй холбоотой асуудлаар 80 иргэн, 4 хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэгт АТГ-аас мөрдөн шалгах ажиллагаа явуулж, Нийслэлийн прокурорын газраас яллах дүгнэлт үйлдэж шүүхэд хүргүүлснийг Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2023 оны 4 дүгээр сарын 17-н өдрөөс эхлэн хэлэлцэж шийдвэрлэсэн байдаг. Тус шүүхийн шийдвэрт дурдсанаар <sup>4</sup> “Зээлийн хорооны гишүүд нь банкны эрх ашгийн үүднээс асуудалд хандаж, ямар нэгэн нөлөөнд автахгүй хамгийн бодитой, зөв шударга санал өгөх, шийдвэр гаргах талаар заасан. Гэтэл Зээлийн хорооны гишүүдийн хувьд дээрх төсөл, хөтөлбөрүүдэд санхүүжилт олгохоор шийдвэрлэхдээ зээлийн хорооны гишүүний хувьд үүргээ биелүүлээгүй, дээрх хуулийн шаардлагуудыг хангаагүй аж ахуйн нэгжүүдэд зээл олгохыг дэмжсэн байна.” гэж дүгнэн зээлийн удирдлагын хорооны гишүүдийг бусдад давуу байдал олгох гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон байна.
7	хараат бус хөндлөнгийн хяналттай байх	Сүүлийн жилүүдэд Хөгжлийн банкны үйл ажиллагаанд УИХ /2022/, Засгийн газар /2019/, Монголбанк /2018, 2021/, Монголбанк, Сангийн яамны хамтарсан /2020/, УАГ /2021/, PWC /2018/ зэрэг эрх бүхий байгууллагуудаас хийгдсэн томоохон хяналт шалгалтаар нийт 170 зөрчилтэй асуудал тэмдэглэгдэж, үр дүнд үндэслэсэн нийт 192 дүгнэлт, зөрчил болон эрсдэлийг бууруулах нийт 232 зөвлөмж өгч байв. <sup>5</sup> Харин 2020 онд Сангийн яам болон Монголбанкны хамтарсан шалгалтын ажлын хэсэг нь хяналт шалгалтын тайланг тус банканд ирүүлээгүйгээс зөвлөмжийн хэрэгжилтийг тайлагнаагүй байна. <sup>6</sup> Эдгээрээс үзэхэд Хөгжлийн банк үүсгэн байгуулагдсан цагаас хойш хөндлөнгийн хяналт шалгалтууд хийгдэж байсан боловч тэдгээрийн зүгээс өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс үр дүн хүрээгүй байна. Иймд тус зармыг хэрэгжүүлэх механизм учир дутагдалтай байснаас хэрэгжээгүй байна гэж үзэж байна.

Дээрх хүснэгтээс үзвэл Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулиар тодорхойлсон банкны үйл ажиллагаанд баримтлах зарчмууд нь бүрэн хэрэгжээгүй нь дараах эрсдэлт нөхцөл байдлуудыг үүсгэсэн байна. Үүнд:

- Хуулиар тодорхойлсон өөрийн эрх ашгийг илэрхийлэх гүйцэтгэх удирдлагын хараат бус, бие даасан үр нөлөөтэй үйл ажиллагаа болон банкны хувьцаа эзэмшигч буюу (Засгийн газар) хооронд тодорхой хил хязгаар бүхий харгалзах зохицуулалт үйлчлээгүй;
- Үүсгэн байгуулагдсанаас хойш татан төвлөрүүлсэн хөрөнгийн хурдацтай өсөлт нь тодорхой хугацааны дараа эргэн төлөлтийн буюу ирээдүйд төлбөрийн чадварын хүндрэл үүсгэж болохыг тухайн цаг үед ажиллаж байсан банкны удирдлагуудын мэргэжлийн “ур чадвар” хангалттай тогтоогдоогүй;
- Үйл ажиллагаанд хяналт тавих дотоод нөөц, туршлага ур чадвар байгаагүйгээс хэтийн сөрөг үр дагавраас зайлсхийж чадаагүй, эцсийн шатанд дотоод хяналт нь зээлдэгчийн найдваргүй байдлыг хязгаарлах хүчин зүйл байж чадаагүй;
- Зээл олгох үйл ажиллагаанд Засгийн газрын болон гүйцэтгэх удирдлагын оролцоо, улс төрд нөлөө бүхий этгээдийн ашиг сонирхол идэвхтэй нөлөөлсөн байж болзошгүй;
- Банкны зээлийн үйл ажиллагаа, хөрвөх болон төлбөрийн чадварын аюулгүй байдлын үзүүлэлт олон нийтийн эрх ашгийг хөндөж байсан, учир нь банкны үйл ажиллагаанд тавигдах хөндлөнгийн болон иргэд, олон нийтийн хяналт нь зээл олголтын ил тод бус байдлаас шалтгаалан хэрэгжээгүй;
- Хөгжлийг дэмжсэн төсөл бэлэн байгаагүйн зэрэгцээ, төслийн хөгжүүлэлтийн

3 УИХ-ын 2022 оны 14 дүгээр тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын Их Хурлын 14 дүгээр тогтоолоор Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооны шалгалтын тайлан. 79-80 дугаар тал.

4 Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн шийтгэх тогтоол. 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон.

5 УИХ-ын 2022 оны 14 дүгээр тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын Их Хурлын 14 дүгээр тогтоолоор Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооны шалгалтын тайлан. 9 дүгээр тал.

6 Монгол Улсын үндэсний аудиторын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/158 дугаар тушаалаар баталгаажсан “Хөгжлийн банкны үйл ажиллагааны үр нөлөө, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан. 13 дугаар тал.

алхмыг орхигдуулсан, өндөр эрсдэлтэй зээл олголт нь банкны урт хугацааны эрх ашигт нийцээгүй, төлөөлөн удирдах зөвлөлийн болон гүйцэтгэх удирдлагын зээл олгох шийдвэр ямар өгөгдөл, мэдээлэлд үндэслэн гарч байсан тухай хангалттай иж бүрэн нотлох баримт хангалтгүй.

Иймд Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулиар тус банкны үйл ажиллагаандаа баримтлах зарчмыг дахин тодорхойлох, тэдгээрийг хэрэгжүүлэх механизмыг бусад бүлэгт тодорхой зааж оруулах нь зүйтэй байна.

### 3.2. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 2 дугаар бүлэг. Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:

Үнэлэх хэсэг	Хоёрдугаар бүлэг. Хөгжлийн банкны үйл ажиллагаа
Томьёолсон шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> <li>- Хөгжлийн банкны үзүүлж буй санхүүгийн ажил үйлчилгээг бүрэн дүүрэн тодорхойлж чадсан эсэх?</li> <li>- Эрхлэх үйл ажиллагааны төрөл бүрд тавигдах хуулийн болон бусад шалгуурууд бүрэн дүүрэн эсэх?</li> <li>- Хөгжлийн банкны өнөөгийн нөхцөл байдалд хүргэхэд нөлөөлсөн эсэх?</li> </ul>

Хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн хоёрдугаар бүлэг нь дараах агуулгатай 10 зүйлээс бүрдэнэ. Үүнд:

- 8 дугаар зүйл. Хөгжлийн банкны үйл ажиллагааны хүрээ
- 9 дүгээр зүйл. Зээл авах
- 10 дугаар зүйл. Төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх
- 11 дүгээр зүйл. Төлбөр тооцоо хийх
- 12 дугаар зүйл. Баталгаа, батлан даалт гаргах
- 13 дугаар зүйл. Үнэт цаас гаргах, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, хадгалуулах
- 14 дүгээр зүйл. Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулах
- 15 дугаар зүйл. Компанийн хувьцаа эзэмших, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийх
- 16 дугаар зүйл. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх
- 17 дугаар зүйл. Экспорт, импортын санхүүжилт хийх

Энэ бүлгийн хэрэгжилтэд үнэлгээ хийдээ зүйл бүрээр нь бус Хөгжлийн банк үүсгэн байгуулагдсан цагаас хойш олгогдсон санхүүжилтийн бүтэц, тэдгээрийн үр дүнгийн талаарх статистик мэдээлэлд үндэслэн бүхэлд нь хийж гүйцэтгэлээ.

#### Хөгжлийн банкны үйл ажиллагаа

Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 195 дугаар тогтоолоор Монгол Улсын Хөгжлийн банкиг байгуулахаар шийдвэрлэсэн ба УИХ-аас 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг баталснаар 2011 оны 5 дугаар сарын 12-ны өдөр албан ёсоор нээлтээ хийж үйл ажиллагаагаа эхэлсэн түүхтэй.

Хөгжлийн банк нь 2012 оноос 2024 оны 4-р улирал хүртэлх хугацаанд нийт 7.5 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний зээлийн санхүүжилтийг I) улсын төсвөөс эргэн төлөгдөх II) арилжааны банк болон охин компаниар дамжуулан III) шууд санхүүжилт гэсэн үндсэн 3 хэлбэрээр олгосон.

Хүснэгт 13. Хөгжлийн банкны нийт олголт, санхүүжилтийн хэлбэрээр (тэрбум төгрөгөөр)

Санхүүжилтийн хэлбэр	Нийт олголт - 2012-2024		2024.12.31-ний байдлаар	
	** Олгосон зээлийн дүн	Төслийн тоо	Зээл, хүү үлдэгдэл дүн	Зээлдэгчийн тоо

Төсөвт шилжүүлсэн багц	2,540.2	355	-	-
Дамжуулан багц	1,646.1	2,548	-	-
Шууд зээлийн багц	3,473.2	91	2,276.8	33
<b>Нийт дүн</b>	<b>7,659.6</b>	<b>2,994</b>	<b>2,276.8</b>	<b>33</b>

\*\* Ололт хийх тухай бүрийн ханшаар төгрөгт хөрвүүлэн тооцсон болно.


Нийт олгосон 7.6 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний багцын 80% хувь хаагдсан<sup>7</sup> бол 20% нь үлдэгдэлтэй буюу баланст зээл хэлбэрээр бүртгэлтэй байна.

Хүснэгт 14. Хөгжлийн банкны нийт олголт, зээлдэгчийн өмчийн хэлбэрээр (тэрбум төгрөгөөр)

Зээлдэгчийн хэлбэр	Улсын төсөв		Дамжуулан		Шууд		Нийт		
	Олгосон дүн	Төслийн тоо	Олгосон дүн	Төслийн тоо	Олгосон дүн	Төслийн тоо	Олгосон дүн	Төслийн тоо	Хувь
<b>Хаагдсан</b>	<b>2,540.2</b>	<b>355</b>	<b>1,646.1</b>	<b>2548</b>	<b>1,940.1</b>	<b>53</b>	<b>6,126.5</b>	<b>2956</b>	<b>80.0%</b>
ЗГ-ын харьяа яамд	2,540.2	355	-	-	-	-	2,540.2	355	41.5%
Төрийн өмчит	-	-	81.0	6	915.5	12	996.6	18	16.3%
Хувийн хэвшил	-	-	1,565.1	2542	1,024.6	41	2,589.7	2,583	42.3%
<b>Үлдэгдэлтэй</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1,533.1</b>	<b>38</b>	<b>1,533.1</b>	<b>38</b>	<b>20.0%</b>
Төрийн өмчит	-	-	-	-	692.6	7	692.6	7	45.1%
Хувийн хэвшил	-	-	-	-	840.5	31	840.5	31	54.9%
<b>Нийт</b>	<b>2,540.2</b>	<b>355</b>	<b>1,646.1</b>	<b>2548</b>	<b>3,472.2</b>	<b>91</b>	<b>7,659.6</b>	<b>2994</b>	<b>100.0%</b>
ЗГ-ын харьяа яамд	2,540.2	355	-	-	-	-	2,540.2	355	33.2%
Төрийн өмчит	-	-	81.0	6	1,608.1	19.0	1,689.2	25	22.0%
Хувийн хэвшил	-	-	1,565.1	2542	1,865.1	72.0	3,430.2	2614	44.8%
<b>Хувь</b>	<b>33.2%</b>		<b>21.5%</b>		<b>45.3%</b>		<b>100.0%</b>		

Үлдэгдэлтэй зээлийн багцыг 2024 оны эцсийн байдлаар авч үзвэл зээл, хүү, нэмэгдүүлсэн хүүг хуримтлуулан тооцсоноор буюу өссөн дүнгээр 2.29 их наяд төгрөгтэй тэнцэж байна. Өөрөөр хэлбэл, олгосон үеийн ханшаар тооцсон 1.53 их наядын зээл нь ханшийн өсөлт, хүү зэргийг оруулсан дүнгээр 2.29 их наяд төгрөг байна.

График 2: Хөгжлийн банкны нийт олголт (2012-2024 он)



Дараах графикаас харахад, 2020 оноос банкны хувьд зээл, санхүүжилтийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсон нь харагдаж байна.

**- Зээл, санхүүжилтийн үйл ажиллагаа (2012-2016)**

Анхны хуульд нийцүүлэн Хөгжлийн банкны ТУЗ-өөс 2011 оны 8 дугаар сард баталсан Зээлийн бодлогод эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулах шугам, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх үйлдвэрлэл, түүхий эд, ашигт малтмалын хагас болон бүтэн боловсруулалт бүхий боловсруулах үйлдвэрлэл, авто зам, төмөр замын сүлжээ,

<sup>7</sup> Бэлэн төлөлт, өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө, бонд гэсэн хэлбэрээр хаагдсан болно.

инженерийн байгууламж бүхий дэд бүтэц зэрэг салбарыг тэргүүлэх чиглэл болгосон.

Банк нь 2012-2016 он хүртэлх хугацаанд УИХ, ЗГ-ын шийдвэртэй Хөгжлийн банкны ТУЗ-өөс баталсан Зээлийн бодлого, бусад хууль, тогтоомж, бодлого, дүрэм, журамд тусгагдсан тодорхой шалгуурыг хангасан хөгжлийн тэргүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий салбаруудын томоохон төсөл, хөтөлбөрүүдэд санхүүжилт олгож байв.

УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоолоор “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд ЗГ-аас тухай бүр Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан. Тухайлбал, 6 аймгийн төвийг нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбох төслүүд, УБ хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн бүс болон шинэ суурьшлын бүсийн цэвэр, бохир ус, цахилгаан болон дулаан хангамжийн инженерийн дэд бүтцийн төслүүд, мөн нийслэлийн авто замын сүлжээний нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилготой “Гудамж” төсөл, цахилгаан, дулаан үйлдвэрлэлийн эх үүсвэрийг найдвартай болгох, хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилготой Дөрөвдүгээр дулааны цахилгаан станцын өргөтгөл, Амгалангийн дулааны станцыг шинээр барих, мөн барилгын материалын дотоодын үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, “Шинэ төмөр зам” зэрэг төслүүд багтсан болно.

График 3: Хөгжлийн банкны зээлийн багцын үлдэгдэл (2012-2016 он)



2016 оны эцэст банкнаас олгосон нийт зээлийн багцын үлдэгдэл 6,044 тэрбум төгрөгт хүрч өссөн ба нийт багцын үлдэгдлийн 50-аас дээш хувийг улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй төсөл, хөтөлбөр эзлэх болсон. Өөрөөр хэлбэл, улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийг банкны эх үүсвэр бусад харьцаа үзүүлэлтийг тооцолгүйгээр их хэмжээтэй олгосон нь төсвийн шинжтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага гэж хэлж болохоор хэмжээнд хүргэсэн.

Иймээс, банкны хууль эрх зүйн орчин, санхүүгийн чадавхыг сайжруулах, активыг бүтцийг өөрчлөх, өрийн удирдлагыг хэрэгжүүлэх ажлыг нэн тэргүүнд хийхээр холбогдох санал боловсруулан ажилласны үр дүнд УИХ-ын 2016 оны 81 дүгээр тогтоол, ЗГ-ын 2016 оны 219 дүгээр тогтоол, ЗГ-ын 2017 оны 53 дугаар тогтоол, Сангийн сайдын 2017 оны 104 дүгээр тушаалыг тус тус хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт 348 төсөл арга, хэмжээний 3,117 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний зээлийн багцыг Сангийн яамтай тооцоо нийлж шилжүүлэх арга хэмжээг авсан.

Хүснэгт 17. Хөгжлийн банкны улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон санхүүжилт, эдийн засгийн салбараар болон валютаар (тэрбум төгрөгөөр)

Эдийн засгийн салбар		MNT /тэрбум/	USD /сая/	Нийт олгосон /тэрбум төгрөг/	Хувь	Төсөвт шилжсэн дүнгээр**
Улсын төсөв	Авто зам*	931.2	209.4	1,236.6	48.7%	(1,432.4)
	Инженерийн дэд бүтэц	506.2	2.1	509.5	20.1%	(511.4)
	Төмөр зам	3.7	224.4	361.4	14.2%	(562.3)
	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	3.0	170.6	303.9	12.0%	(427.7)
	Уул уурхай	0.6	2.5	5.5	0.2%	(6.8)
	Боловсруулах үйлдвэрлэл	0.6	4.1	7.9	0.3%	(10.9)
	Бусад	32.6	59.9	115.3	4.5%	(177.9)
<b>Нийт</b>		<b>1,477.8</b>	<b>673.0</b>	<b>2,540.2</b>	<b>100.0%</b>	<b>(3,129.5)</b>




\* Гудамж төслийн санхүүжилтийг тус салбарт хамруулсан.

\*\* 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орох хүртэлх хугацаанд олгосон 12.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нэмж тусгаснаар.

Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хэвийн ангилалтай, улсын рейтингээс хамааран эрсдэлийн сан байгуулах шаардлагагүй байсан багцыг шилжүүлснээр банкны зээлийн багц 52 хувиар буурч 2016 оны жилийн эцэст зээлийн багцын дараах байдалтай үлдсэн ба энэ үеэс банканд чанаргүй зээлийн асуудал яригдаж эхэлсэн.

Улмаар Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдөр УИХ-ын чуулганаар батлагдсан тул банкны санхүүжилтийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх зээлийн бодлого, журам, заавар, арга аргачлалуудыг шинэчлэн батлах ажил 2 жил орчмын хугацаанд үргэлжилсэн байдаг. Үүнээс хойш удирдлагын баг солигдох бүрд дагаад банкны бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөхөөс гадна банкны дүрэм, бодлого, журмууд өөрчлөгдөх зэрэг ажлууд хийгддэг нь банкныг жигд тогтвортой мэргэжлийн ажиллах боломжийг алдагдуулсан.

Зураг 1. Хөгжлийн банкны 2016 оны жилийн эцсийн байдлаарх зээлийн багцын үлдэгдэл



### - Зээл, санхүүжилтийн үйл ажиллагаа (2017-2024)

Банкны зээлийн багцын үлдэгдлийг 2016-2024 онуудын хугацаанд авч үзвэл, зээлийн багц тухайн онуудын олголт, эргэн төлөлтийн зөрүүгээс хамааран өөрчлөгдөж байснаас өөр томоохон өөрчлөлт ороогүй гэж хэлж болно.

График 4: Хөгжлийн банкны зээлийн багцын үлдэгдэл (2016-2024 он)



### - Зээл, санхүүжилтийн чанарын асуудал

Хэдийгээр өнгөрсөн хугацаанд Хөгжлийн банкны хууль эрх зүйн орчин, санхүүгийн байдлаа сайжруулах тал дээр ЗГ-ын дэмжлэгтэйгээр зарим ажлууд хийгдсэн боловч нь 2017 оноос хойш өнөөдрийг хүртэл чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн асуудал үргэлжилсэн хэвээр байна.

Өнгөрсөн хугацаанд Хөгжлийн банк нийт 7.6 их наяд төгрөгийн зээл олгосон. Үүний

- 45% буюу 3.5 их наяд төгрөгийг 91 төсөл хөтөлбөрт шууд олгосон бол
- 22% буюу 1.6 их наяд төгрөгийг 17 хөтөлбөрийн 2548 дэд төсөлд дамжуулан
- 33% буюу 2.5 их наяд төгрөгийг улсын төсвөөр 355 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн.

Энэ хугацаанд шинээр 232.0 сая доллар, 420 сая юань, 488.0 тэрбум төгрөг босгож, Дорнод бүсийн эрчим хүчний систем төсөлд 420.0 юань, Газрын тос боловсруулах төсөлд 25.0 тэрбум төгрөг, Амгалан дулааны станцийн өргөтгөлд 56.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн.

Хөгжлийн банкны эдгээр санхүүжилтийн үр дүнд:

- Цахилгааны эрчим хүчний эх үүсвэрийг 312 МВт,
- Дулааны цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийг 348 МВт-аар нэмэгдүүлж
- Цементийн үйлдвэрлэлийн хүчин чадал 3.3 сая тонноор өсөж,
- Орон нутагт нийт 2,154 км
- Нийслэлд 123 км авто замын барилга, өргөтгөл, шинэчлэл хийгдсэн.

2018 онд зээлдэгчдээс авсан судалгаагаар банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд нийт 15,115 ажлын байрыг нэмэгдүүлж, 81.4 тэрбум төгрөгийн татвар (ААНОАБ-31.5 тэрбум төгрөг, НӨАТ-49.9 тэрбум төгрөг) төлсөн бөгөөд борлуулсан бүтээгдэхүүний хэмжээ 1.4 их наяд төгрөгт хүрч, экспортолсон бүтээгдэхүүний хэмжээ 304.2 тэрбум төгрөгтэй хүрсэн гэсэн үр дүн гарсан. Үүнээс өөрөөр банкнаас санхүүжүүлсэн төслүүдийн үр дүнг бодитоор нарийвчлан тооцох ажил огт хийгдээгүй.

Банкны зээл олголт, тэдгээрийн үлдэгдлийг чанарын ангиллаар авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 18. Нийт олголт, үлдэгдлийг чанарын ангиллаар (тбм.төг)

Санхүүжилтийн хэлбэр		Хэвийн		Анхаарал хандуулах		Чанаргүй		Нийт	
		Олгосон дүнгээр	Үүнээс 2024.12.31 үлдэгдэл дүнгээр	Олгосон дүнгээр	Үүнээс 2024.12.31 үлдэгдэл дүнгээр	Олгосон дүнгээр	Үүнээс 2024.12.31 үлдэгдэл дүнгээр	Олгосон дүнгээр	Үүнээс 2024.12.31 үлдэгдэл дүнгээр
Улсын төсөв	Хаагдсан	2,540.2	-	-	-	-	-	2,540.2	-
	Үлдэгдэлтэй	-	-	-	-	-	-	-	-
	<b>Нийт</b>	<b>2,540.2</b>	-	-	-	-	-	<b>2,540.2</b>	-
Дамжуулан	Хаагдсан	1,526.6	-	24.4	-	95.2	-	1,646.1	-

	Үлдэгдэлтэй	-	-	-	-	-	-	-	-
	<b>Нийт</b>	<b>1,526.6</b>	<b>-</b>	<b>24.4</b>	<b>-</b>	<b>95.2</b>	<b>-</b>	<b>1,646.1</b>	<b>-</b>
Шууд зээл	Хаагдсан	1,313.0	-	438.5	-	479.5	-	2,230.9	-
	Үлдэгдэлтэй	746.0	843.4	6.0	124.9	490.2	1,308.6	1,242.3	2,276.8
	<b>Нийт</b>	<b>2,059.0</b>	<b>843.4</b>	<b>444.5</b>	<b>124.9</b>	<b>969.7</b>	<b>1,308.6</b>	<b>3,473.2</b>	<b>2,276.8</b>
<b>Нийт</b>	Хаагдсан	5,379.7	-	462.9	-	574.7	-	6,417.3	-
	Үлдэгдэлтэй	746.0	843.4	6.0	124.9	490.2	1,308.6	1,242.3	2,276.8
<b>Нийт</b>		<b>6,125.8</b>	<b>843.4</b>	<b>468.9</b>	<b>124.9</b>	<b>1,064.9</b>	<b>1,308.6</b>	<b>7,659.6</b>	<b>2,276.8</b>

Эдгээрээс үзэхэд дээр дурдсан алдааг эрх зүйн харилцааных нь орчинд дахин гаргахгүй байх, Хөгжлийн банкны үйл ажиллагааг сэргээх, эрх зүйн орчныг сайжруулж, боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагын үүднээс Монгол Улсын Хөгжлийн банкны хуулийг шинэчлэн найруулах замаар зарчмын хэд хэдэн өөрчлөлт оруулж, хөгжлийн болон төслийн санхүүжилт, экспорт, импортын санхүүжилттэй холбоотой харилцаа, ажил үйлчилгээг өргөтгөн зохицуулж, Хөгжлийн банкныг экспортыг дэмжигч банк байхаар өөрчлөх нь зүйтэй байна.

Хуулийг шинэчлэн найруулахдаа олон улсын Хөгжлийн банкнуудын алдаа ба сайн туршлагыг судалж, харьцангуй амжилттай хөгжиж байгаа бусад орнуудын Хөгжлийн банкнуудын үйл ажиллагаатай өөрийн банкны нөхцөл байдлыг жишиж, холбогдох судалгааг хийх шаардлагатай байна.

### 3.3. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн гуравдугаар бүлэг. Хөгжлийн банкны удирдлагад хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:

Үнэлэх хэсэг	Хоёрдугаар бүлэг. Хөгжлийн банкны удирдлага
Томьёолсон шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> <li>- Хүний нөөцийн тогтворгүй байдал нөлөөлсөн эсэх?</li> <li>- Санхүүжилтийн шийдвэр гаргалтын талаар?</li> <li>- Компанийн засаглалын сайн зарчим, туршлагад нийцэж байгаа эсэх?</li> </ul>

Хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн гуравдугаар бүлэг нь дараах агуулгатай 4 зүйлээс бүрдэнэ. Үүнд:

- 18 дугаар зүйл. Хөгжлийн банкны удирдлага
- 19 дүгээр зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл
- 20 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх
- 21 дүгээр зүйл. Гүйцэтгэх удирдлага, түүний бүрэн эрх

Энэ бүлгийн хэрэгжилтэд үнэлгээ хийдээ зүйл бүрээр нь бус Хөгжлийн банк үүсгэн байгуулагдсан цагаас хойш олгогдсон санхүүжилтийн бүтэц, тэдгээрийн үр дүнгийн талаарх статистик мэдээлэлд үндэслэн бүхэлд нь хийж гүйцэтгэлээ.

#### Хүний нөөцийн тогтворгүй байдал нь засаглалд нөлөөлсөн эсэх

Засгийн газрын 2010 оны 195 дугаар тогтоолоор Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Хөгжлийн банк байгуулахаар шийдвэрлэж байсан.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг 2017 онд шинэчлэн баталж, банкны эрх зүйн байдлыг “Хөгжлийн банк нь үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох,

экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой, энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий ашгийн төлөө хуулийн этгээд байна” гэж тодорхойлсон.

“Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг ЗГХЭГ 2016 оноос эхлэн хэрэгжүүлж байсныг Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 122 дугаар тогтоолоор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж эхэлсэн байна.

Хөгжлийн банк үүсгэн байгуулагдсанаас хойш /2011 он/ Засгийн газраас банкттай холбоотой гаргасан 165 тогтоол, тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавраас бүрэн хэрэгжсэн 123, хэрэгжих шатанд байгаа 14, хэрэгжих боломжгүй 28 арга хэмжээ байна гэж Хянан шалгах түр хороонд мэдээлсэн<sup>8</sup>.

Хөгжлийн банк үүсгэн байгуулагдсанаас хойш ТУЗ-ийн даргаар нийт 11 хүн буюу дунджаар 1.6 жил ажиллаж байна. Ажилласан хугацааны хувьд хамгийн бага нь 51 өдөр, их нь 1404 өдөр буюу ажиллажээ. Ажиллаж байсан 10 хүний 5 нь дунджаар 230 хоног, 3 нь дунджаар 650 хоног, 2 нь 1000-аас дээш хоног ажилласан байна.

ТУЗ-ийн гишүүнээр нийт 30 орчим хүн ажиллаж байснаас ажилласан хугацааны хувьд хамгийн бага нь 110, их нь 1404 өдөр ажилласан ба дунджаар 673 хоног ажилласан байна. Нийт 25 гишүүний 24 хувь нь 1 жил хүртэл хугацаанд ажилласан бол үлдсэн 76 хувь нь 1-3.8 жил хүртэл хугацаагаар тус тус ажиллажээ.

ТУЗ-ийн хараат бус гишүүдээр нийт 20 гаруй хүн ажилласнаас ажилласан хугацааны хувьд хамгийн бага нь 73, их нь 2069 өдөр ажилласан ба 16 хүн дунджаар 791 хоног ажилласан байна. Ажиллаж байсан 16 хүний 12.5 хувь нь 1 жил хүртэл хугацаанд ажилласан бол үлдсэн 87.5 хувь нь 1-ээс 5.6 жил хүртэл ажилласан байна.

Гүйцэтгэх захирлаар нийт 8 хүн томилогдсоноос хугацааны хувьд хамгийн бага нь 217, их нь 1106 өдөр ажилласан ба дунджаар тус албан тушаалд 667 хоног ажилласан байна.

Тэргүүн дэд болон дэд /орлогч/ захирал, газрын захирлаар нийт 30 гаруй хүн ажилласнаас тайлант хугацаанд 7 хүн томилогдсон өдрөөс хойш ажиллаж байна. Тодруулбал, 2013 оноос хойш эхлэн ажиллаж байгаа 2 хүн байгаа ба хамгийн богино ажилласан хүн 1 жил ба түүнээс урт хугацаанд ажиллаж байна. Нийт 3 ажилласан хугацааны хувьд хамгийн бага нь 23, их нь 3948 өдөр ажилласан ба 28 хүн дунджаар тус албан тушаалд 837 хоног ажилласан байна. Ажиллаж байсан 28 хүний 14% нь 1 жил ба түүнээс бага хугацаанд ажилласан бол 86% нь 1.2 жилээс 10.8 жил хүртэл буюу харьцангуй тогтвортой ажилласан байна.

Банкны бүтцээр газар, нэгжүүдэд ажиллаж ирсэн болон чөлөөлөгдсөн, шинээр ажилд орсон ажилтнуудын тоо нийт батлагдсан орон тооны хэмжээнд харьцуулснаар өндөр хувьтай, тогтвортой бус байдалтай, энэ нь тухайн хугацаанд томилогдсон удирдлагын шийдвэртэй холбоотой, нөгөө талаас томилгоо дагасан хүний нөөцийн өөрчлөлт банкны үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулаагүй, засаглалын алдаанд хүргэсэн байна.

Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 67 дугаар тогтоолоор 2023 оны бизнес төлөвлөгөөг баталсан ч цаашид нөхцөл байдалтай уялдуулан алсын харааг тодорхойлох, урт болон дунд хугацаанд баримтлах стратеги, түүнийг хэрэгжүүлэх арга замыг боловсруулах шаардлагатай байсан.

Банкны үйл ажиллагаанаас зээл олголт, эргэн төлөлт, түүний орчинтой холбоотой үйл ажиллагаа залилангийн эрсдэлд өртөмтгий байдаг ч залилангийн эрсдэлийг тодорхойлж үнэлэх зохистой горим нэвтрүүлж, уг эрсдэлийг их гэж үнэлсэн тохиолдолд урьдчилан сэргийлэх, илрүүлэх тогтолцоо /горим журам/ үйлчлээгүй байсан.

<sup>8</sup> Эх сурвалж: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн ХЭГ/2399 дугаар албан бичиг

Дээр дурдсан стратеги, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд залиланттай тэмцэх стратегийг боловсруулж, залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, удирдах арга хэмжээг үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд тусгаж өгөх хэрэгтэй байсан.

### Санхүүжилтийн шийдвэр гаргасан байдал

Хөгжлийн банкнаас 2021 оны 1 сард олон нийтэд мэдээлсэн чанаргүй зээлийн мэдээлэлд үндэслэн шууд зээлийн үлдэгдлийн төлөв болон чанарын ангилал, зээл олгох үеийн шийдвэрлэлтийн түвшнийг судалж үзэхэд Хөгжлийн банкны шууд олгосон зээлийн шийдвэрлэлтийн түвшин буюу эцэслэсэн шийдвэрлэсэн байдал дараах байдалтай байсан<sup>9</sup>.

Тухайн үед банкны нийт актив хөрөнгө нь 3.3 их наяд төгрөг, үүнээс 67 зээлдэгчийн 3.2 их наяд төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэйгээс 1.8 их наяд төгрөг нь чанаргүй зээл байсныг мэдээлж байсан.

Хүснэгт. Хөгжлийн банкны зээл олголтыг эцэслэн шийдвэрлэсэн байдал, зээлийн үлдэгдлээр (тэрбум төгрөгөөр)

Д.д	Зээл олгох шийдвэрийн хэлбэр	Зээлийн тоо	Олгосон зээл (тухайн өдрийн ханшаар)	Үүнээс			
				Зээлийн төлбөрийн үлдэгдэл			
				Үндсэн зээл	Хүү	Торгууль	Нийт
1	ТУЗ-ийн тогтоол	44	2,482.3	2,450.5	483.1	21.0	2,954.6
2	ТУЗ-ийн тэмдэглэл	5	96.9	97.6	29.2	0.9	127.7
3	Гүйцэтгэх захирал	18	71.1	53.2	10.5	0.8	64.5
	Дүн	67	2,650.2	2,601.3	522.8	22.7	3,146.8

Хөгжлийн банкны зээл олгох шийдвэрийг дээрх хүснэгтэд харуулсан байдлаар эцэслэн гаргаж ирснээс нийт үлдэгдэлтэй байгаа зээлдэгчийн 44 буюу 65.7 хувийг төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор, 5 буюу 7.5 хувийг төлөөлөн удирдах зөвлөлийн тэмдэглэлээр, 18 буюу 26.8 хувийг гүйцэтгэх захирлын тушаалаар тус тус шийдвэрлэсэн байна.

Тухайн үеийн байдлаар банкны тайлан тэнцлийн анхаарал хандуулах болон чанаргүй ангилалд бүртгэлтэй нийт 33 зээлийн 29-ийг ТУЗ-ийн тогтоолоор, 4-ийг ТУЗ-ийн тэмдэглэлээр, 10 зээлийг гүйцэтгэх захирлын тушаалаар тус тус олгож байсан.

### Өнөөгийн нөхцөл байдал

Хөгжлийн банкны үйл ажиллагаа маш их хумигдсан. Банкны санхүүгийн тайлан тэнцлээс харахад актив хөрөнгө 2017 онд 5.8 их наяд төгрөг байсантай харьцуулахад 60 орчим хувиар буурч, 2024 оны 12 сарын 31-ний байдлаар 2.368 тэрбум төгрөг болсон байгаа бөгөөд зээл олгох, төсөл санхүүжүүлэх, эх үүсвэр татан төвлөрүүлэх үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхгүй зогсонги байдалд орсон. Санхүүгийн үзүүлэлтүүдийг харахад:

Нийт актив хөрөнгө буурсан тул зээлд эзлэх чанаргүй зээлийн жин буурахгүй байна. 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Хөгжлийн банкны актив хөрөнгө 2,368.7 тэрбум төгрөг байна. Нийт активт эзлэх зээлийн багцыг танилцуулбал 33 зээлдэгчийн 2,276.8 тэрбум төгрөг нь зээл байна: Үүнээс:

- Хэвийн зээл: 834.4 тэрбум төгрөг;
- Анхаарал хандуулах зээл: 124.9 тэрбум төгрөг;
- Чанаргүй: 1308.6 тэрбум төгрөг байна.

Нийт зээлийн эрсдэлийн сан 952.9 тэрбум төгрөг байна. Үүнээс:

- Хэвийн зээл: 42.2 тэрбум төгрөг;
- Анхаарал хандуулах зээл: 16.3 тэрбум төгрөг;
- Чанаргүй: 894.4 тэрбум төгрөг байна.

Нийт зээлийн багцын 1,308.6 тэрбум төгрөг буюу 57.5% хувийг чанаргүй зээл эзэлж байгаа

<sup>9</sup> Хэрэгжилтийн үр нөлөөний судалгааг гүйцэтгэж эхлэх үед ХӨГЖЛИЙН БАНКАас ирүүлсэн мэдээлэл

ба үүнээс 25.6 тэрбум төгрөг нь төрийн өмчит, 1,282.4 тэрбум төгрөг нь хувийн хэвшлийн зээл юм.

Хуримтлагдсан алдагдал 738.0 тэрбум төгрөг, энэ жилийн алдагдал 220.7 тэрбум төгрөг болсон байна. Өөрийн хөрөнгийн зөрүүг нөхөх хэрэгцээ шаардлага үүссэн байна. Товчхон дүгнэхэд, Хөгжлийн банк санхүүгийн хүндрэлд орж төлбөрийн чадваргүйд тооцогдох хууль эрх зүйн үндэс бүрдэхээр байна.

Хүснэгт. Хөгжлийн банкны зээлийн үлдэгдэл, шийвэрлэсэн байдал (тэрбум төгрөгөөр)

№	Зээлдэгчийн нэр	Олгосон зээлийн мэдээлэл (анхны гэрээний нөхцөлөөр)			Зээлийн хугацаа		Зээлийн үлдэгдэл (тбм.төг)	МУХБ-наас хэвл олгосон албан тушаалтан /зээлийн гэрээний нөхцөлөөр/			Ангилал
		Валют	Олгосон (сая валют)	тбм.төг олгосон өдрийн хэлц	Олгосон огноо	Төлөх огноо		Шийдвэрийн хэлбэр	ТУЗ дарга	Гүйцэтгэх захирал	
1	АЧЛАЛ ТРЕЙД ХХК	USD	15.0	37.4	2017.10.13	2022.10.13	40.9	ТУЗ тогтоол	Б.Даажамба	Б.Багбаатар	Чанаргүй
2	БОЛОР ШҮҮР ХХК	JPY	104.8	2.3	2017.08.30	2017.12.08	1.2	ГЗ гушаал	Б.Багбаатар	Б.Багбаатар	Чанаргүй
3	*БЭРЭН ГРУПП ХХК - армагур	USD	27.2	55.3	2014.04.16	2022.10.15	135.8	ТУЗ тогтоол	Б.Шинэбаатар М.Баярмагнай	Н.Мөнхбаг Б.Багбаатар	Чанаргүй
	БЭРЭН ГРУПП ХХК - Ё блок	USD	11.7	28.5	2017.10.30	2020.10.23	13.4	ТУЗ тэмдэглэл	Б.Даажамба	Б.Багбаатар	Чанаргүй
4	ГАЗ-ИМПОРТ ХХК	JPY	223.6	4.9	2018.10.17	2025.10.17	6.5	ГЗ гушаал	Б.Багбаатар	Б.Багбаатар	Чанаргүй
5	ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК	CNY	420.0	197.0	2021.10.28	2031.10.28	194.4	ТУЗ тогтоол	С.Наранцогт	Н.Мөнхсүх	Хэвийн
6	ДИС-4 ТӨХК	EUR	77.5	237.9	2018.07.20	2026.08.05	271.0	ТУЗ тогтоол	М.Баярмагнай	Б.Багбаатар Г.Амаргүвшин	Хэвийн
7	ДЭД БҮТЭЦ ИНЖЕНЕРИНГ ХХК	MNT	2,102.0	2.1	2018.09.17	2023.09.14	2.5	ГЗ гушаал	Б.Багбаатар	Б.Багбаатар	Чанаргүй
8	ЗЭСТ-ӨНДӨР ХХК	JPY	439.4	9.7	2018.08.10	2023.08.10	12.3	ТУЗ тогтоол	М.Баярмагнай	Б.Багбаатар	Чанаргүй
9	ИЗИНИС ЭЙРВЭЙЗ ХХК	MNT	22,915.00	22.92	2019.10.29	2024.10.29	29.2	ТУЗ тогтоол	М.Баярмагнай	Г.Амаргүвшин	Чанаргүй
10	ИМПЕРИАЛ ГОУЛД МАЙНИНГ	MNT	16,000.00	16.00	2019.04.02	2022.04.02	11.7	ТУЗ тогтоол	М.Баярмагнай	Б.Багбаатар	Чанаргүй
11	ИНЖИР ХХК	USD	2.0	4.8	2018.01.09	2023.01.09	11.3	ГЗ гушаал	Б.Багбаатар	Б.Багбаатар	Чанаргүй
12	МБУ ТРЕЙД ХХК	MNT	11,500.00	11.5	2018.02.13	2023.02.13	16.7	ТУЗ тэмдэглэл	Б.Даажамба	Б.Багбаатар	Чанаргүй
13	МОНГЕМА ХХК	JPY	419.3	9.1	2017.10.31	2024.10.25	13.0	ТУЗ тогтоол	Б.Даажамба	Б.Багбаатар	Чанаргүй
14	*МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨХК	MNT	176,083.1	176.1	2018.04.26	2028.04.26	288.5	ТУЗ тогтоол	Б.Даажамба	Б.Багбаатар	Хэвийн
15	МОНГОЛ ДРАЙ МИЛК ХХК	USD	15.0	36.1	2017.05.16	2023.12.19	74.0	ТУЗ тогтоол	Б.Даажамба	Б.Багбаатар	Чанаргүй
16	МОНГОЛ МИКРОН КАШМЕР ХХК	MNT	5,000.00	5.0	2018.06.13	2019.12.15	12.1	ТУЗ тэмдэглэл	Б.Даажамба	Б.Багбаатар	Чанаргүй
17	МОНДУЛААН ТРЕЙД ХХК	MNT	15,000.00	15.0	2018.10.22	2021.06.22	19.4	ТУЗ тогтоол	М.Баярмагнай	Б.Багбаатар	Чанаргүй
18	МОННИС МАЙНИНГ ХХК	MNT	107,355.00	107.4	2019.08.07	2025.08.08	122.7	ТУЗ тогтоол	М.Баярмагнай	Г.Амаргүвшин	Чанаргүй
19	НВЦ ХХК	USD	21.0	51.7	2017.09.15	2027.09.15	67.2	ТУЗ тогтоол	Б.Даажамба	Б.Багбаатар	Чанаргүй
20	ПИ СИ ВАЙ ХХК	MNT	4,000.00	4.0	2018.06.13	2019.12.15	6.0	ГЗ гушаал	Ч.Энхбаг	Б.Багбаатар	Чанаргүй
21	ПИРАМИД-ОРД ХХК	MNT	15,000.00	15.0	2017.11.17	2021.11.17	26.0	ТУЗ тэмдэглэл	Б.Даажамба	Б.Багбаатар	Чанаргүй
22	ПРОМОН ТРЕЙД ХХК	MNT	2,000.00	2.00	2020.01.17	2026.09.01	0.7	ТУЗ тогтоол	М.Баярмагнай	Г.Амаргүвшин	Чанаргүй
	ПРОМОН ТРЕЙД ХХК	JPY	731.8	16.1	2017.07.31	2026.09.01	17.9	ТУЗ тогтоол	Б.Даажамба	Б.Багбаатар	Чанаргүй
23	СОНГОУЛД ХХК	JPY	699.6	15.1	2017.12.28	2020.10.10	19.0	ТУЗ тогтоол	Б.Даажамба	Б.Багбаатар	Чанаргүй
24	СЭЛЭНГИЙН ГЕРЕФОРД ХХК	MNT	4,100.00	4.1	2018.08.24	2022.08.24	6.9	ГЗ гушаал	Б.Багбаатар	Б.Багбаатар	Чанаргүй
25	*ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ ТӨҮТ	USD	7.06	14.23	2016.02.05	2019.06.30	25.6	ТУЗ тогтоол	Б.Шинэбаатар	Н.Мөнхбаг	Чанаргүй
26	ТУГЭЭМЭЛТҮМЭН ХИШИГ ХХК	MNT	18,517.3	18.5	2018.08.23	2023.08.23	25.8	ТУЗ тогтоол	М.Баярмагнай	Б.Багбаатар	Чанаргүй
27	*ХӨТӨЛ ХХК	USD	61.3	84.8	2012.10.19	2020.10.19	377.3	ТУЗ тогтоол	Б.Багбаатар	Ким Жанг Жин	Чанаргүй
28	ЦЭЭНС МАЙНИНГ ЭНД ЭНЕРЖИ ХХК	EUR	30.0	85.9	2018.05.02	2026.05.02	61.0	ТУЗ тогтоол	Б.Даажамба	Б.Багбаатар	Хэвийн
	ЦЭЭНС МАЙНИНГ ЭНД ЭНЕРЖИ ХХК	JPY	2,199.66	49.16	2018.06.21	2026.05.02	28.5	ТУЗ тогтоол	Б.Даажамба	Б.Багбаатар	Хэвийн
29	ШАНХ МАЙНИНГ ХХК	MNT	5,600.00	5.6	2019.09.07	2024.09.07	7.6	ГЗ гушаал	Г.Амаргүвшин	Г.Амаргүвшин	Чанаргүй
30	*ЭГИЙН ГОЛЫН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК	USD	10.6	21.5	2013.12.05	2021.03.31	60.6	ТУЗ тогтоол	Б.Шинэбаатар Б.Даажамба	Г.Амаргүвшин	Анхаарал хандуулах
31	ЭНСАДА-ИСТЕРН ХХК	USD	9.83	25.21	2018.10.17	2025.10.17	32.0	ТУЗ тогтоол	М.Баярмагнай	Б.Багбаатар	Чанаргүй
32	*ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ	USD	14.8	25.0	2014.01.30	2022.06.10	64.2	ТУЗ тогтоол	Б.Шинэбаатар	Н.Мөнхбаг	Анхаарал хандуулах
33	**ЭРЭЛ ХХК	USD	23.0	40.0	2013.08.20	2022.06.14		ТУЗ тогтоол	Б.Шинэбаатар	Н.Мөнхбаг	Чанаргүй
	**ЭРЭЛ ХХК	EUR	13.0	30.4	2014.06.06	2019.04.05	173.9	ТУЗ тогтоол	Б.Шинэбаатар	Н.Мөнхбаг	Чанаргүй
<b>НИЙТ ДҮН</b>				<b>1,456.7</b>			<b>2,276.8</b>				

\* УИХ, ЗГ-ын тусгайгасан тогтоолын хүрээнд Хөгжлийн банкнаас санхүүжилт олгосон төслүүд

### Компанийн сайн засаглалын зарчимд нийцэж буй эсэх

Энэ бүлэгт бид одоо байгаа байгууллагын засаглалын тогтолцоо нь Банкний хянан шалгах Базелын хороо (цаашид “БХШБХ” гэх)-ны удирдамжийн банкнуудын байгууллагын засаглалын зарчимд нийцэж буй эсэхэд шинжилгээ хийсэн.

Хөгжлийн банкны засаглалын тогтолцооны үнэлгээ нь дараах зүйлсэд төвлөрсөн болно:

- Одоогийн байгууллагын засаглалын бүтэц (үүрэг, хариуцлага, үндсэн бодлого, журмууд)
- Дотоод хяналтын тогтолцоо, эрсдэл болон нийцлийн бодлого, журмууд, ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэх, түүнээс сэргийлэх бодлого, журмууд)
- Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) болон удирдлагын хороодыг багтаасан байгууллагын зохион байгуулалтын бүтэц
- ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагыг нэр дэвшүүлэх үйл явц
- Үндсэн бодлого, журмууд - Дотоод хяналтын тогтолцоо, эрсдэл ба нийцлийн бодлого, журмууд, ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэх, түүнээс сэргийлэх бодлого, журмууд, цалин, урамшууллын бодлого, журам).

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд (2017 оны 4 сарын 1-ээс хүчин төгөлдөр дагаж мөрдсөн) Хөгжлийн банк нь ашгийн төлөө хуулийн этгээд бөгөөд доорх байгууллагын засаглалын зарчмуудыг баримтлахыг заасан:

- Ашигтай ажиллах;
- Үйл ажиллагаагаа тогтвортой явуулах ;
- Хараат бус байх;
- Ил тод байх;
- Хариуцлагатай байх;
- Шийдвэр нь хамтын удирдлагад үндэслэсэн байх;
- Хараат бус хөндлөнгийн хяналттай байх

Тус хууль нь Хөгжлийн банкны хяналтын системийг сайжруулж дараах зүйлсийг зохицуулсан:

- Монголбанкны эрх нь Хөгжлийн банкны зохистой харьцааг тогтоож, журамтай нийцүүлэн хянах;
- Хараат бус дотоод аудитын үйл ажиллагаа;
- Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төслүүдийн хэрэгжилтэд чиглэсэн хяналтын чиг үүрэг

Хэдий тийм боловч хуульд заасан шаардлагууд нь БХШБХ-ны Удирдамжийн дагуу байгууллагын засаглалын бүх зарчмуудыг хамраагүй (тухайлбал, Банкны хараат бус байдал, ашигт ажиллагаа ялангуяа зээл олгох үйл явцад ашиг сонирхлын зөрчил болон холбоотой талын ажил гүйлгээнүүдэд баримтлах бодлого чухал ач холбогдолтой зарчмуудыг хангаагүй) байх тул Хөгжлийн банкны байгууллагын засаглалын удирдамжууд нь 2012-2016 онтой харьцуулахад ихээхэн сайжирсан боловч олон улсын стандартад бүрэн нийцээгүй байна.

Бид байгууллагын засаглалын сайн туршлагад нийцээгүй гол зөрүүтэй үр дүнг болон түүнд холбогдох санал зөвлөмжүүдийг доорх Хүснэгт 20-т харууллаа.

Хүснэгт 20: Байгууллагын засаглалын тогтолцоотой холбоотой үр дүн болон санал зөвлөмж

Д/д	Холбогдох стандарт ба дүрэм журам	Үр дүн	Санал зөвлөмж
1	<b>ТУЗ-ийн ерөнхий чиг үүрэг- үндсэн бодлого, журмууд</b>		
1.1	<b>Зарчим 1 (26) (БХШБХ д328)</b> ТУЗ нь Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний үнэлгээний үйл явц, капиталын болон хөрвөх чадварын төлөвлөгөө, бодлого, журам ба хүлээсэн үүргийн нийцэл, дотоод хяналтын системтэй холбоотой үндсэн бодлого, журмын хэрэгжилтийг батлах болон хянах хэрэгтэй.	Дотоод хяналтын систем, Эрсдэлийн удирдлагын систем болон Байгууллагын засаглалын үнэлгээний тайланг 2012-2024 онуудад гүйцэтгээгүй.	Банк нь дотоод хяналтын тогтолцоог нэвтрүүлж, дотоод хяналтын системийн ерөнхий аргачлал, түүний бүрэлдэхүүн (хяналтын орчин, хяналтын үйл ажиллагаа, мэдээлэл ба харилцаа холбоо, хяналтын үйл ажиллагаа), нэг болон хоёрдугаар түвшний хяналтын үүрэг, хариуцлагыг тодорхойлох хэрэгтэй.
1.2	<b>Зарчим 1 (БХШБХ д223)</b> Үр дүнтэй дотоод аудитын үйл ажиллагаа нь Банкны дотоод хяналтын чанар, түүний үр дүнтэй байдал, эрсдэлийн удирдлага, засаглалын систем, үйл явцын талаар Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ыг хараат бус баталгаажуулалтаар хангана.	Банк нь дотоод хяналтын тогтолцоог нэвтрүүлээгүй.	
1.3	<b>Зарчим 7 (БХШБХ д223)</b> ТУЗ нь хамгийн багадаа жилд 1 удаа дотоод аудитын нэгжийн өгсөн мэдээлэлд үндэслэн дотоод хяналтын тогтолцооны үр нөлөө, үр дүнтэй байдлыг хянан үзэх хэрэгтэй.	ТУЗ нь Банкны дотоод хяналтын систем, засаглалын бүтэц, түүний практик, эрсдэлийн удирдлагад хамгийн эцсийн хариуцлага хүлээдэг боловч одоогийн байдлаар ТУЗ нь дотоод хяналтын систем, эрсдэлийн удирдлага болон байгууллагын засаглалын хяналтын үйл явцад хангалттай оролцохгүй байна.	Банк нь дотоод хяналтын систем, эрсдэлийн удирдлагын тайлангуудыг боловсруулж ТУЗ-д тайлагнаж, илэрсэн дутагдлуудыг хойшлуулахгүйгээр шийдвэрлэж байх хэрэгтэй.

1.4	<b>Зарчим 13 (БХШБХ д223)</b> Дотоод аудитын үйл ажиллагаа нь бизнес нэгжүүдийн болон бусад туслах үйл ажиллагаанаас үүсэж буй дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, байгууллагын засаглалын үр нөлөө болон үр дүнтэй байдлыг хараат бусаар үнэлж, тэдгээр систем болон үйл явцыг баталгаажуулна.		
<b>2 ТУЗ-ийн бүрэлдэхүүн ба мэдлэг чадвар</b>			
2.1	<b>Зарчим 2 (БХШБХ д328)</b> ТУЗ-ийн гишүүд нь дангаараа болон нийтээрээ тухайн албан тушаалыг эрхлэх мэдлэг чадвартай байх хэрэгтэй. Тэд өөрсдийн хэрэгжүүлэх хяналт, байгууллагын засаглалыг ойлгож, Банкны үйл ажиллагааны талаар зөв, бодитой дүгнэлт гаргах чадвартай байх хэрэгтэй.	<b>ХӨГЖЛИЙН</b> БАНКНЫ тухай хуульд зохистой шалгуурыг хэт тодорхойлж өгсөн бөгөөд тэдгээр нь Олон улсын тэргүүн туршлагатай нийцсэн байна. Гэвч ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулах үүргээ Засгийн газар биелүүлж байгаагүй байна.	ТУЗ-ийн гишүүнээр томилогдсон гишүүдийн мэргэжлийн ур чадварыг тогтмол сайжруулах механизмыг бүрдүүлэх шаардлагатай.
<b>3 ТУЗ-ийн өөрийн бүтэц ба практик - ашиг сонирхлын зөрчил</b>			
3.1	<b>Зарчим 3 (82 - 86) (БХШБХ д328)</b> ТУЗ нь боломжит ашиг, сонирхлын зөрчлийг илрүүлэхийн тулд бодлого, журмын хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт тавих хэрэгтэй. Эдгээр зөрчлөөс урьдчилан сэргийлэх боломжгүй бол ТУЗ нь зохих ёсоор удирдах (үндэсний хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагын стандартад нийцсэн байгууллагын сайн засаглалын хүрээнд ажил гүйлгээ болон холбоо хамаарлыг зөвшөөрсөн байх дээр үндэслэх) хэрэгтэй.  ТУЗ нь албан ёсоор бичигдсэн ашиг, сонирхлын зөрчлийн бодлого, журамтай байх хэрэгтэй бөгөөд бодлогыг хэрэгжүүлж, дагаж мөрдөхийг зорилгоо болгох хэрэгтэй.	Банк нь ашиг, сонирхлын зөрчлийн бодлого, журмыг батлаагүй бөгөөд зөвхөн ерөнхий хэмжээнд батлагдсан хуулийг мөрдөж байгаад 2024 онд Гүйцэтгэх захирлын тушаалаар авлигын эсрэг бодлогыг баталсан. Шалтгаан нь хуулиар авлигын эсрэг бодлого талаар хуульд заагаагүй тул гэх үндэслэлээр <b>ТУЗ батлахаас татгалзсан.</b>	Банк нь ашиг, сонирхлын зөрчлийн бодлогыг баталж, ашиг, сонирхлын зөрчил үүсгэх нөхцөлийг нарийн тодорхойлох хэрэгтэй.  Банк нь албан ёсны холбоотой талуудын ажил гүйлгээний бодлого, журмыг нэвтрүүлэх хэрэгтэй. ТУЗ-ийн гишүүдийн авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг мэдүүлэг хөтлөх журамтай болох шаардлагатай.
<b>4 ТУЗ-ийн ерөнхий чиг үүрэг – холбоотой талуудын ажил гүйлгээ</b>			
4.1	<b>Зарчим 1 (27) (БХШБХ д328)</b> ТУЗ нь эрсдэлийг үнэлэхийн тулд болон зохих хязгаарлалт (тухайлбал гүйлгээ нь зах зээлийн нөхцөлөөр хийгдэхийг шаардах гэх мэт)-ыг тавих, банкны өмчийг зүй бусаар шамшигдуулахыг хязгаарлахын тулд (групийн дотоод дахь гүйлгээ зэрэг) холбоотой талуудтай хийгдэх гүйлгээнд хангалттай нарийн хяналт хийгдэж буй эсэхийг нягтлах хэрэгтэй.	Банк нь холбоотой талын ажил гүйлгээний бодлого, журмыг батлаагүй ч зээл олгох болон батлах ерөнхий журмыг бүх харилцагчдадаа ашигладаг.	Банк нь холбоотой талуудын ажил гүйлгээг зохицуулах хяналтын механизм болон бодлогыг батлах хэрэгтэй.
4.2	<b>Зарчим 5 (98) (БХШБХ д328)</b> Салбар ТУЗ нь группийн байгууллагын засаглалын тогтолцоо нь группийн ашиг сонирхлыг зохистойгоор хүлээн зөвшөөрөхөд чиглэсэн группийн доторх гүйлгээнээс үүсэж болох групп доторх боломжит ашиг, сонирхлын зөрчлийг тодорхойлж, хянахын тулд зохих бодлого, журам болон хяналтыг багтаасан эсэхийг хариуцах хэрэгтэй .	Банк нь холбоотой талуудын жагсаалтыг тодорхойлсон боловч жагсаалтыг тогтмол хугацаанд шинэчлэх эсвэл бүрэн эсэхийг нь шалгаагүй.	
<b>5 ТУЗ-ийн бүтэц ба практик - хороод</b>			
5.1	<b>Зарчим 3 (64 - 67) (БХШБХ д328)</b> Хороо бүр нь өөрийн бүрэн эрх, хамрах хүрээ болон ажлын горимыг тодорхойлсон дүрэмтэй байх ёстой. Үүнд хороо нь хэрхэн ТУЗ-д бүхэлд нь тайлагнах, хорооны гишүүдийн хүлээх үүрэг болон хороонд ажиллах хугацааны хязгаарлалт багтсан байна.  ТУЗ нь өөрийн байгуулсан хороод, тэдгээрийн бүрэн эрх, түүний бүрэлдэхүүнийг (хараат бус гэж үзэх гишүүдийг оролцуулан) ил тод мэдээлэх хэрэгтэй.	ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын хороодын дүрэм нь хангалттай нарийвчилсан биш (дарга болон гишүүнчлэлийг тодорхойлоогүй).  Тодруулга нь сайн туршлагатай нийцээгүй.	Банк нь : Хороодын гишүүнчлэлийг тодорхойлох хэрэгтэй. Аудит болон Эрсдэлийн хороог тусгаарлах хэрэгтэй. Тодруулгын агуулгыг сайжруулах хэрэгтэй



	ТУЗ-ийн хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус, гүйцэтгэх бус гишүүн байна.		
5.2	<b>Зарчим 3 (68, 71) (БХШБХ д328)</b> Аудитын хороо нь бусад хорооноос тусдаа байх хэрэгтэй. Эрсдэлийн хороо нь Аудитын хорооноос тусдаа байх хэрэгтэй.	Аудит болон эрсдэлийн удирдлагын хороо нь тусгаарлагдаагүй.	
5.3	Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-ийн удирдлага болон хяналтын дор бизнесийн стратеги, эрсдэлийн аппетит, цалин урамшуулал болон ТУЗ-аас баталсан бусад бодлого, журамтай нийцүүлэн банкны үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.	2017 он буюу шинэ хууль батлагдсанаас хойш буюу 2017 оны 08 дугаар сарын 22-нд батлагдсанаас хойш өөрчлөлт ороогүй, шинэчилж батлаагүй. Гүйцэтгэх удирдлага дангаар шийдвэр гаргаад байна уу, хамтаар шийдвэр гаргаад байна уу гэдэг нь тодорхой бус.	Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийн үйл ажиллагааны журмыг шинэчлэх шаардлагатай.
5.4	<b>Группийн бүтцийн засаглал Зарчим 5 (БХШБХ д328)</b> Группийн бүтцэд толгой компанийн ТУЗ нь группийн ерөнхий хариуцлагыг хүлээх бөгөөд группийн хэмжээнд болон охин компаниудын бүтэц, бизнес, эрсдэлийг зохистой түвшинд удирдах нарийн тодорхойлсон засаглалын тогтолцоог үүсгэх, ажиллуулахад хариуцлага хүлээнэ. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь банкны группийн зохион байгуулалтын бүтэц болон эрсдэлийг мэддэг, таньдаг байх хэрэгтэй.	Банкны дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, хяналт болон тайлагнал нь охин компаниудыг хамраагүй. (тухайлбал. ДиБиЭМ Лизинг ХХК нь дотоодын бизнес эрхлэгчдэд тоног төхөөрөмжийн лизингийн үйлчилгээ үзүүлдэг бол; ДиБиЭМ Хөрөнгийн Менежментийн ХХК нь гадаад валютын дотогшлох урсгал болон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой; Үндэсний Экспортын даатгал ХХК).	Банк нь эрсдэлийг нэгтгэсэн (охин компаниудын эрсдэлийн түвшнийг оролцуулан) түвшинд удирдаж, хянаж байх хэрэгтэй.
<b>6</b>	<b>Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа</b>		
6.1	<b>Зарчим 6(БХШБХ д328)</b> Банк нь эрсдэл хариуцсан захирлын удирдлага дор хангалттай өндөр түвшинд хараат бус, тодорхой нөөц бололцоотой, болон ТУЗ нэвтрэх боломжтой байдлаар хараат бус, үр дүнтэй эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаатай байх хэрэгтэй.	Санал байхгүй. Олон улсын сайн туршлагатай нийцсэн.	Санал зөвлөмж байхгүй.
<b>7</b>	<b>Эрсдэлийг тодорхойлох, хянах болон удирдах</b>		
7.1	<b>Зарчим 7(БХШБХ д328)</b> Банкны хэмжээнд болон бие даасан аж ахуй нэгжийн хувьд эрсдэлийг тодорхойлж, үнэлж, хянаж байх хэрэгтэй. Банкны эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын бүтцийн нарийвчлал нь банкны эрсдэлийн шинж чанар, гадаад эрсдэлийн хүчин зүйлс болон салбарын практикийн өөрчлөлттэй уялдуулах хэрэгтэй.	Эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэсэгт тусгасан үр дүнг харна уу.	Эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэсэгт тусгасан санал зөвлөмжийг харна уу.
<b>8</b>	<b>Эрсдэлийг мэдээлэх харилцаа</b>		
8.1	<b>Зарчим 8 (БХШБХ д328)</b> Эрсдэлийн талаарх үр дүнтэй эрсдэлийн засаглалын тогтолцоо нь байгууллагын хэмжээнд болон ТУЗ, Гүйцэтгэх удирдлагад тайлагнах замаар мэдээлэх өргөн хэмжээний харилцааг шаарддаг.	Эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэсэгт тусгасан үр дүнг харна уу.	Эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэсэгт тусгасан санал зөвлөмжийг харна уу.
<b>9</b>	<b>Нийцэл</b>		
9.1	<b>Зарчим 9 (БХШБХ д328)</b> Банкны ТУЗ нь банкны нийцлийн эрсдэлийн удирдлагад хяналт тавих чиг үүрэгтэй. ТУЗ нь нийцлийн үйл ажиллагааг бий болгож, нийцлийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хянах, тайлагнах, зөвлөх үйл явцыг батлах хэрэгтэй.	Банк нь нийцлийн үйл ажиллагааг эхлүүлсэн боловч Зохиистой эрсдэлийн зураглал (тухайлбал Банкны хүлээж болох эрсдэлийн тодорхойлолт) болон эрсдэлийн материаллаг байдлын үнэлгээ хийгээгүй. 2-р түвшний хяналтын албан ёсны зураглал байхгүй.  Тиймээс бүх нийцлийн эрсдэл нь Дотоод аудитын (3-р түвшний хяналт) нэгжээс үе үе хийгддэг	Банк нь нийцлийн эрсдэлийг тодорхойлж, удирдах нийцлийн эрсдэлийн үйл явцын голлох чиглэлийг тодорхойлохын тулд нийцлийн бодлого, журмаа шинэчлэх хэрэгтэй. Бид жилийн эрсдэлд суурилсан төлөвлөгөө дээр үндэслэн нийцлийн хяналт хийхийг зөвлөж байна.

		хяналтын үйл явцаас өөрөөр тогтмол хяналтын үйл явцаар хангагддаг эсэх нь тодорхой биш байна.	
<b>10</b>	<b>Дотоод аудит</b>		
10.1	<b>Зарчим 10 (БХШБХ д328)</b> Дотоод аудитын үйл ажиллагаа нь ТУЗ-ийг хараат бус баталгаажуулалтаар хангах хэрэгтэй. Дотоод аудит банкны нийт эрсдэлийн засаглалын тогтолцоонд тогтмол хугацаанд үнэлгээ хийх шаардлагатай, үүнд: Эрсдэлийн удирдлага, нийцлийн үйл ажиллагааны үр дүнтэй байдал; ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад тайлагнаж буй эрсдэлийн тайлангийн чанар; Банкны дотоод хяналтын системийн үр дүнтэй байдал.	2012-2016 онуудад Дотоод Аудитын хангалтгүй/хүрэлцээгүй байдлаас шалтгаалан 2012-2017 онуудад дотоод хяналтын систем, эрсдэлийн удирдлагын систем болон байгууллагын засаглалын тайланг гүйцэтгээгүй. 2017 онд хүчин чадлын асуудал шийдэгдсэн байсан.	Банк нь дотоод хяналтын систем, эрсдэлийн удирдлага болон нийцлийн үйл ажиллагааг тогтмол хугацаанд үнэлж, тайлагнаж хэрэгтэй.  Банк нь тайлангаа ТУЗ-д тайлагнаж, мэдээлэх хэрэгтэй.
<b>11</b>	<b>Цалин, урамшуулал</b>		
11.1	<b>Зарчим 11 (БХШБХ д 328)</b> Банкны цалин, урамшууллын бүтэц нь байгууллагын засаглал болон эрсдэлийн удирдлагыг дэмждэг байх хэрэгтэй.	Эрсдэлийн ажилтнуудын цалин, урамшууллын бодлого нь бусад ажилтнуудаас ялгаатай байгаагүй. Эрсдэлийг шаардлагатай түвшинд бууруулах, хангахад эрсдэлийн ажилтнуудыг идэвхжүүлэх хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлт байхгүй	Банк нь батлагдсан эрсдэлийн хязгаарууд (эрсдэлийн аппетитын мэдэгдэл) болон стратегийн хэрэгжилтээс хамаарсан цалин, урамшууллын бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Цалин, урамшууллын систем нь ашиг, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлсэн байх хэрэгтэй.
11.2	<b>Зарчим 1 (46) (БХШБХ д328)</b> ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллын стандарт ба түүний гүйцэтгэлийг банкны санхүүгийн тогтвортой байдал болон урт хугацааны стратегитай уялдуулан зохистой түвшинд тогтоох хэрэгтэй;		
11.3	<b>Зарчим 3 (77) (БХШБХ д328)</b> Цалин, урамшууллын хороо нь урамшууллын системд хангамжийг үнэлэхдээ банкны эрсдэлийн удирдлагын хороотой нягт ажилладаг. Эрсдэлийн хороо нь урамшууллын системээс хангагдаж буй хангамжууд нь эрсдэл, капитал, хөрвөх чадварын болон орлогын хугацаа, боломж зэргийг авч үзсэн эсэхийг судлах хэрэгтэй.		
<b>12</b>	<b>Мэдээллийн ил тод байдал ба тодруулга</b>		
12.1	<b>Зарчим 12 (БХШБХ д328)</b> Банкны засаглал нь өөрийн хувьцаа эзэмшигчид, хадгаламж эзэмшигчид, бусад холбоотой тал болон зах зээлийн оролцогчдод зохистой хэмжээнд ил тод байх хэрэгтэй.	Банк нь мэдээллийн ил тодыг зохицуулах дотоод бодлого, журмыг нэвтрүүлээгүй.	Банк нь мэдээллийн тодруулгын журмыг нэвтрүүлж, тайланг мэдээлэхээс өмнө хянаж хэрэгтэй.

### 3.4. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн дөрөвдүгээр бүлэг. Хөгжлийн банкны талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, хамтын ажиллагаанд хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:

Үнэлэх хэсэг: Дөрөв дүгээр бүлэг. Хөгжлийн банкны талаархи төрийн байгууллагын бүрэн эрх, хамтын ажиллагаа

- |                             |   |
|-----------------------------|---|
| Томьёолсон шалгуур үзүүлэлт | - Хөгжлийн банкны үйл ажиллагаанд оролцох төрийн байгууллагууд хангалттай ажилласан эсэх? |
|                             | - Хөгжлийн банкны өнөөгийн нөхцөл байдалд хүргэхэд нөлөөлсөн эсэх?                        |

Хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн дөрөвдүгээр бүлэг нь дараах агуулгатай 3 зүйлээс бүрдэнэ. Үүнд:

22 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх

23 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

24 дүгээр зүйл. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын

бүрэн эрх

Энэ бүлгийн хэрэгжилтэд үнэлгээ хийдээ зүйл бүрээр нь бус Хөгжлийн банк үүсгэн байгуулагдсан цагаас хойш гарсан эрх бүхий байгууллагын шийдвэрүүд тэдгээрийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээлэлд үндэслэн бүхэлд нь хийж гүйцэтгэлээ.

### *Төрийн байгууллагуудын гаргасан шийдвэрүүд*

Улсын Их Хурлаас Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталж байсан бол Засгийн газрын 2011 оны 151 тогтоолоор ХӨГЖЛИЙН БАНКНЫ дүрэм, бүтэц, зохион байгуулалтыг баталж, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн дагуу албан ёсоор 2011 оны 3 дугаар сарын 25-ны өдөр тус банк үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа нь эхэлснээс хойш 6 жилийн дараа буюу 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдөр хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн /2011 он/ 18.1.9-д “Хөгжлийн банкны зохистой засаглалын бодлого, журмыг тогтоож, хэрэгжилтэд хяналт тавих” гэж заасан ч ТУЗ-өөс 2016 оныг хүртэлх хугацаанд энэ талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байв.

УИХ-ын 2014 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх арга хэмжээний чиглэл”-ийн 3.37 -д “... Хөгжлийн банкны тухай хууль болон холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулж, өргөн мэдүүлэх”-ийг Засгийн газарт үүрэг болгосон ч тодорхой үр дүн гараагүй байна.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн /2017 он/ шинэчилсэн найруулга нь банкнаас зээл олгох, төсөл санхүүжүүлэх зарчмыг шинэчлэн, үйл ажиллагааны хүрээ өргөжих боломж нэмэгдэж, Монголбанк, Засгийн газрын зүгээс тавих хяналтын тогтолцоог шинэчилжээ.

Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл (цаашид “ҮАБЗ” гэх)-ийн 2012 оны 12 дугаар сарын 03-ны өдөр 28/20 дугаар зөвлөмжийн дагуу “Бодлогын зөвлөл” байгуулж, ҮАБЗ-ийн “зөвлөмжийг үндэслэн” уг зөвлөлөөс Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх “Бодлогын зөвлөлийн зөвлөмж”-ийг гаргаж, тэрхүү зөвлөмжийн дагуу төсөл, хөтөлбөрүүдийг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх чиглэл өгч эхэлснээс хойш тус банкны зээл олгох үйл ажиллагаа эрчимжиж эхэлсэн байна.

ҮАБЗ-ийн 2012 оны “Засгийн газрын үнэт цаасны талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газарт чиглэл болгосон 6 заалт бүхий 28/20 дугаар зөвлөмж гарснаас хойш ҮАБЗ-ийн 2014 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн “Засгийн газрын үнэт цаас арилжаалж бүрдүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тухай” Засгийн газарт чиглэл болгосон 8 заалт бүхий 19/10 тоот зөвлөмж гарч байжээ.

Монгол Улсын Засгийн газрын тус банктай холбоотой шийдвэрүүд:

Засгийн газраас Хөгжлийн банкны эрх зүйн орчинтой холбоотойгоор 2010 оноос эхлэн 2017 оны 02 дугаар сарын 10-ыг хүртэл хугацаанд банканд үүрэг болгосон, банкны үйл ажиллагаанд хамаарах нийт 196 тогтоол, тэмдэглэл гарсан. Үүнд:

- Банкны бүтэц, зохион байгуулалттай холбоотой - 13
- Банкны эх үүсвэр, үнэт цаас гаргахтай холбоотой - 19
- Банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөртэй холбоотой - 162
- Банкны үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын Ерөнхий сайдын захирамж, сайдын тушаал - 32

Засгийн газраас Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн дагуу 2017 оны 02 дугаар сарын 10-аас хойш 2021 оныг дуустал хугацаанд банкны үйл ажиллагаатай холбоотой нийт 34 тогтоол, тэмдэглэл гарсан. Үүнд:

- Банкны бүтэц, зохион байгуулалттай холбоотой – 16

- Банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөртэй холбоотой – 17
- Банкны үйл ажиллагаатай холбоотой Ерөнхий сайдын захирамж, тушаал –3

Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбоотой тогтоол, захирамж, тушаал /УИХ, Засгийн газраас бусад/

Өнгөрсөн хугацаанд холбогдох эрх бүхий байгууллагаас тус банкны үйл ажиллагаатай холбоотой 35 шийдвэр гарсан байна.

### **Төрийн байгууллагаас гаргасан шийдвэрүүдийн хэрэгжилт**

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг үндэслэн УИХ-аас баталсан “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 15 дугаар тогтоолоор дараах төсөл, хөтөлбөрүүдийг Хөгжлийн банкны санхүүжилтээр 2011 оноос хэрэгжүүлж эхлэхийг Засгийн газарт даалгаснаар томоохон гэх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх эхлэл тавигдсан. Үүнд:

- *УИХ-ын 2010 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоолоор баталсан "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр,*
- *УИХ-ын 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 32 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого",*
- *Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын 2010 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 45 дугаар тогтоолд заасан "Сайншанд" аж үйлдвэрийн цогцолбор,*
- *УИХ-ын 2008 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 47 дугаар тогтоолоор баталсан "Өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэйгөөр барих авто зам, эрчим хүчний барилга, байгууламжийн жагсаалт"*

Харин УИХ-аас дээр дурдсанаас өөрөөр Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан шаардлагын дагуу тус банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг баталжээ.

Улсын Их Хурлын 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 52 дугаар тогтоолоор эдийн засгийн өсөлтийг хангах, урт хугацааны хөгжлийн хөрөнгө оруулалт хийх, экспортыг дэмжих бодлогыг санхүүжүүлэх зорилгоор дунд, урт хугацааны 5 тэрбум хүртэлх ам.долларын Засгийн газрын үнэт цаасыг 2012-2014 онуудад үе шаттайгаар олон улсын зах зээлд арилжаалахыг Засгийн газарт зөвшөөрч, уг хөрөнгөөр хэрэгжүүлэх салбар чиглэлийг тодорхойлсон байна<sup>10</sup>.

Уг тогтоолын 2 дахь заалтад тухайн хөрөнгийг нийгмийн халамжийн аливаа үйлчилгээ болон улсын төсвийн орлогын дутагдлыг нөхөхөөс бусад “эрдэс баялаг, зам, тээвэр, эрчим хүч, харилцаа холбоо, барилга, банк санхүү, аж үйлдвэрийн салбар”-т хэрэгжүүлэх эдийн засгийн үр ашиг бүхий томоохон төслүүдэд зарцуулахыг чиглэл болгосон байна.

Гэвч тогтоолын дээрх заалт нь хэт ерөнхийлсөн, нөгөө талаас энэ салбарын хамрах хүрээний хувьд өргөн, олон салбарыг хамарсан, уг салбарын нэрээр л бол ямар ч төсөл, хөтөлбөр, төсвийн шинж чанартай арга хэмжээг санхүүжүүлэх бололцоог олгосон байна.

ҮАБЗ-ийн зөвлөмжид эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх, үр ашиг, эргэн төлөгдөх баталгаа бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн төсөл, хөтөлбөрүүдийг тэргүүн ээлжид санхүүжүүлэхийг зөвлөсөн.

ҮАБЗ-ийн 2012 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Засгийн газрын үнэт цаасны талаар авах зарим арга хэмжээний тухай” 28/20 дугаар зөвлөмжид үнэт цаастай холбогдуулан УИХ, Засгийн газраас хэрэгжүүлэх ажлын ерөнхий чиглэлүүд тусгагдсан байна.

<sup>10</sup> Монгол Улсын Их Хурлын 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 52 дугаар тогтоол

ҮАБЗ-ийн “Засгийн газрын үнэт цаасны талаар авах зарим арга хэмжээний тухай” зөвлөмжид УИХ, Засгийн газар, зөвлөлийн Нарийн бичгийн даргад өгсөн зөвлөмжийн гол агуулга нь дараах байдалтай байсан<sup>11</sup>. Үүнд:

Монгол Улсын Их Хуралд (2 заалт бүхий):

- Бүрдүүлсэн хөрөнгийн зарцуулалт, эргэн төлөлт, тавих хяналтад шаардагдах нэмэлт эрх зүйн орчныг УИХ-ын намрын чуулганд багтаан бүрдүүлэх.
- Засгийн газрын үнэт цаасны зарцуулалт, төслийн сонголт, хэрэгжүүлэлтэд тавих хяналтыг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд, үнэт цаасны үйлчилгээ, хүүгийн болон үндсэн төлбөрийг барагдуулах, түүнийг төсвийн эх үүсвэртэй уялдуулахад тавих хяналтыг УИХ-ын Төсвийн байнгын хороонд тус тус хариуцуулах;

Монгол Улсын Засгийн газарт (6 заалт бүхий):

- Сонгосон төсөл, хөтөлбөрт олгох санхүүжилтийн асуудлыг Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэж, УИХ-ын даргад танилцуулах;
- Эдийн засгийн бие даасан, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн үр ашиг, эргэн төлөгдөх баталгаа бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн нэг төсөл хөтөлбөрт олгох санхүүжилтийн нийт хэмжээний 1/3-ээс хэтрэхгүй байх;
- Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор мэргэжлийн болон салбар хариуцсан байгууллагын төлөөлөл, бие даасан шинжээчдийг оролцуулсан “Бодлогын зөвлөл байгуулах”, төсөл, хөтөлбөрийн сонголтын ил тод байдлыг хангах, иргэний хяналтын дор хэрэгжүүлэх, Засгийн газрын бодлогын залгамж чанарыг хадгалах;

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн даргад (2 заалт бүхий):

- Хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, Зөвлөлийг мэдээллээр хангах, хөрөнгийн эх үүсвэрийн зарцуулалт, ашиглалтад хууль хяналтын байгууллагын ажлын уялдааг хангаж ажиллах (АТГ, ТЕГ болон бусад) зэрэг үндсэн асуудлаар зөвлөмж гаргаж байжээ.

Зээлийн гол шаардлага нь “Эдийн засгийн бие даасан, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн, үр ашиг, эргэн төлөгдөх баталгаа бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн төсөл, хөтөлбөрүүдийг тэргүүн ээлжид санхүүжүүлэхэд оршиж байсан.

Түүнчлэн тогтоолын Засгийн газарт зөвлөмж болгосон хэсэгт үнэт цаасыг арилжаалах замаар бүрдүүлсэн хөрөнгийн эх үүсвэрээс төсөл, хөтөлбөр сонгон санхүүжүүлэх асуудлыг тухай бүр Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэж, УИХ-ын даргад бичгээр танилцуулж байх гэсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор Засгийн газрын үнэт цаас борлуулж, босгосон хөрөнгөөр хэрэгжүүлэх “бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг сонгох шалгуур үзүүлэлтийг тогтоох, үүсэж болох эрсдэлийг тооцох, эрсдэлийн удирдлагаар хангах” үүрэг бүхий “Бодлогын зөвлөл” байгуулагдсан.

ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрээр байгуулагдсан Бодлогын зөвлөлийн бүрэлдэхүүнд бие даасан шинжээч ажиллуулах, төсөл, хөтөлбөрийн сонголт ил тод, хариуцлагатай, цаг хугацаандаа хэрэгжиж байх зарчмыг иргэний хяналт дор хэрэгжүүлэх зөвлөмж хэрэгжээгүй байна.

Бодлогын зөвлөл нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тогтоол батлагдаж байсан ч бидний судалснаар бодлогын зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой үр дүнг үнэлэх хангалттай баримт материал хангалтгүй байсан.

Бодлогын зөвлөл нь ажиллах журам, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байх, үүсэж болох эрсдэлийг урьдчилан тооцож, үнэлгээ гаргах бүхий дэд ажлын хэсэг, дотоод, гадаадын шинжээчдийн багийг байгуулж ажиллуулах, төсөл, хөтөлбөр бүрд шалгуур үзүүлэлтийн дагуу

<sup>11</sup> Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2012 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 28/20 дугаар зөвлөмж

эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, байнгын төлөвлөгөөтэйгөөр хяналт тавих, хөтөлбөрийн хэрэгжилт, санхүүжилтийн хуваарьт хяналт тавьж ажиллах үүргийг хүлээж байсан боловч хэрэгжсэн гэж үзэх нотлох баримт алга байна.

Бодлогын зөвлөлийн хуралдааны шийдвэрлэх хэсэгт дэмжсэн салбар болоод тухайлан зарим аж ахуйн нэгжийн төсөлд санхүүжилт олгохыг дэмжсэн шийдвэрийг гаргаж ирсэн. Тухайлбал:

Гудамж төсөл, Хурдны зам, Тавантолгойн нүүрсний орд газарт цахилгаан станц барих, Шинэ төмөр зам барих томоохон төсөл болон ААН-ийн хувиар “Эрэл” ХХК-ийн БҮК-1 төсөл, “МИАТ” ТӨХК-ийн Голомт банк хооронд байгуулсан агаарын хөлгийн худалдан авах зээлийн төлбөр, ТОСК, төмөрлөгийн үйлдвэрлэлийг дэмжиж “Мон-Лаа” ХХК, “Бэрэн групп” ХХК, цементийн үйлдвэрлэлийг дэмжихэд “Монголын алт” ХХК, “Монполимет” ХХК-д, эрүүл мэндийн чиглэлээр “Энхийн шүүдэр ХХК-ийн төслийг санхүүжүүлэх зөвлөмж гарсан.

Бодлогын зөвлөлийн зөвлөмжийн тогтоох хэсэг буюу зөвлөмж болгох хэсэг нь ҮАБЗ-ийн 28/20 дугаар зөвлөмжийг үндэслэн гэж бичигдсэн бөгөөд зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудалд үндэслэсэн тухай дурдсан зүйлгүй байна.

Харин зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн “шийдвэрлэх хэсэг” нь төсөл, хөтөлбөрүүдийг зохих журмын дагуу боловсруулан Засгийн газарт оруулахыг зөвлөлийн орлогч дарга буюу хариуцсан (ЭЗХЯ) сайдад даалгасан хэлбэртэй байжээ.

Бодлогын зөвлөлийн хуралдаанаас зөвлөмж гарган шаардлагатай гэж үзсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг даалгахдаа зохих журмын дагуу төслийн баримт бичгийг боловсруулан Засгийн газарт оруулж хэлэлцүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг холбогдох сайд нарт үүрэг болгож байсан байна.

Бодлогын зөвлөлийн дэмжлэгтэй болон Засгийн газрын шийдвэрийг үндэслэн олгосон зээлийн хувьд Хөгжлийн банк ямар нэг эрсдэл хүлээгээгүй учраас хүлээх хариуцлага сул, хуульд заасан зээлийн шалгуур үзүүлэлтэд тавих хяналт хангалтгүй байсан.

Хөгжлийн банкнаас олгосон зээл олголт, төлөлтийн нэгтгэсэн мэдээллээс үзэхэд Бодлогын зөвлөлийн зөвлөмжид нэр дурдаж, Засгийн газрын шийдвэрээр дараах зээлдэгчдэд зээл олгосон. Үүнд:

**А. Үлдэгдэлтэй “ШУУД” зээлийн багцын хувьд:**

- “Зөвлөмж I”-ийн хүрээнд ЭХЯ-наас захиалж, хариуцсан “Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн 450 МВт хүчин чадалтай цахилгаан станц барих төсөл”
- “Зөвлөмж III”-ийн хүрээнд УУЯ, БХБЯ-наас захиалж, хариуцсан ТОСК БУ-1, ТОСК БУ-2, Бэрэн групп ХХК, Эрэл ХХК, Мон Лаа ХХК
- “Зөвлөмж V”-ын хүрээнд УУЯ, ЭЗХЯ-наас захиалж, хариуцсан “Мак цемент” ХХК, “Монполимет” ХХК-д тус тус олгосон.

**Б. Хаагдсан “ШУУД” зээлийн багцын хувьд:**

- “Зөвлөмж III”-ын хүрээнд ТОСК ТӨҮГ-ын хэрэгжүүлсэн Увс, Архангай, Сэлэнгэ, Дархан-Уул аймагт хэрэгжсэн 1000 айл орон сууцны хөтөлбөр

**В. Арилжааны банкуудаар “ДАМЖУУЛАН” хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн зээлийн хувьд:**

- “Зөвлөмж II”-ын хүрээнд ҮХААЯ-наас захиалж, хариуцсан ХАА, хөнгөн үйлдвэрийн ноос, ноолуур, сүү, хүлэмж болон оёдлын салбарын төслийг Голомт банкаар дамжуулан олгосон.
- “Зөвлөмж V”-ын хүрээнд ҮХААЯ-наас захиалж, хариуцсан “Экспортыг дэмжих, импортыг орлох 2 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий үйлдвэрлэлийн 888 төсөл”-ийг Голомт, Капитал, Капитрон, Төрийн, УБХБ, ҮХОБ, Хаан, Хас, ХХБ-аар тус тус дамжуулан олгосон.

- **“Зөвлөмж V”-ын** хүрээнд Голомт банкаар дамжуулан “Энхийн шүүдэр” ХХК-ийн “Дуслын шингэний үйлдвэрийн төсөл”
- **“Зөвлөмж V”-ын** хүрээнд ҮХААЯ-наас захиалж, хариуцсан “Экспортыг дэмжих, импортыг орлох 2 тэрбум төгрөгөөс доош өртөг бүхий үйлдвэрлэлийн 888 төсөл”-ийг ЖДҮХС-арилжааны банкууд болох Голомт, Капитал, Капитрон, Төрийн, УБХБ, ҮХОБ, Хаан, Хас, ХХБ, Чингис хаан банкаар тус тус дамжуулан зээл олгосон.

**Г. Банкны эх үүсвэрээр “ТӨСВӨӨС ЭРГЭН ТӨЛӨГДӨХ” нөхцөлтэйгөөр 2012-2017 онуудад хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний /Засгийн газарт шилжүүлсэн/ хувьд:**

- **“Зөвлөмж I”-ийн** хүрээнд ЗТХЯ-наас захиалан хэрэгжүүлсэн “Шинэ төмөр зам төсөл, ЭЗХЯ, НЗДТГ-НХОГ-аас захиалж хамтран хэрэгжүүлсэн Нийслэл хот, хот орчмын гудамж, замын шинэчлэлийн төслүүдэд тус тус дамжуулан олгосон.
- **“Зөвлөмж II”-ийн** хүрээнд зээл ЗТХЯ, ЭХЯ, БХБЯ-наас захиалж, хариуцсан зарим аймгийн төв, улсын чанартай орон нутаг дах авто зам, нийслэлийн бүс, хот орчмын орон сууцны хорооллын дэд бүтэц, цахилгаан дамжуулах шугам сүлжээ барьж байгуулах төсөл.

Бодлогын зөвлөлийн зөвлөмжид үндэслэж Засгийн газраас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагыг Засгийн газрын тогтоолд шууд заасантай холбоотойгоор Хөгжлийн банкны үйл ажиллагааг хууль, журмын дагуу явуулахад зарим хүндрэл гарч, зээлийн үндсэн зарчим болох зээлийн судалгаа хийж эрсдэл, үр ашгийг тодорхойлох, хөгжлийг дэмжих үр ашигтай, эрсдэлгүй, эргэн төлөгдөх баталгаа бүхий төсөл, хөтөлбөрийг болон хэрэгжүүлэгчийг сонгон санхүүжүүлэх үр нөлөөтэй хөрөнгө оруулалтын тогтолцоо тухайн үед үйлчилж чадаагүй.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 3 дугаар зүйлийн 3.6-д "Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй" гэж заасныг үндэслэн гаргасан Засгийн газрын тогтоолд нэр заасан компаниудтай Хөгжлийн банк шууд гэрээ байгуулж байжээ.

ҮАБЗ-ийн 2014 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 19/10 дугаар зөвлөмж нь өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн хангалтгүй байдлыг хэлэлцэж, Засгийн газрын Бодлогын зөвлөлийг татан буулгах нь зүйтэй гэж үзсэн.

ҮАБЗ-ийн Ажлын албанаас хийсэн шалгалтаар өмнөх зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, тухайлбал гол асуудлаар буюу өмнөх зөвлөмжийн 1.1-ийн үнэт цаасны зарцуулалт, эргэн төлөлт, тавих хяналтад шаардагдах нэмэлт эрх зүйн орчныг бүрдүүлэх гэсэн УИХ-д даалгасан заалт хэрэгжээгүй байна.

Түүнчлэн 2.2-ын эдийн засгийн бие даасан, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн үр ашиг, эргэн төлөгдөх баталгаа бүхий төсөл, хөтөлбөрт бус хөрөнгийн нийт 50.0 хувийг ойрын хугацаанд эргэн төлөгдөх баталгаагүй төслүүдэд зарцуулсан, 2.4-ийн Засгийн газрын эрсдэлийг багасгах, хөрөнгө оруулалтын орчныг дэмжих үүднээс нэг төсөл, хөтөлбөрт хийх санхүүжилт нь тухайн төслийн нийт санхүүжилтийн 1/3-ээс хэтрэхгүй байх гэсэн заалтыг баримтлаагүй байсан тухай зөвлөлийн хуралдааны тэмдэглэлд үлджээ.

ҮАБЗ-ийн Ажлын албанаас хуралдаанд танилцуулсан дүн, хэлэлцсэн асуудал, оруулсан зөвлөмжийн төслийг хэлэлцэн шийдвэрлэсэн Зөвлөлийн зөвлөмжийн 2.7 дахь хэсэгт Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2012 оны 28/20 дугаар зөвлөмжийн 2.4-т заасныг биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох тухай, 2.8 дахь хэсэгт Хөгжлийн банкны үнэт цаас гаргах, арилжих, зарцуулах, зээл олгох үйл ажиллагаанд хяналт тавьж, уг банкнаас гаргасан үнэт цаасны арилжаа, зарцуулалт, эргэн төлөлт, эх үүсвэрийн талаар Улсын Их Хурал болон ҮАБЗ-д тухай бүрд танилцуулж байх тухай зааж өгсөн байна.

ҮАБЗ-ийн 19/10 дугаар зөвлөмж нь 2014 оны 05 дугаар сарын 06-ны өдөр гарч, Монгол Улсын Засгийн газарт Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2012 оны 28/20 дугаар зөвлөмжийн 2.5-д заасан Бодлогын зөвлөлийг татан буулгах тухай байсан ч ҮАБЗ гарснаас хойш 14 хоногийн

дараа буюу Засгийн газраас байгуулсан Бодлогын зөвлөлийн 5 дахь удаагийн зөвлөмж нь 2014 оны 05 дугаар сарын 20-ны өдөр гарсан байна.

Бодлогын зөвлөлийн дээрх зөвлөмжөөр нийт 4 аж ахуйн нэгжийн төсөл, экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийн 579 төсөл, арга хэмжээг дэмжихээр шийдвэрлэсэн байна.

ҮАБЗ-ийн зөвлөлийн Засгийн газрын үнэт цаасны талаар авах зарим арга хэмжээний тухай, үнэт цаас арилжаалж бүрдүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тухай өмнөх болон дараагийн зөвлөмжийн талаар ил тод, нээлттэй мэдээлэл алга байна.

Засгийн газрын тогтоолуудад төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх болон хэрэгжүүлэх байгууллага, олгох мөнгөн дүн, хугацааг шууд заасан, түүнчлэн эрсдэл, үр ашгийг нарийвчлан судалж тодорхойлоогүй төсөл, арга хэмжээ их хэмжээгээр баталж байжээ.

Монгол Улсын Хөгжлийн банкны хуулийн шинэчлэлийн зорилтод нийцсэн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх төрийн шийдвэр амжилттай хэрэгжээгүй.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай анхны хууль (2011 он) батлагдсанаас хойш 2017 оны 2 дугаар сард хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан ч түүнээс хойш хуулийн хэрэгжилттэй холбогдуулан үр дагаврын үнэлгээ, төлөв байдлын судалгаа албан ёсоор хийгдээгүй байна.

Хуулийн шинэчилсэн найруулга нь тус банкны эрх зүйн байдлыг илүү тодотгож өгсөн ч өмнөх хуулийн гол заалт болох хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийн жагсаалтыг Улсын Их Хурлын хаврын чуулганаар батлуулж байх заалтыг хасаж, харин УИХ болон Засгийн газар төсөл, хөтөлбөрийг тусгайлан батлахгүй байхаар хуульчилжээ.

Хөгжлийн банкны эрхлэх үйл ажиллагааны хүрээг өргөжүүлж шинэчлэхдээ төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн байх, банк өөрийн санхүүжилт олгох шийдвэрийг бие даан гаргах зохицуулалт тусгасны дээр банкны хяналтын тогтолцоо, үйл ажиллагааны хязгаарлалтыг шинэчлэн тогтоож өгсөн байна.





**23 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх**

23.1.2 дахь заалт “Хөгжлийн банкны санхүүгийн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг баталж, түүний үйл ажиллагаанд хийсэн дүгнэлтийн хамт Монгол Улсын Их хуралд хүргүүлэх”

**25 дугаар зүйл. Хөгжлийн банканд тавих хяналт**

25.1.Хөгжлийн банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам, активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журмыг санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг харгалзан Монголбанк батална.

**28 дугаар зүйл. Хөгжлийн банкны үйл ажиллагаанд тавих хязгаарлалт**

28.1.1.зээл, баталгаа, зээлтэй адилтгах актив хөрөнгийн нийт дүн нь өөрийн хөрөнгийг 30 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй бөгөөд түүний хэмжээг Монголбанк тогтооно.

28.1.2.Монголбанк нь том зээлдэгчийг тодорхойлох, түүнд олгох зээлийн дээд хэмжээ болон нийт хэмжээг тогтоох, тайлагнах журмыг батална. Нэг зээлдэгч болон түүнд холбогдох этгээдэд олгох зээлийн нийт хэмжээ нь Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийг 8 дахин нэмэгдүүлсэн хэмжээнээс хэтрэхгүй байна.

### 3.5.Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн тавдугаар бүлэг. Хөгжлийн банкны хяналтын тогтолцоо, үйл ажиллагааны хязгаарлалтад хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:

Үнэлэх хэсэг: Тав дүгээр бүлэг. Хөгжлийн банкны хяналтын тогтолцоо, үйл ажиллагааны хязгаарлалт

- Томьёолсон шалгуур үзүүлэлт
- Хяналт шалгалтын тогтолцоо бүрэн дүүрэн эсэх?
  - Олон улсын сайн туршлагад нийцсэн эсэх?
  - Үр дүнд хүрч байсан эсэх?

Хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн тавдугаар бүлэг нь дараах агуулгатай 4 зүйлээс бүрдэнэ. Үүнд:

25 дугаар зүйл. Хөгжлийн банканд тавих хяналт

26 дугаар зүйл. Хөгжлийн банкны дотоод аудит

27 дугаар зүйл. Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт

28 дугаар зүйл. Хөгжлийн банкны үйл ажиллагаанд тавих хязгаарлалт

Энэ бүлгийн хэрэгжилтэд үнэлгээ хийдээ зүйл бүрээр нь бус Хөгжлийн банк үүсгэн байгуулагдсан цагаас хойш гарсан эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлсэн хяналт шалгалтууд тэдгээрийн тайлангаас өгсөн дүгнэлт зөвлөмжүүдийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээлэлд үндэслэн бүхэлд нь хийж гүйцэтгэлээ.

#### УИХ, Монголбанк, Засгийн газар, Үндэсний аудитын газраас хийсэн хяналт, үр дүн

Монгол Улсын Хөгжлийн банк үүсгэн байгуулагдсанаас хойших хугацаанд тус банкны үйл ажиллагаанд олон удаагийн шалгалт хийгджээ.

Өнгөрсөн хугацаанд ХӨГЖЛИЙН БАНКНЫ үйл ажиллагаанд УИХ /2022/, Засгийн газар /2016, 2019/, Монголбанк /2018, 2021/, УАГ /2021, 2023/, Монголбанк, Сангийн яамны хамтарсан /2020/, PWC /2018/ зэрэг эрх бүхий байгууллагуудаас хийгдсэн голлох хяналт шалгалтаар нийт 170 гаруй зөрчилтэй асуудал тэмдэглэгдэж, хяналт шалгалтын дүнд үндэслэсэн нийт 192 дүгнэлт бичиж, зөрчил болон эрсдэлийг арилгах нийт 237 зөвлөмж өгсөн байна.

Олон удаагийн давтамжтай болон эрх бүхий байгууллагуудын давхардсан хяналт шалгалтын үйл ажиллагааны үр нөлөөт байдал хангалтгүй байсан.

Эрх бүхий байгууллагуудын хяналт шалгалтын тайланд албан ёсоор бичигдсэн зөвлөмжөөс гадна уг тайланд дурдсан алдаа дутагдлыг зөвлөмжөөр хүлээн зөвшөөрч засан сайжруулах чиглэлээр тоон агуулгад шилжүүлэн авч үзвэл нийт 450 гаруй болсон.

Хүснэгт 21. Хамрагдсан шалгалтууд

Д.д	Шалгалт хийсэн эрх бүхий байгууллага	Он	Хяналт шалгалтаас өгсөн зөвлөмж, дүгнэлтийг баталгаажуулсан баримт бичиг	Баримт бичгийн огноо, дугаар
1	PWC аудит	2018	Дэлгэрэнгүй шинжилгээний тайлан	2018.04.12

2	Монголбанк		Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал	2018.11.27 №А-290
3	Үндэсний аудитын газар	2019	МУ-ын Ерөнхий аудиторын тушаал	2019.05.03 №А/41
4	Засгийн газар	2019	МУ-ын Засгийн газар албан тоот	2019.05.03 №ХЭГ/Н-30
5	Үндэсний аудитын газар	2021	МУ-ын Ерөнхий аудиторын тушаал	2022.03.15 №07/631
6	Монголбанк	2020	Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал	2021.12.13 №А-336
7	Улсын Их Хурал	2022	УИХ-ын даргын захирамж	2022.01.31 20 тоот
8	УИХ-ын хянан шалгах түр хороо	2023	Шалгалтын тайлан	2023 оны 3 дугаар сарын 16-ны өдөр нийтлэгдсэн. <a href="https://www.parliament.mn/files/c02d669c1686437a83235768cd005000/?d=1">https://www.parliament.mn/files/c02d669c1686437a83235768cd005000/?d=1</a>
9	Үндэсний аудитын газар		МУ-ын Ерөнхий аудиторын тушаал	2023.02.15 №А/158

Хөгжлийн банкны үйл ажиллагаанд эрх бүхий байгууллагаас гүйцэтгэсэн хяналт шалгалт болон аудитын хуулийн этгээдийн санхүүгийн тайланг баталгаажуулах аудитын үр нөлөө сул байсан.

Хөгжлийн банкны үйл ажиллагаанд эрх бүхий байгууллага, хөндлөнгийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

*Хүснэгт 22.Хяналт шалгалтуудаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилт*

<b>Бүрэн хэрэгжсэн 101 буюу 26.2 хувь, үүнээс:</b>	<b>Хэрэгжээгүй 36 буюу 9.3 хувь, үүнээс:</b>
<i>Дотоод үйл ажиллагаатай холбоотой 23, Засаглах тогтолцооны ажил, үйлчилгээтэй холбоотой 15, Зээлийн орчин, тухайлсан зээлтэй холбоотой 17, Мөнгөн хөрөнгө, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлагатай холбоотой 28, Эрсдэлийн удирдлагатай холбоотой 16, Санхүүгийн тайлагнал, НББ-тэй холбоотой 2.</i>	<i>Засаглах тогтолцооны ажил, үйлчилгээтэй холбоотой 14, Зээлийн орчин, тухайлсан зээлтэй холбоотой 4, Мөнгөн хөрөнгө, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлагатай холбоотой 3, Эрсдэлийн удирдлагатай холбоотой 15,</i>
<b>Хэрэгжилт хангалтгүй 86 буюу 22.3 хувь, үүнээс:</b>	<b>Хэрэгжих шатанд буюу үргэлжилж буй 162 буюу 42.1 хувь үүнээс:</b>
<i>Дотоод үйл ажиллагаатай холбоотой 9, Засаглах тогтолцооны ажил, үйлчилгээтэй холбоотой 10, Зээлийн орчин, тухайлсан зээлтэй холбоотой 30, Мөнгөн хөрөнгө, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлагатай холбоотой 6, Эрсдэлийн удирдлагатай холбоотой 25, Санхүүгийн тайлагнал, НББ-тэй холбоотой 6.</i>	<i>Дотоод үйл ажиллагаатай холбоотой 15, Засаглах тогтолцооны ажил, үйлчилгээтэй холбоотой 17, Зээлийн орчин, тухайлсан зээлтэй холбоотой 44, Мөнгөн хөрөнгө, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлагатай холбоотой 16, Эрсдэлийн удирдлагатай холбоотой 59, Санхүүгийн тайлагнал, НББ-тэй холбоотой 11.</i>
<i>Эрх бүхий байгууллагын тухайлсан шалгалт, аудитын хуулийн этгээдийн баталгаажуулах аудитын "үр нөлөө" нь дараагийн шатандаа "АХИЦ ДЭВШИЛ"-ээр үнэлэгдэж байх ёстой. Гэвч үр нөлөө хангалттай түвшинд байж чадаагүй, нөгөө талаас дурдсан байгууллагуудын тусгайлсан, нарийвчилсан, өргөтгөсөн, хэсэгчилсэн зэрэг шалгалтуудын мөрөөр, мөн давтан хийсэн болон ээлжит хяналт шалгалтын үеэр өмнөх шалгалтын илрүүлэлт, алдаа зөрчлийг хэрхэн арилгасан талаар үндсэндээ хянаж байгаагүй, энэ талаар учир холбогдолтой, бодит нөхцөл байдлыг илтгэх хангалттай "НОТЛОХ ЗҮЙЛ" олддоогүй болно. Эцэст нь ХӨГЖЛИЙН БАНКны хууль тогтоомжид заасан үйл ажиллагаанд тавих төрийн хяналтын чиг үүрэг хангалтгүй хэрэгжиж ирсэн гэсэн дүгнэлтэд хүрч байна. Эрх бүхий байгууллагаас гүйцэтгэсэн хяналт шалгалтын мөрөөр арга хэмжээг эртчилэн аваагүйгээс өнөөгийн нөхцөл байдалд хүргэсэн байна.</i>	

Тухайлбал, эрх бүхий байгууллагын гүйцэтгэлийн хяналт шалгалт, хөндлөнгийн хуулийн этгээдийн баталгаажуулах аудитын мөрөөр давтан хийх үе шатны ажлын гүйцэтгэл, түүнд суурилсан ахиц дэвшлийг үнэлэх, нөлөөллийг тооцох ажил хангалтгүй байсан.

Хөгжлийн банкны дотоод хяналтын тогтолцооны хүрээнд Монгол Улсын хууль тогтоомж, санхүүгийн удирдлагын үр ашиг, үр нөлөөтэй байдал, хэмнэлтийн горим зөрчсөн тохиолдол гарч байсан ч тухай бүр нь таслан зогсоон шийдвэртэй арга хэмжээг авч чадаагүй.

Энэ байдал нь дотоод хяналтын тогтолцооны үйлчлэл сул, эрх бүхий байгууллага хяналт шалгалтынхаа мөрөөр илэрсэн зөрчил, алдаа дутагдлыг таслан зогсоох, засан залруулж, шийдвэрлэх үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн.

Хөгжлийн банкны зээлийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаанд эрх бүхий байгууллагаас үе шаттай хяналт, шалгалт хийж, илэрсэн алдаа зөрчлийг арилгах талаар санал, зөвлөмж өгч, хуулийн байгууллагуудаар хянуулах тодорхой саналыг өгч ирсэн ч илэрсэн асуудлаар тухай бүр нь Хөгжлийн банк нь эдгээр алдаа, зөрчлийг арилгуулахаар хууль хяналтын байгууллагад албан ёсоор хандаж, шийдвэрлүүлэх асуудлыг орхигдуулсан.

Хөгжлийн банкны үйл ажиллагаанд эрх бүхий байгууллагаас үе шаттай хяналт, шалгалтуудын талаар дурдвал дараах байна.

### **Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 36 дугаар тогтоолоор байгуулсан ажлын хэсгийн шалгалт**

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 36 дугаар тогтоолоор байгуулсан ажлын хэсгийн шалгалтаар Монгол Улсын Хөгжлийн банкны татан төвлөрүүлсэн эх үүсвэр, төслийн сонгон шалгаруулалт, төслийн санхүүжилтийн зарцуулалт болон хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, цаашид учирч болзошгүй эрсдэлд үнэлэлт, дүгнэлт өгөхөд оршиж байсан.

Ажлын хэсэг дараах асуудлыг хөндсөн байна. Үүнд:

- *Монгол Улсын Засгийн газарт 8;*
- *Хууль, эрх зүйн хүрээний нийцэл, тэдгээрийн хүрээнд шийдвэрлэвэл зохих асуудлаар 8;*
- *Монгол Улсын Хөгжлийн банканд тусгайлан 24;*
- *ХӨГЖЛИЙН БАНКны Актив, пассивын удирдлагын хороонд 11;*
- *Зээлийн хороонд 2;*
- *Эрсдэлийн удирдлагын хороонд 10;*
- *Эдгээрийн хороодын хамаарал бүхий асуудлыг нэгтгэн 6 чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн нийцлийг хангаж ажиллах;*
- *Шалгалтын дүнд үндэслэн хуулийн хяналтын байгууллагад чиглэл болгон татан төвлөрүүлсэн хөрөнгийн ашиглалт, үнэт цаас гаргалт, тухайлсан зээл, санхүү хөрөнгийн захиран зарцуулалт, дотоод үйл ажиллагаатай холбоотой 21 асуудлаар нийт 703.6 тэрбум төгрөг болон 315.2 сая ам.долларын үнийн дүн бүхий ажил, үйлчилгээг хянуулж шийдвэрлүүлэх асуудлыг гаргаж ирсэн байна.*

Шалгалтын дүнг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, үр дүнг олон нийтэд мэдээлж ажиллан, банкны тухайн үеийн удирдлагууд болон төрийн холбогдох байгууллагуудад үүрэг өгч байсан ч уг тайлан нууцын зэрэглэлд шилжсэнээр ач холбогдлыг бууруулсан бол 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн “Төрийн нууцад хамаарах мэдээллийг ил болгох тухай” 114 дүгээр тогтоолын үйлчлэлээр ил болсон.

Энэхүү шалгалт нь Хөгжлийн банканд хийсэн өргөн хүрээний анхны томоохон шалгалт байсан гагцхүү тухай үед нууцалснаар /5 жил илүү хугацаанд/ хяналт шалгалтын үр дүнд Хөгжлийн банкны үйл ажиллагаа хэвийн явагдах анхны шаардлага хангагдах байсан.

Уг шалгалтын мөрөөр Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны 49 дүгээр тэмдэглэлээр улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Хөгжлийн банкнаас олгосон зээл болох 3.0 их наяд төгрөгийн дүн бүхий 371 төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах чиглэл өгөгдөж, Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 69 дүгээр тогтоолоор шалгалттай холбоотой арга хэмжээг анх удаагаа авч хэрэгжүүлж эхэлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлээр Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлж, Засгийн газрын 2016 оны 219 дүгээр тогтоолоор Засгийн газарт шилжүүлсэн нийт 3.1 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 348 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хянах үүрэг өгсөн ч төсвийн ерөнхийлөн захирагчдын Нарийвчилсан хяналт шалгалтын материалаас үзэхэд “үр нөлөөт” байдал хангалттай түвшинд хүргэж тайлагнаагүй, төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн хөрөнгийн зарцуулалт, түүний үр ашиг, үр өгөөж, үр дүнгийн талаас асуудлыг хөндөөгүй байсан.

Хууль тогтоомжийн зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тодорхой дүгнэлт гараагүй байна.

Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны 19 дүгээр тэмдэглэлээр Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хийсэн ээлжит шалгалтын дүнгийн талаар Засгийн газрын гишүүдэд танилцуулж, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар шийдвэрийн төсөл боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, газар дээрх шалгалтын тайлангаар цаашид авах арга хэмжээний санал /37/-ыг тодорхойлж, хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтуудад даалгасан.

#### **Монгол Улсын Засгийн газраас байгуулсан ажлын хэсэгт:**

Хөгжлийн банкны тухай хуулийн зарим заалтууд зөрчигдсөнийг тогтоосон тул Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хэрэг нээх нөхцөл бүрдсэн гэдгийг тэмдэглэсэн;

#### **Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал:**

Хөгжлийн банкны зээлийн орчин, зээлдэгчийн зээлийн ашиглалт, санхүү, аж ахуй, дотоод үйл ажиллагаа, мөнгөн хөрөнгийн удирдлага, эх үүсвэрийн ашиглалт, үнэт цаас гаргалт, ТУЗ-ийн зохион байгуулалт, мэдээ тайлан гаргалт, тайлагналын ил тод байдал зэргээр нийт 62 асуудлыг хөндсөн;

#### **Хөгжлийн банкнаас олгосон зээлд илэрсэн зөрчил:**

Нийт 8 зээлдэгчид олгосон зээлийн шийдвэрлэлт, ашиглалт, зарцуулалт, эргэн төлөлт, барьцаа хөрөнгийн асуудлыг тусгайлан авч үзэж зөрчилтэй асуудлыг тайланд дэлгэрэнгүй байдлаар тусгасан;

#### **Цаашид авах арга хэмжээний санал:**

Газар дээрх шалгалтын мөрөөр нийт 37 асуудлаар хэрэгжүүлэх арга хэмжээний санал гаргаж Засгийн газрын 2019 оны 169 дүгээр тогтоол гарчээ.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэл /Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Хөгжлийн банкнаас 2012-2016 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ/-ээр өгсөн үүргийн хэрэгжилт хангалтгүй, үр нөлөөтэй байж чадаагүй байна.

Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу зээлд хамрагдсан буюу хариуцсан Төсвийн ерөнхийлөн захирагчдын салбарт хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд нарийвчилсан шалгалт хийсэн гэх ирүүлсэн танилцуулга, баримт материалд үндэслэн үр нөлөөт байдлыг хянан үзсэн.

Хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт хийж бичсэн танилцуулгыг ЗГХЭГ-т тухай бүр хүргүүлж байсан ч хяналт шалгалтын материалын агуулгаас үзэхэд үр нөлөөт байдал хангалттай түвшинд хүрсэн эсэхийг тайлагнаагүй, төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн хөрөнгийн зарцуулалт, түүний үр ашиг, үр өгөөж, зориулалт, үр дүнгийн байдал талаас дорвитой асуудал хөндөөгүй, илрүүлсэн буюу хууль тогтоомжийн зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тодорхой дүгнэлт санал аль ч тайланд бичигдээгүй байжээ.

*“Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор” /Цагдаагийн байгууллага хянаж байсан гэх боловч тодорхойгүй шалтгаанаар буцаагдсан/, “Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх” төслийн нэгжүүд татан буугдсан бол төслийн үр дүнг үнэлж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхойгүй, зээлийн зарцуулалтыг нэг бүрчлэн хянаж шалгаагүй байсан.*

Мөн Зам, тээврийн салбарт хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой баримт материал архивд бүрэн хадгалаагүй, төсөл хэрэгжүүлэх чадамж сул хэт хавтгайруулсан

олон төсөл арга хэмжээг төлөвлөсөн, “МТЗ” ТӨХК-ийн хэрэгжүүлж буй “Шинэ төмөр зам”, зүүн чиглэлийн Даланзадгад-Сайншанд-Хөөт-Чойбалсан 1165 км зам, Ухаахудаг /тавантолгой/ - Гашуунсухайт чиглэлийн 267 км замын зөвлөх үйлчилгээнд үр ашиггүй зарцуулалт хийгдсэн” гэж ерөнхийлөн дүгнэжээ.

Барилга, хот байгуулалтын салбарт хэрэгжсэн төслийн хяналтыг тус салбарын сайдын шийдвэрээр “Дэд бүтэц” төслийн нэгж, мөн “Гудамж” төслийн нэгж татан буугдсанаар Сангийн яамны дэргэд “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийг баталж, төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулсан ч тэдгээрийн үйл ажиллагааны үр дүнгийн асуудал хөндөгдөөгүй орхигдсон байна.

Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн “Оюутолгой төслийн санхүүжилтийн хүрээнд шаардагдах зардлыг шийдвэрлэх тухай” 274 дүгээр тогтоолоор Оюутолгой төслийн үр ашигтай байдлыг хангах, төслийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай стратеги, санхүү, хууль болон олон нийтийн харилцааны зөвлөх үйлчилгээнд шаардлагатай 10.0 сая ам.долларын зээлийг баталснаас олгосон санхүүжилт, үр дүнгийн байдалд нарийвчилсан шалгалт хийгдээгүй байсан.

ХӨГЖЛИЙН БАНКны эх үүсвэрээр төсвийн хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх үеийн буюу Гаалийн ерөнхий газар, Шадар сайдын багц, БСШУС-ын салбарын хүрээний нэг бус төсөл, арга хэмжээний талаар тус тус харгалзан ЗТХЯ, Онцгой байдлын Ерөнхий газар болон Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хороонд хандаж нэмэлт тайлбар, тодруулгыг авах тухай хүсэлт явуулж, дараах албан хариуг авсан.

Зам, тээврийн хөгжлийн яам: /ЗТХЯ/ Тус салбарт олгосон нийт 1,320,165.8 сая төгрөгийн зээлийн (86+4) ТАХ-ний хүрээнд:

Тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хүрээнд тус яамны ТНБД-ын удирдамжаар байгуулагдсан ажлын хэсэг шалгалт хийж, тайлан баримт бичгийг сайдын 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 01/3244 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлжээ.

Нийт 90 ТАХ-ний хүрээнд гэрээний үнийн дүн 1,567,529.3 сая төгрөг байсан байна.

Авто замын барилгын 53, авто замын хяналтын 16, авто замын зургийн 12, гүүрний барилгын 5, төмөр замын барилгын 4 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэгч, Хөгжлийн банк, захиалагч гэсэн 3 талт гэрээг байгуулж байжээ.

ЗТХЯ-ны архивд байсан Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн 35, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын архивд байсан 2 төсөл, арга хэмжээний ХАА-ны баримт бичигт хяналт хийсэн ч үлдэх ТАХ-ний мэдээлэл, баримтгүй тул хяналтын ажил орхигдсон байжээ.

Тус салбарт хэрэгжсэн 90 ТАХ-ний гэрээний биелэлт, хэрэгжилтийн байдлыг дүгнэх ажлын хэсэг, Хөгжлийн банкны төлөөллийг оролцуулан 2 чиглэлд нийт 14 төслийн ашиглалтын байдлыг хянасан байна.

Засгийн газрын 124 дүгээр тогтоолоор 18 чиглэлийн 24 төсөл арга хэмжээг 2013 онд 570 тэрбум төгрөгөөр Хөгжлийн банкнаас санхүүжүүлэхээр батлахдаа 4 чиглэлийн 10 төслийн 331.7 км авто замын үнийн дүнг тусгаагүй;

Тогтоолоор батлагдсан хөрөнгийг Хөгжлийн банк гаргаж чадаагүй, дараа он руу шилжүүлсээр ирсэн;

Хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй байхад аймгийн төвүүдийг холбох зам, барилгын ажлыг бүгдийг нь эхлүүлэхийн тулд Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн жагсаалтад оруулах, дутсан санхүүжилтийг дараагийн ээлжид шийдвэрлүүлэх, хойшлуулах зэргээр асуудалд хандаж байсан;

Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын гэрээг ажлын тоо хэмжээ, улирлын үргэлжлэх хугацаа, газар зүйн онцлогийг үл харгалзсан, нэгэн ижил загвараар буюу 1 км авто

замыг 530 орчим сая төгрөгөөр байгуулсан нь уулархаг бүсэд замын төсөвт өртөг хүрэлцэхгүй болсон;

Олон жилийн өмнө хийгдсэн зураг төслийг дахин хянаж баталгаажуулах ажил хийгдээгүй, талбайн хяналтыг шаардлагын түвшинд хэрэгжүүлж чадаагүй;

Гүйцэтгэгч зөвлөхийн хяналт хэрэгжүүлэх аж ахуйн нэгж байгууллагуудын санхүү, техник, тоног төхөөрөмж, хүн хүчний чадамжийг үл харгалзан гэрээ байгуулсан;

Гэрээт ажил хэрэгжих хугацаанд импортын материалын үнэ өссөн нь гэрээний хэрэгжилтэд нөлөөлсөн. Жишээ нь: Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км авто зам /Загастайн даваа орчим/-ын төсөвт өртөг нэмэгдэх шаардлагатай буюу нийт төсөвт өртгийг дутуу баталснаас болж, хугацаанд нь хэрэгжүүлж чадаагүй байна/;

Төмөр замын барилгын ажлын талаар зээлийн зарцуулалтын байдалд тойм дүгнэлт хийхэд барилга угсралтын ажлын газарт буусан буюу бодит байдлаар боссон ажлаас гадна бодит байдалтай нийцэхгүй доорх ажлын зардлыг хэтрүүлэн үр ашиггүй зардал гаргасан гэж дүгнэсэн. Үүнд:

“МТЗ” ТӨХК үйл ажиллагааны зардалд 2,301,287 ам.доллар зарцуулсан. “МТЗ” ТӨХК-ийн хэрэгжүүлж буй “Шинэ төмөр зам” төслийн мэргэжлийн ажлын багаас гадна компанийн төв байранд компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд ямар ч хамааралгүй, үр бүтээлгүй, зорилго тодорхойгүй, ажлын байр олноор бий болгосон, компанийн дотоод менежмент, хөдөлмөр зохион байгуулалт туйлын хангалтгүй гэдгийг тогтоосон.

Техникийн зөвлөх үйлчилгээнд зүүн чиглэлийн зам буюу Даланзадгад-Сайншанд-Хөөт-Чойбалсан чиглэлийн 1165 км замд 5.8 сая ам.доллар, Ухаахудаг/тавантолгой/-Гашуунсухайт чиглэлийн 267 км замын техникийн зөвлөх үйлчилгээнд 2.4 сая ам.доллар зарцуулсан. Техникийн зөвлөхийн өгсөн мэргэжил арга зүйн зөвлөмж нь туйлын ядмаг бөгөөд зөвлөмжийн ач холбогдол бүхий нэгдсэн тайлангүй гэж дүгнэсэн байна.

Зүүн чиглэлийн зам буюу Даланзадгад-Сайншанд-Хөөт-Чойбалсан чиглэлийн 1165 км замын хуулийн зөвлөх үйлчилгээнд 4.09 сая ам.доллар, Ухаахудаг/тавантолгой/-Гашуунсухайт чиглэлийн 267 км замын зураг төсөл болоод барилгын ажлын гэрээтэй холбоотой хуулийн зөвлөх үйлчилгээнд 2.07 сая ам.доллар зарцуулсныг “МТЗ” ТӨХК нь дотооддоо зохион байгуулах бүрэн боломжтойг тэмдэглэсэн.

“Даланзадгад-Сайншанд-Хөөт-Чойбалсан” чиглэлийн 1165 км замын зураг төслийн гэрээтэй холбоотой санхүүгийн зөвлөх үйлчилгээнд 1.9 сая ам.доллар, Ухаахудаг/тавантолгой/-Гашуунсухайт чиглэлийн 267 км замын зураг төсөл болоод барилгын ажлын гэрээтэй холбоотой санхүүгийн зөвлөх үйлчилгээнд 0.9 сая ам.долларыг тус тус зарцуулсан бол энэхүү санхүүжилтийг “МТЗ” ТӨХК нь дотоод нөөц бололцоог ашиглан зохион байгуулж болох байсныг цохон тэмдэглэсэн.

Нөхцөл байдлаас үзэхэд зөвхөн 3 төрлийн зөвлөх үйлчилгээнд 17.3 сая ам.долларыг үр ашиггүй зарцуулсан байна гэж дүгнээд “МТЗ” ТӨХК-ийн удирдлага болон түүний ТУЗ нь удирдлага, зохион байгуулалтын хувьд хангалтгүй, зээлийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, хэрэв нарийвчлан авч үзсэн бол залилангийн шинж чанарыг агуулж байсан байна.

Гаалийн ерөнхий газар: /ГЕГ/ Тус салбарт олгосон нийт 31,105.7 сая төгрөгийн зээлийн 2 ТАХ-ний хүрээнд:

Нарийвчилсан хяналт шалгалтын талаар дурдаагүй, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 350 дугаар тогтоолоор төсөл хэрэгжсэн дүнгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд балансаас баланст шилжүүлсэн байна.

Эрчим хүчний яам: /ЭХЯ/ Тус салбарт олгосон нийт 582,614.4 сая төгрөгийн зээлийн 50 ТАХ-ний хүрээнд:

Нарийвчилсан хяналт шалгалтын талаар дурдаагүй, хэрэгжсэн гэх 50 төслийн жагсаалтаас улсын комиссын актаар баталгаажуулаагүй 1, төсөвтэй тооцоо нийлсэн болон гүйцэтгэгч гэрээт ажлаа хугацаанд нь дуусгаагүйгээс шүүхэд хандсан 2 төсөл гэх зэргээр зөвхөн жагсаалт ирүүлжээ.

Барилга, хот байгуулалтын яам: /БХБЯ/ Тус салбарт олгосон нийт 171,807.9 сая төгрөгийн зээлийн 37 ТАХ-ний хүрээнд:

Нарийвчилсан шалгалт хийгдээгүй, Хөгжлийн банкны санхүүжилтээр 2012-2016 онд 34 ТАХ-г хэрэгжүүлснээс “Дэд бүтэц” төслийн нэгж 23 /төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий “Дэд бүтэц” төслийн нэгжийг салбарын сайдын 2013 оны 92 дугаар тушаалаар байгуулсан/, яам хариуцан 11 төслийг хариуцан хэрэгжүүлснийг тэмдэглэснээс өөрөөр ач холбогдол бүхий асуудлыг хөндөөгүй байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам: /УУХҮЯ/ Тус салбарт олгосон нийт 11,098.9 сая төгрөгийн зээлийн 3 ТАХ-ний хүрээнд:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжсэн “Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх” төслөөс нарийвчилсан ТЭЗҮ-г УУХҮЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж хүлээн авснаар төслийн үйл ажиллагаа зогссон, “Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор” төслийн нэгжийг Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор татан буулгажээ.

Гэвч дээрх 2 төслийн нэгж татан буугдахад тэдгээрийн санхүүгийн үйл ажиллагаа, зээлийн ашиглалт, зарцуулалт, үр дүн болон төслийн нийт үр өгөөж, үр нөлөөт байдлын тухай хяналт шалгалтын танилцуулгад дурдсан зүйлгүй байна.

“Замын-Үүд дэх Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийн автоматжуулалт” төсөл хэрэгжиж дууссан байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам: /ХХААХҮЯ/ Тус салбарт олгосон нийт 7,995.0 сая төгрөгийн зээлийн 1 Төсөл арга хэмжээний хүрээнд:

Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг чиглэлийн дагуу хийсэн хяналт шалгалтын тайланг ирүүлснээс гадна яамны Дотоод аудитын хорооноос өмнө нь зээлдүүлэгчийн төлөөлөл болоод Тариалан эрхлэлтийг дэмжих сан, ХХААХҮЯ-ны хамтарсан шалгалтын дүнг үндэслэн 2016 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр батламжилсан 01 тоот тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Газар тариалангийн агуулах” худалдан авах ажиллагаатай холбоотой гарсан зөрчилд АТГ эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа гэх боловч уг хэрэг хэрхэн шийдвэрлэгдсэн талаар мэдээлэлгүй байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам: /БСШУСЯ/ Тус салбарт олгосон нийт 2,000.0 сая төгрөгийн 1 ТАХ-ний хүрээнд:

Сангийн сайд, Эрүүл мэнд, спортын сайд /хуучин нэрээр/, Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирлын хамтарсан 2015 оны “төсөл санхүүжүүлэх ерөнхий нөхцөлийг тохиролцох гэрээ” 77/2/283, 1/22 дугаар бүхий гэрээгээр “Увс аймгийн Улаангом сумын наадмын талбайн дуусгал 2500 суудал” нэртэй 2,000.0 сая төгрөгийн ажил хийгдэж, мэдээлэл ирүүлэх асуудлаар Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэд хандана уу гэсэн хариуг ирүүлжээ.

Шадар сайдын багц: Тус салбарт олгосон нийт 20,000.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээний хүрээнд:

Сангийн сайд, Хөгжлийн банкны гүйцэтгэх захиралтай байгуулсан 2015 оны 74/2/280/131 тоот гэрээний дагуу Онцгой байдлын албанд галын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл

худалдан авахад зориулж 20.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноор төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж дууссан байна.

Сангийн яам: Тус салбарт олгосон нийт 87,649.7 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээний хүрээнд:

Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 274 дүгээр тогтоолоор баталсан “Эрдэнэс Оюутолгой” төслийн зөвлөх үйлчилгээний төсөлд Сангийн яам, “Эрдэнэс Оюутолгой” ХХК болон Хөгжлийн банк хоорондын гурван талт 2014 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан “137/3-ОТ-С 2014-99” дугаартай 2 жилийн хугацаатай, жилийн 7.65 хувийн хүүтэй, нийт 10.0 сая ам.долларын гэрээг байгуулж, нийт 2014 оны 11 дүгээр сараас 2015 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэл 8 удаагийн санхүүжилтээр нийт 2,512,000.20 ам.долларын “зээл олгосон ч санхүүжилтийн үр дүнг тооцож тодорхойлсон зүйлгүй” байна.

Хувийн орон сууцны зээлийн санхүүжилт болон нэмэлт санхүүжилтийн төсөлд зориулан 2012, 2013 онд Сангийн яам, Хөгжлийн банкны ТУЗ, Төрийн банкттай 2012 оны 05 дугаар сарын 16-ны өдөр 50.0 тэрбумын болон 2013 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр 30.0 тэрбум төгрөгийн буюу нийт 80.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн гэрээ байгуулж, дамжуулан зээлийн санхүүжилт олгосон. Дээрх төслийн зээлийн гэрээнд нэмэлт оруулсан асуудал байсан бөгөөд энэхүү өөрчлөлт 2013 оны 12 дугаар сард тус тус хийгдэж нийт 80.0 тэрбум төгрөгийн зээлийг ам.доллар /дундаж ханш 1375.18/-т хөрвүүлснээр нийт 58.4 сая ам.доллар болсон. Сангийн яам, Хөгжлийн банк 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр нийт өглөг, авлагыг харилцан суутгаж, хүүгийн хамт 145.4 тэрбум төгрөгөөр /тооцоо нийлэх үеийн ханш 2489.53/ тооцоо нийлжээ.

Гудамж төслийн үйл ажиллагааг шинээр байгуулагдсан “Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц төсөл”-ийн нэгж үргэлжлүүлэн хариуцжээ. Төслийн үйл ажиллагаанд ҮАГ-аас аудит хийсэн ч аудитын мөрөөр тус нэгж ямар үйл ажиллагаа явуулж үр дүнд хүрсэн нь тодорхойгүй байна. Түүнчлэн АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсээс нээсэн 2016 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 06/6278, 10 дугаар сарын 11-ний өдрийн 06/7014, 11 дүгээр сарын 18-ны өдрийн 03/6016, 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 06/1379, 08 дугаар сарын 10-ны өдрийн 03/6016 дугаар албан бичгээр “эрүүгийн 2014250003287 дугаартай хэргийн хэрхэн шийдвэрлэгдсэн байдлын талаар ямар ч мэдээлэлгүй” байна.

НЗДТГ: Нийслэлийн бүсэд дэд бүтцийг сайжруулах чиглэлээр олгосон нийт 305,790.1 сая төгрөгийн 171 ТАХ-ний хүрээнд:

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй сонгон шалгаруулалт явуулалгүйгээр сонгож шууд гэрээ байгуулсан нь хуулийн зохих шаардлагатай нийцээгүй, үүнээс шалтгаалан төслийн үндэслэл, тооцоолол, төсөвт шинжээч ажиллуулах шаардлага үүсэж байсан.

Гудамж төслийн хүрээнд баригдах авто замын ажлын зураг төсөл боловсруулахаас зам, барилга угсралтын ажлыг бүрэн дуусгах хүртэл хяналт, зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх гэрээтэй “Си ти ай инженеринг интернейшнл” ХХК нь төрийн захиргааны төв байгууллагад бүртгэлгүй, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй байгууллага захиалагчийн хяналтыг гүйцэтгэсэн байна.

Атар өргөөгийн уулзвараас Яармагийн гүүр 1 км авто замын барилгын ажилд 2013 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр 440.0 сая төгрөгөөр гэрээ байгуулсан ч зураг төсвийг магадлалаар баталгаажуулсны дараа дахин гэрээ байгуулж гэрээний үнийн дүнг 1,895.5 сая төгрөг болгон өөрчилж байжээ.

Засгийн газрын 118 дугаар тогтоолоор “Дэд бүтэц” төслийн дэд бүтцийн барилга байгууламж, шугам, сүлжээний ажлыг гүйцэтгэхээр тусгагдсан 2 ажил нь төсөл хэрэгжихээс өмнө гүйцэтгэсэн ажил байгаа ба эдгээр ажил нь төсөвт өртгийн ихээхэн зөрүүтэй, хугацаандаа ашиглалтад ороогүй байжээ.

Төслийн үр дүнд шинээр 36.2 км авто зам, 123.0 у/м гүүр барьж, 68.06 км авто зам өргөтгөн шинэчилсэн, 22 уулзварын өргөтгөл шинэчлэлтийг хийж, гэр хорооллын 9 гудамжны зам



барилгын ажлын тохижилт хийгдэж, зам барилгын 93 зураг төсөл /цаашид ашигласан эсэхийг тодруулах шаардлагатай/ боловсруулагдаж, авто зам дагуу 1306 ширхэг гэрэлтүүлэг хийгдсэн.

Гэр хорооллын 3 гудамжны зураг төслийг боловсруулж, шинэчлэлтийн ажлыг авто зам, дэд бүтцийн барилгын хамт хийж, Хүй 7 худгийн тохижилтын зураг төслийг боловсруулж, тохижилт, зам барилгын ажлыг гүйцэтгэсэн. Туулын хурдны зам, Сэлбэ голын ТЭЗҮ, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, зураг төслийг гүйцэтгэсэн.

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн байршлуудад цахилгааны хаалттай дэд өртөө 47 ком, цахилгаан хуваарилах байгууламж 5 ком, цахилгааны дэд станц 4 ком, цахилгааны 171.5 км шугам, дулааны бага оврын 12 ширхэг эх үүсвэр, цэвэр усны 11.9 км шугам, бохир усны 7.6 км, дулааны 13 км шугам, ус хангамжийн 5.8 км шугам, ариутгах татуургын 3.6 км шугам сүлжээ ашиглалтад оруулсан гэж мэдээлсэн.

Төсвийн хөрөнгөөр эргэн төлөгдөх нөхцөлтэй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд нарийвчилсан хяналт хийх тухай Засгийн газрын 2016 оны 49, 2017 оны 52 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавар нь бүхэлдээ дурдсан хяналт шалгалтын ажлын үр дүнд суурилан төсвийн хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг сайжруулах, цаашид авах арга хэмжээний дүгнэлт санал нь ХӨГЖЛИЙН БАНКНЫ үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн ажиллуулахад чиглэгдэж байсан ч энэхүү шалгалтын үр нөлөөг тооцсон гэх хангалттай баримт материал алга байна.

### **Сангийн яам, Монголбанкны хамтарсан шалгалтын ажлын хэсэг /2020 он/**

Сангийн яам, Монголбанкны хамтарсан шалгалтын гол зорилго нь 2019 онд Хөгжлийн банканд хийсэн өргөтгөсөн хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилттэй танилцах, банкны өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмын хэрэгжилт болон үйл ажиллагааны нөхцөл байдлыг бодитоор үнэлэхэд оршиж байсан.

Хөгжлийн банкны үйл ажиллагаанд 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөр тасалбар болгон Засгийн газар, Монголбанкнаас хамтарсан шалгалт /өргөтгөсөн/-ыг гүйцэтгэсэн. Энэхүү шалгалтын дүнд үндэслэн Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 169 дүгээр тогтоолоор илэрсэн нөхцөл байдалтай уялдуулан алдаа зөрчлийг засаж ажиллахыг Хөгжлийн банкны ТУЗ-д даалгасан шийдвэр гарснаас өөрөөр үр дүнг үнэлэх зүйл алга байна.

Энэхүү хамтарсан шалгалт нь 2019 онд тус банканд хийсэн өргөтгөсөн хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилттэй танилцах, банкны өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмын хэрэгжилт болон үйл ажиллагааны нөхцөл байдлыг бодитоор үнэлэх зорилготой байсан гэж ирүүлсэн албан бичигт дурджээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” 122 дугаар тогтоолоор “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж байхаар тогтоож, 2020 оны 129 дугаар тогтоолоор банкны дүрмийг шинээр баталснаар Сангийн яам энэхүү шалгалтыг ахалсан.

Гэвч ажлын хэсгийн хамтарсан шалгалтын тайлангаас үзэхэд тус банкны үйл ажиллагаанд үүссэн хүндрэлтэй байдлын нөхцөл, учир шалтгааны талаар дурдсан зүйлгүй, шалгалтын дүнд үндэслэсэн хариу арга хэмжээний талаар тайлагнаагүй байгаа нь энэхүү шалгалтын тайланг “Хөгжлийн банк”-д албажиж хүргүүлээгүй байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна.

Тайлангийн агуулгыг нягтлан үзэхэд хамрах хүрээний асуудлаар нөхцөл байдалд суурилсан мэдээллийг дурдсанаас өөрөөр дүн шинжилгээнд суурилсан тодорхой гаргалгаа бүхий асуудлыг хянан шалгагчдын зүгээс олж хараагүй болно.

Тайланд дурдсанаар зөвхөн зээлийн орчны асуудлаар цаашид авах арга хэмжээний санал гэсэн асуудлаар сайжруулалт хийхийг дурдсанаас өөрөөр “нөхцөл байдал”-д суурилсан холбоотой талуудын хүлээх ёстой хариуцлага, ёс зүйн болоод нийтээр хүлээх алдагдал түүнээс

улбаалан талуудын оролцоог хөндсөн, тэдгээрт үндэслэгдсэн хууль тогтоомжийн үл нийцэлтэй холбогдсон асуудал энэхүү тайланд тусгагдаагүй байна.

Хөгжлийн банкны 2020 оны 04 дүгээр сарын 1-ний өдрийн банкны бүртгэлээр 1.8 их наяд төгрөгийн 44 зээлдэгчийн зээлийн ангиллыг бууруулж, шинэчлэн тогтоосноор нийт 787.4 тэрбум төгрөгөөр зээлийн эрсдэлийн санг нэмэгдүүлэх тохируулгын гүйлгээ хийхийг чиглэл болгосон.

Банкны өөрийн ангилснаар зээлдэгч бүрд байгуулсан сангийн хувийн дундаж хэмжээ 16.9 хувь байсан бол тохируулга хийснээр 45.7 хувь, сангийн зөрүү 28.8 хувьд хүрсэн гэдгийг онцолсон нь энэхүү шалгалтын онцлог байна.

Ажлын хэсгийн хамтарсан шалгалтаар,

**II** *“Зээлийн үйл ажиллагаа”*-тай холбогдуулан цаашид авч хэрэгжүүлэх 7 арга хэмжээний саналын гол агуулга нь,

Зээлийн орчны хяналт удирдлагын тогтолцоог сайжруулж, батлагдсан дүрэм журмыг дагаж мөрдөх, эрсдэлийн санг зохих ёсоор байгуулж, стандартын дагуу банкны бүртгэл, тайланд үнэн зөв бүртгэх, зохицуулалтгүй болон сайжруулалт шаардлагатай дүрэм журам, мөн тус банкны хуульд оруулах өөрчлөлт, мэргэжлийн удирдлага ур чадварын асуудлаар дотоод хяналтын тогтолцоог төлөвшүүлэх асуудлыг хөнджээ.

**III** *“Активын бүтэц, бусад актив хөрөнгийн удирдлага”*-ын талаар тайланд хэрхэсэнийг авч үзвэл, шалгалтаар активын бүтцэд гарсан үндсэн үзүүлэлтийн өсөлт бууралт буюу өөрчлөлтийг харуулж, дотоодын арилжааны банкнуудад байршуулах мөнгөн хөрөнгийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх, бүртгэлтэй хөрөнгө оруулалт, үнэт цаас, өрийн бичгийн мэдээллийг дурдсаны зэрэгцээ авлага, үнэ цэнэ буурч болзошгүй болон эрсдэлтэй активын төлөвтэй уялдуулан зохих журмын дагуу ангилж, бүртгэл тайланд тусгах асуудлыг хөндсөн байна.

Тухайн үед хуримтлуулж тооцсон хүүгийн нийт 334.0 тэрбум төгрөгийн хүүгийн авлага бүртгэлтэй, үүнээс 321.0 тэрбум төгрөг буюу нийт зээлийн хүү, түүний 288.9 тэрбум төгрөг буюу 90.0 хувь чанаргүй зээлд хамаарч байсныг дурджээ.

**III** *“Татан төвлөрүүлсэн хөрөнгө, төлбөр түргэн чадвар”*-ын асуудлаар тайланд дурдсанаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн хувьд өсөлт гараагүй, бүтцийн хувьд тогтвортой, банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийг хангаж байгаа ч цаашид зээлийн орчны чанаргүй төлөв, эрсдэлийн сан нэмж байгуулсан тохируулгын гүйлгээний дараа ч гэсэн гадаад эх үүсвэр татах үеийн байгуулсан гэрээний хэрэгжилтэд нөлөөлж болзошгүй байдлыг хөндсөн.

Татан төвлөрүүлсэн хөрөнгө, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийг хангаж байхуйц урьдчилсан нөхцөлийг тооцож байх, банкны санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг нэн даруй нэвтрүүлэх, эх үүсвэрээ байршуулсан банк, санхүүгийн байгууллагатай тохирч төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийг шинэчлэн тогтоох арга хэмжээний саналыг бичсэн.

**IV** *“Зах зээлийн болон үйл ажиллагааны эрсдэлийн мэдрэмж”* хэсэгт ТУЗ-ийн 2019 оны 76 дугаар тогтоолоор баталсан эрсдэлийн удирдлагын бодлогыг удирдлага болгон ажиллаж, чиг үүргийг хэрэгжүүлсэн байдлын талаар авч үзсэн ба тайланд хүүгийн болон ханшийн эрсдэлийг онцгойлон алдагдал хүлээж болзошгүйг сэргийлж дурдсан.

Энэхүү асуудлаар “зөвхөн” удирдлагын түвшинд хянан үзэж, актив пассивын удирдлагын хороо нь үр нөлөөтэй ажиллах шаардлагыг дэвшүүлжээ.

**VI** *“Өөрийн хөрөнгийн хүрэлцээ”* банкны чанаргүй актив нэмэгдэхийн хирээр шалгуур үзүүлэлт буурч бодит байдлаар хөрөнгийн хүрэлцээг хангаж чадахгүйд хүрэхийг сануулсан байна.

Нийт зээлийн багцад хийсэн шинжилгээгээр 787.4 тэрбум төгрөгийн үнэ цэний бууралт нэмж бүртгэгдсэнээр тус банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 5.51 хувь, нийт өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 4.86 хувь болж алдагдах, шаардлагатай нэмэлт өөрийн хөрөнгийн хэмжээ 230.9 тэрбум төгрөгт хүрнэ гэж тооцоолсон.

“Ашигт ажиллагааны шинжилгээ”-ээр цэвэр хүүгийн харьцааг 0.8 хувь гэж тооцоолон эрсдэлийн сангийн зардал өсөж байгаатай холбогдуулан өөрийн хөрөнгийн өгөөж хасах утгатай болж эрсдэлийн сангийн зардал, нийт орлогын харьцаа 480.7 хувь байгаа тул чанаргүй актив болон алдагдлын хэмжээг бууруулахад онцгой анхаарч ажиллахыг зөвлөсөн байна.

**М/** “Банкны бүтэц, удирдлага, зохион байгуулалт”-ын хувьд өмнөх шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүйг тэмдэглэж, энэ нь банкны үйл ажиллагааны дотоод хяналт, удирдлага болон ажилтнуудын сахилга хариуцлагатай холбоотой гэж үзсэн.

Тус банкны үйл ажиллагаанд сүүлийн 2 жил дараалан 2 удаагийн хамтарсан шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хэрэгжилт бүрэн хангагдахгүй, удаашралтай, удаа дараа давтагдсан, хангагдах эсэх нь тодорхойгүй, үр дүн хангалтгүй, ажилтнуудын сахилга хариуцлага дунд зэрэг хэвээр байна гэж дүгнэжээ.

Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” 122 дугаар тогтоолоор Хөгжлийн банкны төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлснээр энэхүү шалгалтыг гүйцэтгэх гол үндэслэл болсныг дурдаж байна.

Энэхүү хяналт шалгалтын ажлын үр нөлөө нь цаг хугацааны хувьд болон ил тод байдлын хувьд ач холбогдлоо алдсан.

Ажлын хэсгийн тайланг Хөгжлийн банканд албан ёсоор хүргүүлж, танилцуулаагүй нь нөхцөл байдал улам хүндрэхэд хүргэсэн байж болзошгүй юм. Шалгалтын зорилго нь өмнөх шалгалтын үр дүнгийн байдалд хяналт хийх байсан боловч шалгалтын тайлан албан ёсоор албажаагүйгээс шалгалтын үр дүн гараагүй.

Ажлын хэсгийн хамтарсан шалгалтын тайлангаас үзэхэд тус банкны үйл ажиллагаанд үүссэн хүндрэлтэй байдлын нөхцөл, учир шалтгааны талаар дурдсан зүйлгүй, шалгалтын дүнд үндэслэсэн хариу арга хэмжээний талаар тайлагнаагүй байна.

Тайланд дурдсанаар зөвхөн зээлийн орчны асуудлаар цаашид авах арга хэмжээний санал хэсэгт үйл ажиллагааны чиглэл, горимын хувьд сайжруулалт хийх асуудлыг дурдсанаас өөрөөр нөхцөл байдалд суурилсан холбоотой талуудын хүлээх ёстой хариуцлага орхигдох эрсдэлийг үүсгэсэн.

Өөрөөр хэлбэл, хариуцлага ёс зүйн болоод нийтээр хүлээх алдагдал, түүнээс улбаалан талуудын оролцоог хөндсөн, тэдгээрт үндэслэгдсэн хууль тогтоомжийн үл нийцэлтэй холбоотой тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохих асуудал энэхүү тайланд тусгагдаагүй байна.

### **Монголбанкнаас хийсэн бусад хэсэгчилсэн болон өргөтгөсөн хяналт шалгалт**

Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсноор Засгийн газартай хамтран хэсэгчилсэн болон ээлжит хяналт шалгалтыг гүйцэтгэсэн байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамж /2011.03.25-2017.04.26/ бүхий иж бүрэн хяналт шалгалтаар дараах асуудлыг илрүүлэн зөвлөмж өгч байсан байна.

- Хөгжлийн банкнаас шууд санхүүжүүлсэн зээл нь хуулийн 10.1.2-т заасан эдийн засгийн болон санхүүгийн үр ашигтай, зээлийг эргэн төлөх чадвартай байх гэсэн шаардлага хангагдаагүй;

- Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 23.2-т заасны дагуу зээлийн хувийн хэргийн бүрдлийг хангаагүй;
- 2011 онд 602.2 тэрбум төгрөгийн, 2012 онд 5.7 тэрбум төгрөгийн, 2016 онд 191.8 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан;
- Шууд санхүүжүүлсэн 8 төсөл нь Зээлийн бодлогын 5.5 дахь заалт буюу барьцаа хөрөнгийн шаардлага хангаагүй;
- Хүүгийн болон ханшийн эрсдэл банкныг алдагдалд оруулах өндөр эрсдэл тогтоогдсон;
- Актив пассивын хугацааны зөрүүгийн шинжилгээгээр төлбөрийн чадварын эрсдэлд өртөж болзошгүй, хөрвөх чадварын удирдлагын бодлого тодорхойгүй “дефолт” үүсэж болзошгүй гэж дүгнэж байсан.

Уг шалгалтын дүнд суурилан банкны тухай хууль, тогтоомжид заасан шаардлагуудын хүрээнд Хөгжлийн банкны ТУЗ-ийн үйл ажиллагаа, зохистой засаглал, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавихыг чиглэл болгож байсан байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамж /2017.04.26-2018.07.20/ бүхий Иж бүрэн хяналт шалгалтаар дараах гол асуудлыг хөндөж байсан байна. Үүнд:

Хөгжлийн банкны зээлдэгч “Нью Хаппи”, “Хөтөл”, “Эрэл”, “Капитал банк” зэрэг компаниудын нийт 378.7 тэрбум төгрөгийн 9 зээлд үнэ цэний бууралт тооцож, нийт 80.3 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан нэмж байгуулах тухай Улсын байцаагчийн мэдэгдлийг хүргүүлсэн.

Шалгах өдрөөр нэмж байгуулсан 80.3 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сангийн тохируулгын гүйлгээг хийснээр МУХБ 3.5 их наяд төгрөгийн актив хөрөнгөтэй, 2.5 их наяд төгрөгийн татан төвлөрүүлсэн хөрөнгөтэй, 2.1 их наяд төгрөгийн зээлийн өрийн цэвэр үлдэгдэлтэй, 1.02 их наяд төгрөгийн өөрийн хөрөнгөтэй, 53.0 тэрбум төгрөгийн тухайн жилийн алдагдалтай, 157.7 тэрбум төгрөгийн өмнөх үеийн алдагдалтай байна гэж дүгнэсэн.

Уг шалгалтаар тус банканд мөрдөж байгаа “Зээлийн тусгайлсан болон бүлгийн эрсдэлийн сан байгуулах дотоод аргачлал”-ыг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2017 оны А-294/340 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн багц материал” болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны А-251 дүгээр тушаалаар баталсан “Хөгжлийн банкны актив ангилах, активын эрсдэлийн сан байгуулах журам”-тай нийцүүлэн баталж, мөрдөж ажиллах үүрэг өгсөн нь агуулгын хувьд өмнөх шалгалтаар өгсөн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал давтагдсан шинжтэй байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамж /2021.12.13/-тай хэсэгчилсэн шалгалтаар доорх гол асуудлыг хөндсөн. Үүнд:

Хөгжлийн банкнаас 2020 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 2/977 дугаар албан бичгээр тус банкны санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн зээлд холбогдох журам, аргачлалын дагуу 2020 оны эхний хагас жилийн байдлаар 800.0 гаруй тэрбум төгрөгийн эрсдэлийн санг нэмж байгуулах тооцоо гарсан нь дараах хүндрэлд хүргэж болзошгүйг анхааруулан тайландаа тусгасан байна.

Хөгжлийн банк нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 44 зээлдэгчээс 6 зээлдэгчийн зээлд эрсдэлийн санг нэмж байгуулсан. Бусад зээлд эрсдэлийн сан нэмж байгуулах тохируулгыг 2020 оны жилийн эцсийн байдлаар авч үзэхэд банкны тайлант үеийн алдагдал 779.9 тэрбум төгрөг, хуримтлагдсан алдагдал 934.5 тэрбум төгрөгт хүрч өсөх тооцоолол гарч байсан.

Монголбанкны 2021 оны 7 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон хийсэн хэсэгчилсэн шалгалтаар хийсэн тохируулах бичилтийн дараа Хөгжлийн банк нь 3.3 их наяд төгрөгийн актив хөрөнгөтэй, 1.5 их наяд төгрөгийн зээлийн цэвэр өрийн үлдэгдэлтэй, 259.4 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгөтэй болж, банкны тухайн жилийн алдагдал 742.0 тэрбум төгрөг, хуримтлагдсан алдагдал 987.6 тэрбум төгрөгт хүрэх болсон байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамж /2021.12.13/-тай “Хэсэгчилсэн шалгалт”-аар Хөгжлийн банкны санхүүгийн голлох үзүүлэлт дараах байдалтай байсанд дүгнэлт өгсөн. Үүнд:

Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан журамд заасны дагуу Хөгжлийн банкны 2019 оны жилийн эцсийн тайлан тэнцэлд бүрэн байгуулагдаагүй нийт 337.8 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн санг нэмж байгуулах тохируулгын гүйлгээг хийж, нийт 305.0 тэрбум төгрөгийн тайлант үеийн алдагдалтай, 460.0 тэрбум төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай болсон .

Сангийн яам 2020 оны 2 дугаар сараас эхлэн Хөгжлийн банкны хувьцаа эзэмшигч болсонтой холбоотой Сангийн яам, Монголбанкны хамтарсан иж бүрэн шалгалт /2020.04.01-ний байдлаар/ хийх үед тус банкны 1.8 их наяд төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэл бүхий 44 зээлдэгчийн зээлд 787.4 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн санг нэмж байгуулахаар тооцоолж байсан.

Тайланд тэмдэглэгдсэнээр Сангийн сайд болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хамтран баталсан Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хийх хамтарсан шалгалтын удирдамжийн дагуу хийгдсэн газар дээрх иж бүрэн шалгалтын дүн эцэслэсэн байдлаар батлаагүйг “тэмдэглэсэн” юм.

Монголбанкны оролцоотойгоор хийгдсэн хяналт шалгалтаар зээлийн эрсдэлийн сангийн хэмжээг зохистой түвшинд байгуулахыг чиглэл болгон ирсэн ч тэр бүр хэрэгжилт хангагдаагүй байсан.

Хөгжлийн банк нь жилийн эцсийн санхүүгийн тайлан, НББ-д хийвэл зохих зээлийн чанарын үзүүлэлттэй холбоотой тохируулга бичилт буюу үнэ цэний бууралтаас шалтгаалж бий болох эрсдэлийн сангийн хэмжээг хөндлөнгийн аудитын байгууллагын зөвлөмжөөр тайлагнадаг байсан бөгөөд эрх бүхий байгууллагын нийт 6 удаагийн шалгалтаар эрсдэлийн сангийн хэмжээнээс материаллаг дүнгээр зөрүү үүсэж байсан нь Монголбанк болон хөндлөнгийн баталгаажуулах аудитын хяналт шалгалтын дүгнэлт зөвлөмж тэр болгон үр дүнтэй байж чадаагүйг илтгэж байна.

Хөгжлийн банкны гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн “Хүсэлт хүргүүлэх тухай” 2/690 дүгээр албан бичгээр тус банкнаас Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А-290 дугаартай тушаал, Монголбанкны улсын байцаагчийн 2018 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 2018/12039/005 дугаартай мэдэгдлийг хууль бусад тооцуулах тухай нэхэмжлэлийг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасныг үндэслэн, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байсныг мэдэгдсэн.

Тус банкны нийт зээлийн хэмжээг 2.6 их наяд төгрөгөөс хэтрүүлэхгүй байх гэсэн хязгаарлалт нь Хөгжлийн банкны зээлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад хүндрэлтэй байдал үүсгэж байгааг дурдан хязгаарлалтыг авах талаар тодорхой арга хэмжээ авч дэмжлэг үзүүлэхийг хүсжээ.

Монголбанкнаас тухайн тушаал нь дараагийн газар дээрх хяналт шалгалтын акт, материал батлагдах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх болохыг Монголбанкны 2019 оны А-1/36 дугаар албан бичгээр тус банканд мэдэгдэж байсан.

Гэвч Хөгжлийн банканд хийсэн шалгалтын дүнгийн тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А-290 дугаар тушаалын “ХОЁР” дахь хэсгийн 1 дэх заалтын “2.6” гэснийг “3.0” гэж өөрчилсүгэй хэмээн 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А-184 дүгээр тушаалаар өөрчлөлт оруулж, “нэмэгдэж буй 400 тэрбум төгрөгийн зээлийн олголтыг “Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал та биечлэн хариуцахыг” мэдэгдсэн байна.

#### **Үндэсний аудитын газраас хийсэн хяналт шалгалт**

ҮАГ-аас Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбоотой дараах сэдвээр гүйцэтгэсэн байна. Үүнд:

*Хүснэгт 22 Аудитын тайлангийн мэдээлэл*

Аудитын сэдэв /гүйцэтгэсэн он/	Гол асуудал
Гадаадын зээл, тусламж, Засгийн газраас гадаад зах зээлд гаргасан бонд, МУХС-гийн хөрөнгөөр 2008-2013 оны 9 дүгээр сар хүртэл хугацаанд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын чанартай төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн /2014/	<i>Бондын хөрөнгөөр санхүүжүүлэх хөтөлбөр, ТАХ-ний төлөвлөлт, зарцуулалтын талаар ҮАБЗ-ийн гаргасан зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байсныг тогтоосон.</i>
Засгийн газраас гаргасан үнэт цаас болон Чингис Самуурай бондын хөрөнгийн зарцуулалт, Хөгжлийн банкны хуулийн хэрэгжилт, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн төслийн үр дүн /2015/	<i>Хөгжлийн банкны бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө, эх үүсвэрийн ашиглалтыг сайжруулах шаардлагатай гэж үзсэн.</i>
Улсын төсвийн хөрөнгөөр 2015 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудит /2016/	<i>ТАХ хугацаандаа хэрэгжээгүй, гүйцэтгэлийг баталгаажуулаагүй, газар чөлөөлөлт хийгдээгүй, гэрээ байгуулаагүй, зураг төсөл бүрэн бус ТАХ-г санхүүжүүлсэн.</i>
Хөгжлийн банкны хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилт /2017/	<i>Анх удаа давтан аудитыг гүйцэтгэж, тухайн үед зөвлөмжийг хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн.</i>
Монгол Улсын Засгийн газар, Хөгжлийн банкны хооронд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй үүссэн өр, авлагын тооцоог 2016 оны жилийн эцсийн байдлаар баталгаажуулах аудитын тайлан /2017/	<i>Өр, авлагын тооцоог нийлж, баталгаажуулж дуусаагүй, зээлийн хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд эцэслэн тусгаагүй байсан.</i>
Монгол Улсын хөгжлийн банкны үйл ажиллагаа, зээл олголтын үр дүн, эргэн төлөлтийн байдалд хийсэн гүйцэтгэлийн аудит /2019/	<i>Зөвлөмжийн биелэлтийг тайлагнаагүй, аудитын мөрөөр гүйцэтгэх үе шатны ажил хийгдээгүй.</i>
Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн 2021 нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан /2022/	<i>“Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн ч аудитын мөрөөр хийх үе шатны ажил эхлээгүй.</i>
Хөгжлийн банкны үйл ажиллагааны үр нөлөө, үр ашиг /2023/	<i>Монгол Улсын Хөгжлийн Банк 2020-2021 оны хооронд 81.6-306.7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласныг тогтоосон 2023 оны 12 сарын 14-ний байдлаар чанаргүй зээл 1,270.1 тэрбум төгрөг буюу 56.3 хувьд хүртэл өсөж, хөндлөнгийн хяналтын байгууллагын зөвлөмжийн 58.4 хувь нь хэрэгжээгүй байгааг тогтоосон.</i>

ҮАГ-аас 2019 онд гүйцэтгэсэн аудитын хүрээнд нийт 3.0 их наяд төгрөг, 341.5 сая ам.доллар, 168.0 сая иений мөнгөн дүн бүхий 25 алдаа зөрчлийг илрүүлж, зөвлөмжөөр 2.0 их наяд төгрөг, 19.4 сая ам.долларын, эрсдэлийн аудит хийх шаардлагатай гэж үзсэн 7.6 тэрбум төгрөг, 257.4 сая ам.долларын ажил үйлчилгээ, албан шаардлагаар 786.9 тэрбум төгрөгийг, 138.9 тэрбум төгрөг 64.7 сая ам.доллар, 168 сая иений алдаа зөрчилтэй холбогдох асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлжээ.

Уг аудит үе шаттайгаар үргэлжилсэн бөгөөд нэмэлт горим хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу Хөгжлийн банкны 2012-2017 оны үйл ажиллагаа, төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр шууд олгосон зээл, Засгийн газрын холбогдох тогтоолуудын дагуу арилжааны банкуудаар дамжуулан олгосон зээлийг түүврийн аргаар хамруулж, УИХ-ын 2016 оны 81 дүгээр тогтоол, Засгийн газрын 2017 оны 42, 219 дүгээр тогтоолуудын хүрээнд Хөгжлийн банкнаас Сангийн яаманд шилжүүлсэн “улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон зээл”-ийн багцаас хэрэгжилт хангалтгүй төсөл, хөтөлбөрийн шалтгаан нөхцөлийг тодорхойлсон.

Аудитын дүнд эрх зүйн зохицуулалт хангалтгүй, эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрэн бүрдээгүй байхад Хөгжлийн банкны тухай хууль /2011 он/ батлагдсан гэж үзсэн. Банкны захиргааны нэгжийн орон тоо банкны үйл ажиллагаатай бүрэн уялдаагүй, арвилан хэмнэлттэй ажиллах зарчмыг хангаагүй, үр ашиггүй зарцуулалт, худалдан авах ажиллагаанд мөрдөж буй журмын зохицуулалт хангалтгүй байгаа нь арвилан хэмнэлттэй худалдан авалт хийгдэх нөхцөлийг бүрдүүлж байсныг илрүүлсэн.

Тооцоо судалгаагүйгээр эх үүсвэр татаж, мөнгөн хөрөнгийн удирдлагыг зохисгүй хэрэгжүүлснээс их хэмжээний алдагдал хүлээсэн, бэлтгэл ажлыг бүрэн хангахгүйгээр бонд гаргасан, зарим бондын эх үүсвэр татах үйл ажиллагааны зардал өндөр байгаа нь бодит хүү нэмэгдэхэд хүргэснийг хөндөж байсан.

2012-2015 онд мөнгөн хөрөнгийн удирдлагыг зохистой хэрэгжүүлээгүйгээс их хэмжээний орлого олох боломжийг алдаж, 102.1 тэрбум төгрөгийн ханшийн алдагдал хүлээсэн,

санхүүжүүлсэн төслийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт иж бүрэн бус, зээл олголтод мөрдөгдөж буй дүрэм, журмын мөрдөлт, зохицуулалт хангалтгүй байсны дээр санхүүжүүлсэн зарим зээл хуулийн зорилго, зорилтод нийцээгүй, УИХ-аас батлаагүй хөтөлбөрүүдэд арилжааны банкнуудаар дамжуулан зээл олгосныг тэмдэглэж байсан.

Түүнчлэн арилжааны банкаар дамжуулан зээлийн багц, төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн багцын хувьд хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг бүрэн тодорхойлоогүй байна гэх мэтчилэн голлох дүгнэлтүүдийг хийсэн байна.

Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх саналын хүрээнд тооцоо судалгаагүйгээр эх үүсвэр татаж, мөнгөн хөрөнгийн удирдлагыг зохисгүй хэрэгжүүлснээс их хэмжээний алдагдал хүлээсэн 3, төслийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт иж бүрэн бус, зээл олголтод мөрдөж буй дүрэм, журмын зохицуулалт хангалтгүй байсантай холбоотой 7 асуудлыг шилжүүлсэн.

Аудитын болон хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудлын мөрөөр үе шатны ажлыг гүйцэтгээгүйгээс аудитын ач холбогдлыг бууруулсан байна.

ҮАГ-аас аудитын дүнд суурилан Хөгжлийн банкны хуулиар тодорхойлсон зорилго, зорилтын хэрэгжилт хангалтгүйг тэмдэглэн УИХ-ын анхааралд 1, Хөгжлийн банкны ТУЗ-ийн даргад 2, гүйцэтгэх удирдлагад 6 бүлэг асуудлаар зөвлөмж хүргүүлсэн хэдий ч аудитын мөрөөр хийх үе шатны ажлууд бүрэн хэрэгжээгүй, аудитын үр нөлөөг тооцож ажиллаагүй байна.

ҮАГ-ын “Хязгаарлалттай” дүгнэлт гаргасан санхүүгийн тайлангийн аудитын мөрөөр давтан шалгалтын ажил хийгдээгүй байна.

Хөгжлийн банканд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 66 хуулийн этгээдийн 3.2 их наяд төгрөгийн үндсэн болон хүүгийн үлдэгдэлтэй, үүнээс хэвийн 27, анхаарал хандуулах 4, чанаргүй ангилалд 35 зээлдэгчтэй байсан бөгөөд нийт зээлийн үлдэгдлийн 18.3 хувьтай тэнцэх хэмжээний эрсдэлийн сан байгуулсан нь бодит байдалтай нийцэхгүй, журмын дагуу Үндэсний аудитын газрын тооцоолсноор 792.7 тэрбум төгрөгөөр нэмж байгуулах шаардлагатай байсныг тэмдэглэсэн.

Уг аудитаар нийт 983.1 тэрбум төгрөгийн 18 алдаа зөрчил илэрснээс 90.5 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 950.4 тэрбум төгрөгийн 12 алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 32.6 тэрбум төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж хүргүүлж, “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Зочин төлөөлөгчийн зардалд 9.2 сая төгрөг, баяр ёслол арга хэмжээний зардалд 22.6 сая төгрөг, спорт арга хэмжээний зардалд 12.3 сая төгрөг, хэвлэл мэдээллийн зардалд 46.4 сая төгрөг, нийт 90.5 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасныг тогтоосон.

Ажлаас чөлөөлөгдсөн 14 хүнд 192.0 сая төгрөгийн тэтгэмж, ажилтнуудад 98.0 сая төгрөгийн эрүүл мэндийн халамж, нийт 290.1 сая төгрөгийн тэтгэмжийн зардал олгосон нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 А-1/354 тоот “Албан даалгавар хүргүүлэх тухай”-д заасан хэмнэх зардлыг хэмнэж ажиллаагүй байсан байна.

### **УИХ-ын хяналт шалгалт**

Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж дүнг УИХ-д танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгээс (ажлын дэд хэсэг) төсөл, хөтөлбөр бүрээр газар дээрх хяналт, шалгалт, барьцаа хөрөнгийн магадалгаа хийж, зориулалт бусаар зарцуулсан 37 зээлийг АТГ-т шилжүүлэх, шалгах үеийн байдлаар үлдэгдэлтэй зээлийн хувьд зээл тус бүрээр авах арга хэмжээг ангилан тайландаа тусгасан байна.<sup>12</sup>

<sup>12</sup> ХӨГЖЛИЙН БАНКнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж дүнг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн ажлын тайлан, 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр

Төрийн өмчит компаниудын хувьд зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахад Засгийн газрын шууд болон шууд бус оролцоотойгоор хэрэгжүүлэхийг санал болгосон байна.

Хүснэгт 23 Төрийн өмчит компаниудын зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах санал

№	Зээлдэгчийн нэр	Зээлийн ангилал	Зээлийг зориулалтын дагуу ашигласан эсэх	Зээлийн үлдэгдэл /тбм.төг/		Шийдвэрлэсэн байдал
				Тухайн үеийн	2023.03.31	
1	ТОСК БУ-1 орон сууцны хороолол	Чанаргүй	Зориулалт нотлогдоогүй	75.3	-	Бэлэн мөнгө+Үнэт цаас
2	ТОСК БУ-2 орон сууцны хороолол	Чанаргүй	Зориулалт нотлогдоогүй	97.4	-	
3	ТОСК Шинэ Яармаг орон сууцны хороолол	Чанаргүй	Зориулалт нотлогдоогүй	107.1	-	Бэлэн мөнгө+ӨБҮХХ
4	ТОСК Хөдөлгөөнт	Чанаргүй	Зориулалтын дагуу	25.6	25.6	Шүүхэд хандсан
5	Эрчим хүчний яам - ТТЦ станц	Анхаарал хандуулах	Зориулалтын дагуу	46.3	60.4	-
6	Эгийн голын усан цахилгаан станц	Чанаргүй	Зориулалтын дагуу	43.9	58.6	
7	Эрдэнэс Монгол ХХК	Анхаарал хандуулах	Зориулалтын дагуу	152.4	43.9	Бэлэн төлөлт
8	ДЦС-4 ТӨХК	Хэвийн	Зориулалтын дагуу	248.4	274.3	-
9	Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК	Хэвийн	Зориулалтын дагуу	20.2	42.2	-
10	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК	Хэвийн	Зориулалтын дагуу	205.3	234.0	
11	Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ	Хэвийн	Зориулалтын дагуу	16.9	9.6	
12	МИАТ ТӨХК	Хэвийн	Зориулалтын дагуу	16.1	-	Бэлэн төлөлт
13	ДИ БИ ЭМ Лизинг ХХК	Хэвийн	Зориулалтын дагуу	0.4	-	Бэлэн төлөлт
	<b>Нийт</b>			<b>1,054.8</b>	<b>748.7</b>	

Монгол Улсын Их Хурлаас байгуулсан хяналт шалгалтын ажлын хэсгийн тайлагнал, үр дүнд суурилан Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн “Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон зээлийн өр төлбөрийг барагдуулах зарим арга хэмжээний тухай” 220 дугаар тогтоолоор төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн тус банкнаас авсан зээлийн өр төлбөрийг барагдуулах арга хэмжээг зээлдэгч бүрээр шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг нэр заан холбогдох албан тушаалтан, хуулийн этгээдэд даалган ажилласан байна. Гэвч Засгийн газрын 220 дугаар тогтоолоор шийдвэрлэхээр чиглэл өгсөн төрийн хэвшлийн зээлдэгч нарийн зээлийн ашиглалт, зарцуулалтад нарийвчилсан хяналт хийх шаардлагатай байсан.

### Хяналт шалгалтуудын хэрэгжилт

Тус банкны үйл ажиллагаанд 2020-2022 оны байдлаар УИХ, YAГ, Монгол банк, Сангийн яам зэрэг төрийн байгууллага болон хөндлөнгийн аудитын “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК зэрэг эрх бүхий байгууллагаас хяналт шалгалт, аудит хийж нийт 154 зөвлөмжийг өгснөөс 64 буюу 41.6 хувь нь биелж, 90 буюу 58.4 хувь нь биелээгүй нь ТУЗ болон дотоод аудитын хорооноос зөвлөмж хэрэгжүүлэх, шийдэл чиглэлийг тухай бүр гаргаагүйтэй холбоотой байна.

Эрх бүхий байгууллагаас хийгдсэн хяналт шалгалт, аудитын зөвлөмжийн хэрэгжилт, биелэлтийг холбогдох байгууллагад дараах хугацаанд хүргүүлж, харин 2020 онд Сангийн яам болон Монголбанкны хамтарсан шалгалтын ажлын хэсэг нь хяналт шалгалтын тайланг тус банканд ирүүлээгүйгээс зөвлөмжийн хэрэгжилтийг тайлагнаагүй байна.

Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх Монгол Улсын Засгийн газар, Монгол банк болон аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж дүнг УИХ-д танилцуулах үүрэг бүхий “Ажлын хэсэг” УИХ-ын даргын 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 20 дугаар захирамжаар байгуулагдаж, тус банкны санхүүгийн болон зээлийн үлдэгдэл, холбогдох мэдээллийг 2021 оны тайлант хугацаагаар тасалбар болгож хяналт шалгалтыг гүйцэтгэсэн байна.

УИХ-ын 2022 оны 20 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хяналтын тайланд 22 анхаарах асуудал, 33 санал зөвлөмж, Засгийн газрын түвшинд шийдвэрлэх шаардлагатай 53 зээлдэгчийн 2,425.9 тэрбум төгрөгийн зээлийн үүргийг хангуулах зөвлөмж гаргасан ч санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх хугацааг тодорхой заагаагүй байна. Үүнд:



- Төрөөс хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээнд анхаарах 3 асуудалд 3 санал зөвлөмж,
- Засаглал, бүтэц зохион байгуулалт хүний нөөцийн анхаарах 6 асуудалд 7 санал, зөвлөмж,
- Зээлийн үйл ажиллагаанд анхаарах 9 анхаарах асуудалд 13 санал, зөвлөмж,
- Барьцаа хөрөнгийн анхаарах 2 асуудалд 2 санал, зөвлөмж,
- Хөгжлийн банкны санхүүгийн нөхцөл байдал, санхүүгийн удирдлагын анхаарах 2 асуудалд 2 санал зөвлөмж,
- "Төрийн өмчит компаниуд"-ын зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах 13 зээлдэгчийн 1,054.8 тэрбум, "Хувийн хэвшлийн компаниуд"-ын зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах 30 зээлдэгчийн 1,092.1 тэрбум, Авлигатай тэмцэх газар шалгагдаж байгаа 10 зээлийн 278.5 тэрбум төгрөгийн зээлийг Засгийн газрын түвшинд шийдвэрлэх шаардлагатай гэж тус тус заасан байна.

УИХ-ын 2022 оны 20 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хяналтаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар авч үзэхэд 33 санал зөвлөмжөөс "Засгийн газар цаашид дэд бүтцийн салбар дахь бодлогын тогтвортой байдлыг хангах" санал, зөвлөмжийг Засгийн газарт өгсөн нь тус банкнаас хэрэгжилтийг тайлагнаагүй байна. Тайлагнасан 32 санал, зөвлөмжөөс 9 буюу 27.3 хувь хэрэгжсэн, 14 буюу 43.8 хувь нь хэрэгжиж байгаа, 4 буюу 12.5 хувь хэрэгжих шатанд, 5 буюу 15.6 хувь хэрэгжээгүй, санал зөвлөмжийн биелэлт 27.3 хувьтай байна.

Зээлийн эргэн төлөлт нь зөрчилтэй зээлдэгчдийн эрсдэл өндөр тул хувийн хөрөнгө оруулалтын сангууд хамтран ажиллах сонирхолгүй, зээл авсан компаниудын орлогын болон зарлагын гүйлгээг хянах зорилгоор "Corporate gateway" нэвтрүүлэх саналыг арилжааны банкнуудад хүргүүлсэн ч хариу ирүүлээгүй, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн

8.1.46 дэх заалт хэрэгжээгүй, "Актив удирдлагын компанийн тухай" хуулийн төсөл дэмжигдээгүй зэрэг шалтгаанаас дараах 5 санал, зөвлөмж хэрэгжээгүй байна. Үүнд:

#### **Хэрэгжээгүй санал, зөвлөмж:**

1. "Хувийн хөрөнгө оруулалтын сангуудтай санхүүжилт олгох, зээлийг худалдаж авах, зарах чиглэлээр хамтран ажиллах" ... хувийн хөрөнгө оруулалтын сангууд зөрчилтэй зээлдэгчдийн эрсдэл өндөр гэж үздэг тул хамтран ажиллах сонирхолгүй
2. "Хөгжлийн банканд зээл авсан компаниудын орлогын болон зарлагын гүйлгээг нь хянах боломж олгох"...зээл авсан компаниудын орлогын болон зарлагын гүйлгээг хянах зорилгоор "Corporate gateway" нэвтрүүлэх, арилжааны банкнуудад хамтран ажиллах тухай санал хүргүүлсэн ч хариу ирүүлээгүй,
3. "Хөгжлийн банкнаас төрийн өмчит компанид зээл олгоход байгуулж буй зээлийн барьцааны гэрээг холбогдох хуульд нийцтэй болгож өөрчлөх"... төрийн өмчийг барьцаалахтай холбоотой Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8.1.4 дахь заалт хэрэгждэггүй,
4. "Төрийн өмчит үйлдвэрийн газар, компанид зээл олгох, эд хөрөнгийг барьцаалах шаардлагыг тусгасан хуулийн заалтын хэрэгжилтийг хангуулж ажиллах" ... төрийн өмчийг барьцаалахтай холбоотой Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8.1.4 дахь заалт хэрэгждэггүй,
5. "Активын удирдлагын компани байгуулж, зээлийг эрсдэл, хугацаа, хэмжээ, зориулалтаар нь ангилан үе шаттай худалдаж авах, зарах боломжийг олгох, хуримтлуулсан мөнгөн хөрөнгөөр төслүүдэд тодорхой дэмжлэг үзүүлэх, улмаар зээлийн эргэн төлөлтийг хангуулах" ..."Актив удирдлагын компанийн тухай" хуулийн төсөл боловсруулах шатанд дэмжигдээгүй байна

Тус банк нь "Зээлийн бодлого" болон "Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх шийдвэр гаргах журам"-ыг ТУЗ-д танилцуулж, ЗГ-ын 2022 оны 220 дугаар тогтоолын хүрээнд эргэн төлөлт хийгдээгүй, чанаргүй ангилалд хамаарах зарим зээлийг хууль, шүүхийн байгууллагатай хамтран, шүүхийн бус журмаар зээлийг төлүүлж байгаа ч дараах төслүүд хэрэгжих шатанд байна.

#### **Хэрэгжих шатанд байгаа санал, зөвлөмж:**

1. "Хөгжлийн банкны тухай хуулийн 10.1 дэх хэсэгт заасан Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл хөтөлбөрт тавигдах шаардлагыг хангасан эсэхийг үнэлэх, дүгнэлт өгөх тодорхой шалгуур, аргачлал, зааврыг шинэчилж мөрдөх" ..."Зээлийн бодлого", "Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх шийдвэр гаргах журам"-ын шинэчилсэн найруулгын төсөлд Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх

- төсөл хөтөлбөрт тавигдах шаардлагыг нэмэгдүүлж, түүнд үнэлэлт дүгнэлт өгөх шалгуур, аргачлал, зааврыг тусгасан,
2. *“Найдваргүй болсон зээлдэгчийн хувьд зээлийн гэрээний нөхцөлийг өөрчлөх замаар төслийн мөнгөн урсгалд үндэслэн зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах, сунгах болон бүтцийн өөрчлөлт хийх, зээлийн хэлбэрийг өөрчлөх, барьцаа нэмэгдүүлэх шаардлага тавих зэрэг арга хэлбэрийг судалж, зохион байгуулах арга хэмжээ авсны эцэст шүүхээр шийдвэрлүүлэх хувилбарт шилжиж байх”...* шүүхийн бус журмаар зээлийг төлүүлэх ажиллагаагаар 4 зээлдэгчдийн зээлүүд хаагдсан ч төрийн өмч болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зээл “Эгийн голын усан цахилгаан станц” төсөл, “Таван толгойн дулааны цахилгаан станц” төсөл, ТОСК “хөдөлгөөнт цогцолбор” зэрэг зээлүүдэд төлөгдөөгүй,
  3. *“Санхүүгийн хүндрэлд орсон, зээлийн эргэн төлөлт нь олон сарын зөрчилтэй зээлдэгчийн төсөл хэвийн явагдах үндэслэлтэй гэж үзвэл төсөл хэрэгжүүлж буй бизнесийг үнэлэх, нэгтгэх, нийлүүлэх, зарах боломжийг олгох; Хувийн хөрөнгө оруулалтын сангуудтай санхүүжилт олгох, зээлийг худалдаж авах, зарах чиглэлээр хамтран ажиллах” ...* шүүхийн бус журмаар зээлийг төлүүлэх,
  4. *“Төсөл хэвийн явагдах үндэслэлтэй гэж үзвэл төсөл хэрэгжүүлж буй бизнесийг үнэлэх, нэгтгэх, нийлүүлэх, зарах боломжийг олгох”...* шүүхийн бус журмаар зээлийг төлүүлэх ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Хянан шалгах Түр хороо”-ны тус банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц, байдалд үнэлэлт, дүгнэлт гаргасан тайлан УИХ-ын цахим хуудсанд 2023 оны 04 сарын 21-нд байршсанаар олон нийтэд нээлттэй болж, уг тайлангаар 3 саналд үндэслэсэн дараах 4 хэсэгт 11 зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

1. *Банкны үйл ажиллагааны чиглэлийг олон улсын сайн туршлагад нийцүүлэх, Компанийн засаглалын зохистой зарчмыг хэрэгжүүлэх, төрийн томилгоог халах, Банкны хяналт шалгалтын тогтолцоог олон улсын банк, санхүүгийн тогтолцоо, стандарт, дүрэм журамтай нийцүүлэх, хууль тогтоомж, журам зааварт өөрчлөлт оруулах тухай 4,*
2. *Санхүүгийн өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт хийх, активын чанарын үнэлгээг гаргах, эх үүсвэрийн эргэн төлөлт, балансын бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг боловсруулах, Зах зээлийн эрсдэлийн хэм хэмжээг тогтоож, актив, пассивын хугацааны болон хүүгийн шинжилгээг нарийвчлан хийх, бизнес загварын хувьд дахин өөрчлөн байгуулалт хийх, шаардлагатай бол үйл ажиллагааг төрөлжүүлэх чиглэлээр 2,*
3. *Банкны засаглалын бодлого, Эрсдэлийн бодлогыг боловсруулан баталж, хэрэгжүүлэх болон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх, Банкны үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг мэргэжлийн түвшинд сонирхлын зөрчилгүй, хараат бус байдлаар шийдвэрлэх чадвартай ТУЗ-ийн гишүүдийг томилох; ТУЗ-ийн гишүүдтэй гэрээ байгуулах, Гүйцэтгэх удирдлагын багийг багаар нь сонгон шалгаруулж, гэрээ хийн үнэлэлт дүгнэлт хийн ажилладаг байх тухай 3,*
4. *Олон улсын жишгээр хөгжлийн банкны 72 хувь нь Төв банкны, 28 хувь нь Засгийн газрын хяналтад байгааг харгалзан үр ашигтай, зохистой хяналтын тогтолцоог бий болгох, Банкны хяналт шалгалтын тогтолцоог олон улсын банк, санхүүгийн стандартад нийцүүлж, энэ хүрээнд холбогдох эрх зүйн орчин, дүрэм журмуудыг тогтоох тухай 2 зөвлөмжийг тус тус өгсөн байна.*

Тус банкнаас Улсын Их Хурлын 2022 оны 14 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Хянан шалгах Түр хороо”-ноос өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар авч үзэхэд 10 зөвлөмж хэрэгжиж буй, 1 зөвлөмж хэрэгжээгүй, биелэлт 40 хувьтай боловч төлөвлөгөөний хэрэгжиж дуусах хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт тодорхойгүй байна. Тухайлбал:

*Тус банкны гүйцэтгэх удирдлагаас банкны алдаа сургамж, цаашид авах шаардлагатай арга хэмжээний талаар Хөгжлийн банкны хууль, эрх зүйн орчин, сайжруулалт, Банкны засаглал, удирдлага, Санхүүжилтийн үйл ажиллагаа, Зохицуулалт, хяналтын тогтолцоо ба эрсдэлийн удирдлага, Банкны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, Бусад орны хөгжлийн банкууд гэсэн 6 бүлэг асуудал болгон Хувьцаа эзэмшигчдэд 2023.04.06-нд 2/410 тоотоор хүргүүлсэн.*

*Азийн хөгжлийн банкнаас Худалдааны санхүүжилт, Компанийн засаглал, Төслийн санхүүжилт, СТОУС-9 нэвтрүүлэх чиглэлээр техникийн тусалцаа авах санал хүргүүлсэн<sup>7</sup> бөгөөд Азийн Хөгжлийн Банкнаас техникийн тусалцааг 2024 онд эхлүүлэхээр төлөвлөж /Азийн хөгжлийн банкны техник тусалцааны хүрээнд бодлогын чанартай томоохон санал, зөвлөмжүүд гарснаар Банкны бизнес загвар тодорхой болж, холбогдох дүрэм журмуудад өөрчлөлт хийх/ байна.*

МУХБ болон “Обзервстар” ХХК-ийн хооронд байгуулсан “Авлигын эсрэг менежментийн тогтолцооны олон улсын стандарт ISO37001-ийг нэвтрүүлэх гэрээг 2023 оны 10 сарын 25-нд байгуулсан байна,

МУХБ болон “Инфосек Интелиженс” ХХК-ийн хооронд Монгол Улсын хөгжлийн банканд нээгдсэн менежментийн тогтолцоо ISO27001-ийг нэвтрүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх” гэрээг 2023 оны 10 сарын 05-нд байгуулсан байна,

Сангийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 121 тоот тушаалаар байгуулагдсан “Ажлын хэсэг” тус банкны ТУЗ-ийн ердийн гишүүний сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, ТУЗ-ын гишүүдийг санал хураалтаар сонгон шалгаруулж томилсон байна.

УИХ-ын 2016 оны 12 сарын 28-ны өдрийн 81 дүгээр тогтоолоор Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банк хооронд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй үүссэн өр, авлагын тооцоог 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон харилцан суутгах замаар эцэслэн шийдвэрлэх чиглэлийг гаргасан байна.

Хөгжлийн банкнаас ҮАГ-аас хийсэн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг ҮАГ-т 2023 оны 5 сарын 03-ны өдрийн 3/511 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг тайлагнасан байна. Үүнд:

Нийт 7 зөвлөмж өгснөөс 5 зөвлөмж хэрэгжиж, 2 зөвлөмж хэрэгжих шатанд, 15 албан шаардлага өгснөөс 5 хэрэгжсэн, 5 хэрэгжих шатанд, 1 хэрэгжилт хангалтгүй, 4 хэрэгжээгүй, 90.5 сая төгрөгийн төлбөрийн акт барагдсан.

Харин Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолоор зээлийн өр төлбөрийн барагдуулах шийдвэр гаргасан ч ҮАГ-аас өгсөн албан шаардлагын хэрэгжилтээс тодорхой үр дүн гараагүй байна. Тухайлбал :

“Ди Би Эм Ассет менежмент ҮЦК” ХХК болон “Дархан арьс ширний цогцолбор” ХХК хооронд байгуулсан гэрээний дагуу нийт 6,488.4 сая төгрөгийн зээлийн төлбөр төлөгдөөгүй, зээлдэгчээр зээлийн гэрээний үүргийг биелүүлж ажиллаагүй гэх албан шаардлагын дагуу ХХААХҮЯ-ны харьяа “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт” ТӨХХК-д шилжүүлэн өгөх замаар өр төлбөрийг барагдуулах хэлэлцээрийг “Дархан арьс ширний цогцолбор” ХХК болон ХХААХҮЯ-тай хийсэн ч тодорхой үр дүнд хүрээгүй, банкнаас Авлигатай тэмцэх газарт хандаж хохирогч, иргэний нэхэмжлэгчээр тогтоолгох хүсэлт гаргасан;

Хөгжлийн банк нь бие даан шийдвэрлэх эсвэл төрийн бусад байгууллагуудын адил тогтоол шийдвэр журмын хэрэгжилтийг дагаж мөрддөг байх эсэхийг нэг талд нь гаргаж шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна гэсэн албан шаардлага биелэгдээгүй, Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн хүрээнд ТӨБЗГ-аас ирсэн албан бичиг, Засгийн газрын шийдвэрийн хүрээнд хөрөнгийг шилжүүлсэн байна;

“Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор” зээлийг Засгийн газрын 2016 оны 60 дугаар тогтоолоор Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэлд “Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор”-ын тоног төхөөрөмжийг худалдан авахад зориулж ТОСК ТӨҮГ-аар дамжуулан 2016 онд 7,055.255 ам.долларын зээлийг олгосон. Засгийн газрын 2017 оны 48 дугаар тогтоолоор уг тоног төхөөрөмжийг худалдан авахад зориулж олгосон нийт 25,649.9 сая төгрөгийг, үүнээс зээл, зээлийн хүү нийт 10.4 сая ам.доллар, 153.1 сая төгрөгийг улсын төсөвт тусгах, Батлан хамгаалах яамны баланст шилжүүлэхээр заасан боловч уг тогтоолыг хэрэгжүүлээгүй байна.

2017 онд тус банкнаас “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-д 10.6 сая ам.долларын зээлийг хэсэгчлэн олгосон ба зээлийн хугацаа 2021 онд дуусгавар болж зээл, зээлийн хүү, торгуулийн төлбөр нийт 15.0 сая ам.долларын 43,038.3 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байна.

Засгийн газрын 2013 оны 80 тогтоолыг үндэслэн “Тавантолгойн цахилгаан станц” төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангахад тус банкнаас эхний ээлжид 1.9 сая ам.долларын зээл олгож,

Засгийн газрын 2014 оны 261 дүгээр тогтоолын дагуу дахин нийт 15.9 сая долларын зээл олгосон байна. Зээлийн хугацаа 2022 оны 6 сард дууссан ч гэрээнд заасан хугацаанд зээлийн төлөлт хийгдээгүй байна.

Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 155 дугаар тогтоолоор “Ди Би Эм Ассет менежмент ҮЦК” ХХК болон “Ди Би Эм лизинг” ХХК-ийг татан буулгаж, 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 252 дугаар тогтоолоор 2 охин компанийг татан буулгах ажиллагааг зогсоож, үйл ажиллагааг сэргээхийг Хөгжлийн банканд даалгаж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 08 дугаар шийдвэрээр дүрмийг дахин баталж, компанийн үйл ажиллагаа сэргэсэн байна.

ҮАГ-аас 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 5 зөвлөмж, 1 албан шаардлагыг тус банканд өгч 2023 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 5/920 тоот албан бичгээр албан шаардлагын хэрэгжилтийг ҮАГ болон Сангийн яаманд хүргүүлж тайлагнасан байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 12 дугаар сарын А/336 дугаар тушаалаар Хөгжлийн банканд хийсэн хяналт шалгалтын дүнг баталж, 13 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг ТУЗ, гүйцэтгэх захирал нарт үүрэг болгож, 8 зөвлөмж хэрэгжиж, 5 зөвлөмж хэрэгжих шатандаа байна. Тухайлбал:

#### **Хэрэгжих шатанд байгаа зөвлөмж:**

- Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл хөтөлбөрт тавигдах шаардлагыг хангасан эсэхийг үнэлэх, дүгнэлт өгөх тодорхой шалгуур, аргачлал, зааврыг шинэчилж, мөрдөх зөвлөмжийн хүрээнд “Санхүүжилтийн бодлого”-ын төслийг боловсруулж гүйцэтгэх удирдлагад танилцуулж баталгаажуулан ТУЗ-д хүргүүлсэн. Учир нь энэхүү баримт бичиг нь Хөгжлийн банкны тухай хуулийн дагуу ТУЗ-ийн шийдвэрлэх, батлах хүрээний асуудал бөгөөд ТУЗ нь уг бодлогын төслийг Хөгжлийн банкны хуулийн шинэчлэлтэй уялдуулан сайжруулах чиглэл өгсөн тул хүлээгдэж байна.
- Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасан шаардлага хангасан төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхдээ гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчидтай хамтран санхүүжүүлэх заалтыг хангасан эсэхийг үнэлэх, дүгнэлт өгөх тодорхой шалгуур, аргачлал, зааврыг шинэчилж, мөрдөх зөвлөмжийн хүрээнд Хөгжлийн банкны “Зээлийн бодлого” болон “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх шийдвэр гаргах журам”-ын шинэчилсэн найруулгын төсөлд Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл хөтөлбөрт тавигдах шаардлагыг нэмэгдүүлж, түүнд үнэлэлт дүгнэлт өгөх шалгуур, аргачлал, зааврыг нарийвчлан тусгасан байна.

#### **Дотоод хяналт**

Дотоод хяналтын тогтолцооны хэрэгжилтийн үр нөлөөний үнэлгээ нь банкны дотоод хяналтын тогтолцоо (түүний бүрдэл хэсгүүд) болон үндсэн ойлголтуудын хэмжээнд үндэслэн хийгдсэн:

- Тогтолцоо нь байгууллагын бүх хэсэгт хэрэгжсэн эсэх, нэг, хоёр, гурав дугаар түвшний хяналтын үүрэг, хариуцлагыг нарийн тодорхойлсон эсэх
- Банк нь хараат бус дотоод хяналтын чиг үүргийг бий болгосон эсэх
- Дотоод хяналтын систем, эрсдэлийн удирдлагын тогтолцоо, байгууллагын засаглал болон нийцлийн байнгын тайлагнал хийгддэг эсэх;
- Байгууллага нь нийцлийн бодлоготой эсэх, удирдлагын зөвлөлд тогтмол хугацаанд үр дүнтэйгээр тайлагнадаг нийцлийн чиг үүрэгтэй эсэх

Дотоод аудитын дүрэм, ТУЗ болон Аудит, Эрсдэлийн хорооны хурлын тэмдэглэл болон 2017 онд гүйцэтгэгдсэн дотоод аудитын тайлангуудыг түүвэрлэн судалж үзэхэд дотоод аудит нь хараат бусаар, олон улсын стандарт, шаардлагын дагуу үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг

байжээ.

Гэвч дотоод аудит нь эрсдэлд суурилсан аудитын төлөвлөгөөндөө эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, нийцлийн болон засаглалын асуудлууд зэрэг бүх шаардлагатай асуудлуудыг хамруулсан эсэхийг нягтлан үзээд дотоод хяналтын системийг сайжруулах талаар санал зөвлөмжийг үүгээр өгч байна.

Хүснэгт 24: Дотоод хяналтын систем, аудитын чиг үүргийн үр дүн, санал зөвлөмжүүд

Д/д	Харгалзах стандарт болон удирдамж	Үр дүн	Санал зөвлөмж
1	<b>Зарчим 6 (БХШБХ д223)</b> Дотоод аудитын газрын захирал нь олон жилийн аудитын төлөвлөгөөний хэсэг болох жилийн аудитын төлөвлөгөөг боловсруулах үүрэгтэй. Аудитын төлөвлөгөө нь найдвартай эрсдэлийн удирдлагад (ТУЗ болон гүйцэтгэх удирдлагаас өгсөн чиглэл) үндэслэх хэрэгтэй бөгөөд хамгийн багадаа жил бүр шинэчлэгдэх хэрэгтэй.	Олон жилийн аудитын төлөвлөгөөг боловсруулаагүй.  Дотоод аудитын төлөвлөгөө нь эрсдэлийн үнэлгээнд үндэслээгүй (эрсдэлийн зураглал байхгүй учраас хэсэгчлэн).	Банк нь эрсдэлийн үнэлгээ болон гүйцэтгэх захирлаас өгсөн чиглэлд үндэслэн олон жилийн дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулах хэрэгтэй.
2	<b>Зарчим 6 (БХШБХ д223)</b> Банкны аливаа үйл ажиллагаа болон аж ахуй нэгж нь дотоод аудитын чиглэлийн хувьд нэгдсэн хүрээнд хамрагдах хэрэгтэй.	Засаж сайжруулах арга хэмжээний биелэлтийн үнэлээг Гүйцэтгэх захиралд шууд тайлагнах нь (Үнэлгээ, мониторингийн алба) 2-р түвшний хяналтын хариуцлага юм.  Салбар компаниуд нь дотоод аудитын болон дотоод хяналтын систем /Эрсдэл/ засаглалын тайланд (2018 оныг оролцуулан) хамрагдаагүй байсан.	Дотоод аудит нь хараат бус дүгнэлт гаргахын тулд засаж сайжруулах арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх хэрэгтэй.  Дотоод аудитыг төлөвлөгөө нь салбар компаниудад хийх үнэлгээг хамрах хэрэгтэй.
3	<b>Зарчим 7 (БХШБХ д223)</b> Хяналтын чиг үүргийн хувьд ТУЗ нь дотоод аудитын үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянах хэрэгтэй. ТУЗ нь тухай бүр дотоод аудитын үйл ажиллагаанд хараат бус хөндлөнгийн чанарын баталгаажуулалтыг хийлгэхийг авч үзэх хэрэгтэй.	2012-2017 онуудад дотоод аудитын үйл ажиллагаанд хараат бус хөндлөнгийн чанарын баталгаажуулалт хийгдээгүй.	Банк нь дунд хугацааны давтамжтайгаар (5 жил) чанарын баталгаажуулалтын хяналтыг хийлгэж байхаар авч үзэх хэрэгтэй.

Дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын тогтолцоо (чанар болон үр дүнтэй байдал)-нд гарсан дээр дурдсан зөрүүтэй байдлуудад ТУЗ нь эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын систем, байгууллагын засаглал болон түүний хэрэгжүүлэлтэд эцсийн хариуцлага хүлээдэг хэдий ч эдгээрийн хяналт, хэрэгжүүлэлтэд хангалттай хэмжээнд оролцож ажиллаагүй байна.

Дэлхийн банкны судалгаагаар олон улсад үйл ажиллагаа явуулж байгаа Хөгжлийн банкнуудын 72 хувь банкны хяналт шалгалтын зохицуулагч гол байгууллага болох Төв банкны хяналтаар хэрэгждэг, 28 хувь Засгийн газрын агентаар хэрэгждэг бол олон улсын Хөгжлийн банкнуудын 78 орчим хувь Базелийн хяналт шалгалтын үндсэн стандартын дагуу хэрэгждэг байна.

Олон улсын Хөгжлийн банкны хувь нийлүүлэгч, хяналт тавьдаг байгууллага тусдаа байдаг, бие даасан хяналт шалгалтын тогтолцоотой байхаас гадна Хөгжлийн банканд хяналт тавих асуудал нь арилжааны банканд тавих хяналтаас ихээхэн ялгаатай буюу энэ нь хэт их зохицуулалтад орохыг хүсдэггүй, төрийн ашиг сонирхол илүүтэй, дотоод хяналтын тогтолцоо сул байдагтай холбоотой юм.

Үүнтэй холбоотойгоор олон улсын жишигт нийцсэн байдлаар тус банкны үйл ажиллагаанд тавигдах хяналт шалгалтын ажлын үр нөлөө сул байсан байна

Эрх бүхий байгууллагын тухайлсан шалгалт, аудитын хуулийн этгээдийн баталгаажуулах аудитын үр нөлөөт байдал дараагийн шатандаа ахиц дэвшлээр үнэлэгдэх учиртай ч хангалттай баримт алга байна.

Эрх бүхий байгууллагын хяналт шалгалтын үр нөлөө хангалттай түвшинд байж чадаагүй, нөгөө талаас дурдсан байгууллагуудын тусгайлсан, нарийвчилсан, өргөтгөсөн, хэсэгчилсэн зэрэг шалгалтуудын мөрөөр давтан хийсэн болон ээлжит хяналт шалгалтын үеэр өмнөх шалгалтын илрүүлэлт, алдаа зөрчлийг хэрхэн арилгасан талаар үндсэндээ хянаж байгаагүй байна.

Хяналт шалгалтын үр дүн, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлсэн учир холбогдолтой, бодит нөхцөл байдлыг илтгэх хангалттай нотлох зүйл олдоогүй, хууль тогтоомжид заасан Хөгжлийн банкны үйл ажиллагаанд тавих төрийн хяналтын чиг үүрэг хангалтгүй хэрэгжиж ирсэн байна.

### 3.6. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн зургаадугаар бүлэг. Санхүүгийн тайлагнал, ил тод байдалд хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:

Үнэлэх хэсэг: Тав дүгээр бүлэг. Хөгжлийн банкны хяналтын тогтолцоо, үйл ажиллагааны хязгаарлалт

- |                             |   |
|-----------------------------|---|
| Томьёолсон шалгуур үзүүлэлт | - Олон улсын сайн туршлагад нийцсэн эсэх? |
|                             | - Хэрэгжих боломжтой байсан эсэх?         |
|                             | - Үр дүнд хүрч байсан эсэх?               |

Хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн зургаадугаар бүлэг нь дараах агуулгатай 2 зүйлээс бүрдэнэ. Үүнд:

29 дүгээр зүйл. Санхүүгийн тайлагнал  
30 дугаар зүйл. Ил тод байдал

Энэ бүлгийн хэрэгжилтэд үнэлгээ хийхдээ зүйл бүрээр нь бус Хөгжлийн банк үүсгэн байгуулагдсан цагаас хойш гарсан эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлсэн хяналт шалгалтууд тэдгээрийн тайлангаас өгсөн дүгнэлт зөвлөмжүүдийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээлэлд үндэслэн бүхэлд нь хийж гүйцэтгэлээ.

#### Санхүүгийн тайлагнал

Хөгжлийн банк үүсгэн байгуулагдсанаас хойш жил бүрийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн байдлын тайлагналд Улаанбаатар аудит ХХК /1/, DELOITTE /3/, PWC /3/, KPMG /4/ аудитыг гэрээний үндсэн дээр тус тус гүйцэтгэсэн байна.

Хөгжлийн банкны санхүүгийн үйл ажиллагаанд хараат бус хөндлөнгийн аудитын этгээдээс гүйцэтгэсэн аудитын дүн, удирдлагад хүргүүлэх захидалд зээлийн багцын хурдацтай өсөлттэй уялдсан үүсэж болзошгүй эрсдэл бий болохыг, үнэ цэний бууралт, чанаргүйдлээс урьдчилан сэргийлсэн горим тогтолцоог нэвтрүүлэх тухай (2013 оноос эхлэлтэй) зохих зөвлөмж өгч байсан.

Тус банкны 2011-2021 оны санхүүгийн жилийн дуусгавар болгосон санхүүгийн байдалд аудит хийлгэсэн байдлаас үзэхэд дээрх аудитын хуулийн этгээдээс 119 асуудлаар нийт 266 зөвлөмжийг удирдлагын захидлаар хүргүүлсэн байна.

Аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн хөндлөнгийн аудитын дүгнэлт, удирдлагын захидалд дурдсан аудитын ажлын дүн, ажиглалтад тулгуурлан гаргасан санал, зөвлөмжөөс тус банкны засаглах үйл ажиллагааны эрсдэл болон зээлийн орчинтой холбоотой талбаруудад

хэрэгжсэн горим, үйл ажиллагаа, нөхцөл байдлыг авч үзсэн.

Банкны санхүүгийн тайланд Улаанбаатар аудит ХХК нэг удаа, DELOITTE, PWC, KPMG зэрэг аудитын хуулийн этгээд тус бүр 3-4 удаа давтамжтай аудитыг гүйцэтгэж, онилсон бүлэг асуудлын хураангуй, мөн түүний нөлөөллийг тооцооноор дараах чиглэлд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй байж үр нөлөөг сайжруулах шаардлагатай нь ажиглагдсан болно.

Талбар	Болзошгүй үр дагаврын эсрэг эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх шаардлагатай
Зээлийн эргэн төлөгдөх магадлал болон ирээдүйн мөнгөн урсгалын шинжилгээ	Зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн хэмжээг тохиромжгүй хэмжээгээр тогтоох, санг хянах боломжгүй болох;
Тухайлсан зээлийн төсөөллийн эргэн шалгалт	Эргэн шалгалтын горимыг дэмжих баримтжуулалт дутагдалтай байдал нь үнэ цэний бууралт юунаас үүссэн эсэхийг хянах, буцаан шалгах үр дүнд хүндрэл учруулж болзошгүй болох;
Зээлийн шалгуур үзүүлэлтийн харьцааны тооцоолол	Тооцооллын буруу үйлдэл нь гэрээний зөрчлийг давхар үүсгэх, банкны нэр хүнд сулрах;
Барьцаа хөрөнгийн хөндлөнгийн үнэлгээ	Хараат, туршлагагүй үнэлгээ нь үнэлгээ тохиромжгүй байдлаар үнэлэгдэх, улмаар эрсдэлийн сан буруу тооцох, удирдлагын шийдвэр буруу гарах;
Арилжааны банкнуудын барьцаа	Барьцаа хөрөнгийн шаардлага хангаагүйгээс материаллаг хэмжээний алдагдалд хүргэж болзошгүй;
Үнэ цэний бууралтын нөөцийн бүлгийн үнэлгээний тооцоолол	Эрсдэлийн санг илүү, эсхүл дутуу байгуулах эрсдэл үүсгэх, Үнэлгээний тооцоолол эсхүл тооцоолох арга зүй зөрүүтэй, тооцооллыг хийхдээ 1.5 хувиар тооцоолдог нь Монголбанкны журам, заавар болон түүхэн мэдээлэл, бусад үнэлгээтэй нийцэхгүй;
Зээлдэгчдийн аудитлагдсан санхүүгийн тайлан	Зээлдэгчийн талаар буруу шийдвэр гаргах эрсдэл үүсэх, Зээлдэгчийн СТОУС-ын дагуу аудитлагдаагүй тайлан авч байгаа нь санхүүгийн үзүүлэлт ил тод бус, хангалттай мэдээллийг агуулдаггүй;
Санхүүжүүлсэн төслүүдийг хянах хараат бус хянан шалгагч	Хуулийн нийцэл буюу ХӨГЖЛИЙН БАНКны хуулиар тодорхойлогдсон зорилго, зорилтод нийцсэн төслийн санхүүжилтийн үр ашиг хангагдахгүйд хүрэх;
Зээлийн ирээдүйн мөнгөн урсгалын төсөөлөл	Зээлийн мөнгөн урсгалын төсөөлөл, ялгаатай хувилбаруудын нөлөөллийн шинжилгээг дэмжих мэдээлэл дутмагаас эрсдэлийн сан байгуулах, хянахад хүндрэлтэй байх.

Үйл ажиллагааны дотоод орчин, сайн засаглалаас гадна зээл, зээлийн орчинтой холбоотой гол асуудлын хувьд эрсдэл тогтмол “Дунд”-аас “Өндөр” гэсэн түвшинд үнэлэгдэж байсан.

Ихэнх тохиолдолд удирдлагын захидлаар хүргэгдсэн зөвлөмжид “Өмнөх жилийн аудит”-ын хүрээний “зээлийн орчин”-той ажиглалт, түүнд суурилсан “зөвлөмж” давтагдсан нь зөвлөмжийн дагуу авсан гэх хариу арга хэмжээний үр дүн төдийлөн гараагүй хэвээр хадгалагдсан, уламжлалт эрсдэл бодитойгоор оршиж ирсэн байна.

Хөгжлийн банкны 2011-2021 он хүртэл жил бүрийн санхүүгийн тайлагналд аудит хийж, өгсөн зөвлөмжид өмнөх жилийн аудитын хүрээнд ижил төсөөтэй агуулга бүхий, горим, арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг удирдлагын захидлаар хүргүүлж байсныг харж болно.

Аудитын хуулийн этгээдийн өгсөн гол асуудлаарх зөвлөмж, өмнөх жилийн аудитын хүрээнд ижил төстэй агуулгаар бичигдэж байсан нь тухайн үеийн банкны удирдлагаас хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний гүйцэтгэл хангалтгүй байсныг гэрчилнэ.

Аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн хараат бус аудиторын тайлан, тухайн үед удирдлагын захидлаар хүргүүлж байсан зөвлөмжийн агуулга хэрэгжилтийг дараах байдлаар үнэлж байна. Үүнд:

Гол асуудал нь:

- Аудитын хуулийн этгээдээс хийсэн аудитын дүнд өгсөн удирдлагын захидалд дурдсан асуудлууд нь банкны үйл ажиллагааг хэвийн үр ашигтай горимоор явуулж, үйл ажиллагааны хувьд томоохон сайжралыг олж авахуйц давуу талыг олгож байсан.

- Аудитын хуулийн этгээдээс Хөгжлийн банканд хүргүүлсэн жил бүрийн аудитын удирдлагын захидалд үүсэж болзошгүй нөхцөл байдлаас сэргийлсэн горим, тогтолцоог бий болгох хангалттай хэмжээний зөвлөмжийг давтан аудитаар өгч байсан.
- Давтан буюу дахин гүйцэтгэсэн аудитаар өмнөх зөвлөмжийн агуулга давтагдаж байсан нь удирдлагын захидлаар хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт, банкны удирдлагаас өгсөн хариу/биелэлт хангалтгүй, хүсэл сонирхол бага байсныг гэрчилнэ.
- Аудитын хуулийн этгээдийн санхүүгийн тайланг баталгаажуулахдаа үнэ цэний бууралт үүссэн, хугацаа хэтэрсэн зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн тооцоолол, эргэн төлөгдөх магадлал, активын ангилал зэрэгтэй холбоотой санхүүгийн тайланд материаллаг нөлөө бүхий эрсдэлийг тогтоож, нэг ижил асуудлыг 3-4 жил хөндөн тавьж байсан.
- Гэвч бүхэлдээ асуудлыг үүсгэсэн шалтгааныг арилгах оновчтой зөвлөмж санал болгоогүй, өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг давтан хянаж, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлсэн. Нөгөө талаас банкны ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлэх идэвх санаачилга гаргаагүй алдаа зөрчил жил бүр давтан гарсан.
- Санхүүгийн тайлангийн аудитыг аудитын олон улсын стандартаар гүйцэтгэж, төрийн өмчийн эзэмшилтэй учраас төрийн аудитын байгууллагын мөрдөж буй олон улсын стандарт болон үндэсний стандартыг мөрдөхөд анхаарал хандуулах нь зохимжтой байгаа бөгөөд түүнийг баримтлахгүйгээр хөндлөнгийн аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэх аудит нь хамрах хүрээ, зорилго зорилт, түүний үр нөлөө явцуу хүрээнд зохион байгуулагдах эрсдэлтэй байна .

Шийдвэрлэгдээгүй гол асуудал нь:

- Удирдлагын захидлаар хүргүүлсэн зөвлөмжийн дэлгэрэнгүйд үндэслэн банкны удирдлагаас өгсөн хариу/биелэлтэд анхаарч ажиллах ёстой байсан боловч хэрэгжилт хангалтгүй байсан.

Түүнчлэн дараах асуудлыг Хөгжлийн банкны тухай хууль болон дотоод үйл ажиллагааны зохицуулалтын хүрээнд анхаарч шийдвэрлэвэл зохистой байна. Үүнд:

**“Аудитаар хэрэгжүүлэх арга хэмжээ” буюу “Менежментийн захидлаар санал, зөвлөмж хүргүүлсэн ч биелүүлэх эсэх нь ТУЗ болон банкны гүйцэтгэх удирдлагын идэвх санаачилгаас хамаарах”**

Шалгагдагч этгээд төрийн эзэмшлийн хэлбэртэй тул хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар албан шаардлага өгдөг. Хэрэв шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтоох, мөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тохиолдолд албан шаардлага хүргүүлэх, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцуулах зэргээр шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлэх ёстойг ажлын даалгаварт тусгадаггүй байна.

**“Мэдээллийн хязгаарлалт” буюу “Менежментийн захидлыг зөвхөн тухайн байгууллагад зориулж бэлтгэдэг бөгөөд аудитын хуулийн этгээдийн урьдчилан бичгээр авсан зөвшөөрөлгүйгээр хуулбарлах буюу гуравдагч этгээдэд ил болгох, эсхүл бүхлээр нь болон хэсэгчлэн ишлэх, дурдахыг хориглодог”**

Төрийн аудитын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-д "Төрийн аудитын байгууллага төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайланг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан журмын дагуу улирал бүр гаргаж, өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ" гэж заасан байдгийг харгалзан нотлох ажлын хүрээнд төрийн аудитын байгууллага ээлжит хяналт шалгалтыг гүйцэтгэж байх нь зохимжтой байна.

Аудитын хуулийн этгээдээс хүргүүлсэн удирдлагын захидалд дурдсан зөвлөмжийн



хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 26. Зөвлөмжийн хэрэгжилт

Он	Онилсон асуудал ба чиглэлийн тоо	Хэрэгжсэн	Хэрэгжиж буй	Хэрэгжээгүй
2011	3	3	-	-
2012	16	15	1	-
2013	5	3	2	-
2014	7	4	3	-
2015	10	6	4	-
2016	17	16	1	-
2017	27	16	10	1
2018	11	5	6	-
2019	10	5	4	1
2020	15	8	5	2
2021	17	7	10	-

Аудитын хуулийн этгээд нь санхүүгийн тайланг баталгаажуулахдаа үнэ цэний бууралт үүссэн, хугацаа хэтэрсэн зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн тооцоолол, эргэн төлөгдөх магадлал, активын ангилал зэрэгтэй холбоотой санхүүгийн тайланд материаллаг нөлөө бүхий эрсдэлийг тогтоож, нэг ижил асуудлыг 3-4 жил хөндөж байсан. Гэвч асуудлыг үүсгэсэн шалтгааныг нь арилгах оновчтой зөвлөмж санал болгоогүй. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг давтан хянаж, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлсэн. Нөгөө талаас банкны ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлэх идэвх санаачилга гаргаагүй алдаа зөрчил жил бүр давтан гарсан.

Санхүүгийн тайлангийн аудитыг аудитын олон улсын стандартаар гүйцэтгэж, төрийн өмчийн хэлбэрийн хувьд төрийн аудитын байгууллагын мөрдөж буй олон улсын стандарт болон үндэсний стандартыг мөрдөхөд анхаарал хандуулах, түүнийг баримтлахгүйгээр хөндлөнгийн аудитын гүйцэтгэх аудит нь хамрах хүрээ, зорилго зорилт, үр нөлөө явцуу хүрээнд зохион байгуулагдах эрсдэлтэй.

Өмнөх жилийн аудитын хүрээний зээлийн орчинтой холбогдсон ажиглалт, түүнд суурилсан зөвлөмж давтагдсан нь зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн гэх хариу арга хэмжээний үр дүн төдийлөн гараагүй хэвээр хадгалагдсан, уламжлалт эрсдэл бодитойгоор оршиж ирсэн, өмнөх зөвлөмжийн агуулга давтагдаж байгаа нь удирдлагын захидлаар хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгааг гэрчилж байна.

Зарим жилүүдэд баталгаажуулах аудитын дүнд суурилан өгсөн зөвлөмжид банкны гүйцэтгэх удирдлагаас өгсөн хариу нь зөвлөмжийг хүлээн авахаар гарч байсан ч дараагийн тайлант жилийн баталгаажуулах аудитаар өгсөн зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар удирдлагын захидалд дурдаагүй байна.

Түүнчлэн, Хөгжлийн банкны тухай хуулийн 29.1-д “Хөгжлийн банкны санхүүгийн тайланд төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр сонгосон олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар жил бүр аудит хийлгэж, дүгнэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хамт төлөөлөн удирдах зөвлөлөөс Монголбанк, Засгийн газарт хүргүүлнэ.”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 211 дүгээр зүйлийн 211.9-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийлгэнэ” гэсэн хуулийн заалтууд хоорондоо уялдаагүй байна.

### Ил тод байдал

Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгад ил тод байдлын тухайд зүйлчлэхдээ зөвхөн банкны баримтлах зарчим, банкны жилийн эцсийн аудит хийсэн санхүүгийн тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх асуудлыг хөндсөн болохоос зээл олголтын үйл явц, зээлээр санхүүжсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн ил тод байдлыг хангах талаар зохицуулалтгүй байна.

Нэгэнт тусгайлсан хууль батлан мөрдөж байгаа учраас Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлсэн хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцыг хүлээгдэж буй үр дүн, үр өгөөж нь тод харагдахуйц ил тод байдлыг нэхсэн хуулийн тогтоомжийн нэмэлт өөрчлөлт оруулахыг санал болгож байна.

Энэ нь хөгжлийн төслүүдийг зарлах, санхүүжүүлэх зээл олголтын болон таагүй үр дагаварт хүргэхээс урьдчилан сэргийлэх үйл явцтай ч хамааралтай.

### **3.7.Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 31 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагад хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:**

Үнэлэх хэсэг: 31 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

Томьёолсон шалгуур үзүүлэлт	- Хэрэгжих боломжтой байсан эсэх?
	- Үр дүнд хүрч байсан эсэх?

Хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Хөгжлийн банкны тухай 31 дүгээр зүйл нь дараах агуулгатай. Үүнд:

#### **31 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

31.1.Хөгжлийн банкны тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд шүүгч, эсхүл холбогдох улсын байцаагч доор дурдсан захиргааны шийтгэлийг ногдуулна:

31.1.1.энэ хуулийн 10.1-т заасныг зөрчсөн албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг далан таваас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

31.1.2.энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан хяналт шалгалтад саад учруулсан бол иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван таваас дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг далан таваас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

31.1.3.төлбөр тооцооны баримтыг нуун дарагдуулсан буюу гүйлгээг саатуулсан ажилтан, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

31.1.4.тайлан тэнцэл, мэдээ баримтыг зохих хууль, журмын дагуу гаргаж өгөөгүй буюу энэ хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу холбогдох байгууллагад хүргүүлээгүй, нийтэд мэдээлэх санхүүгийн тайланг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нийтэд мэдээлээгүй бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас далан тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

31.1.5.нийтлүүлсэн тайлан, мэдээлэлд хуурамч, худал, ташаа мэдээлэл агуулагдсан бол уг тайлан, мэдээллийг баталгаажуулсан Гүйцэтгэх захирал, эрх бүхий бусад албан тушаалтныг тус бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг далан таваас хоёр зуун хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

31.1.6.энэ хуулийн 8.2-т заасныг зөрчсөн албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг далан таваас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

Энэ зүйлийн хэрэгжилтэд үнэлгээ хийдээ тус зүйлийг Зөрчлийн тухай хуультай харьцуулан давхардал, хийдэл, зөрчил байгаа эсэх агуулгаар бүхэлд нь хийж гүйцэтгэлээ.

#### ***Зөрчлийн тухай хуультай давхардсан тухай***

Зөрчлийн тухай хуулийг 2017 оны 5 дугаар сарын 11-ны өдөр шинэчлэн батлахдаа Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг зааж өгсөн атлаа 2017 оны 2 дугаар сард батлагдсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгаас хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын зохицуулалтыг хасалгүй орхигдуулснаас хуулийн Хөгжлийн банкны тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын асуудал давхардаж байсан.

Тухайлбал, Хөгжлийн банкны тухай хуулийн 31.1.1-д заасан зөрчил Зөрчлийн тухай хуулийн 11.17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 31.1.2-д заасан зөрчил Зөрчлийн тухай хуулийн 11.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31.1.3-д заасан зөрчил Зөрчлийн тухай хуулийн 11.17 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 31.1.4-д заасан зөрчил Зөрчлийн тухай хуулийн 11.17 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 31.1.5-д заасан зөрчил Зөрчлийн тухай хуулийн 11.17 дугаар зүйлийн 5 дахь хэсэгтэй тус тус давхардсан байх тул Хөгжлийн банкны тухай хуулийн холбогдох заалтуудыг хүчингүй болгох шаардлагатай.

Гэвч Хөгжлийн банкны тухай хуулийн 31.1.6-д заасан зөрчил Зөрчлийн тухай хуулийн 11.17 дугаар зүйлийн 6 дахь хэсэгтэй давхардаж байсан боловч тус заалт нь Хөгжлийн банкны эрхлэх санхүүгийн үйл ажиллагааг илүү тодорхой ойлгомжтой болсонтой холбогдуулан зөрчилд тооцох шаардлагагүй болсон тул 11.17 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг хүчингүй болгож улмаар мөн зүйлийн 7 дахь хэсэгт уялдаа холбоог хангах өөрчлөлтийг оруулах шаардлага үүснэ.

## **ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

2017 оны 02 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн байдлыг үнэлээд дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна.

### **4.1.Дүгнэлт**

2017 онд Монгол Улсын Хөгжлийн банкны хуулийн шинэчлэл нь зорилгодоо хүрээгүй буюу Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх зорилтод нийцсэн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх төрийн шийдвэр амжилттай хэрэгжээгүй байна.

Хуулийн шинэчилсэн найруулга нь тус банкны эрх зүйн байдлыг илүү тодотгож өгсөн ч өмнөх хуулийн гол заалт болох хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийн жагсаалтыг Улсын Их Хурлын хаврын чуулганаар батлуулж байх заалтыг хасаж, УИХ болон Засгийн газар төсөл, хөтөлбөрийг тусгайлан батлахгүй байхаар хуульчилсан бодлогын банкны чиг үүргийг алдагдуулжээ.

Хөгжлийн банкны эрхлэх үйл ажиллагааны хүрээг өргөжүүлж шинэчлэхдээ төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн байх, банк өөрийн санхүүжилт олгох шийдвэрийг бие даан гаргах зохицуулалт тусгасны дээр банкны хяналтын тогтолцоо, үйл ажиллагааны хязгаарлалтыг шинэчлэн тогтоож өгсөн ч банкны үйл ажиллагаа эрсдэлтэй байсаар байна.

Банкны өмнөх хууль болон шинэчилсэн найруулга, банканд мөрдөж ирсэн зээлийн бодлогыг тодорхойлж байгаа тэргүүлэх чиглэл, зарчим, үндсэн нөхцөлүүд ихэнх зээлдэгч нар дээр алдагдсан байна.

Тус банкны ТУЗ-ийн тогтоолоор зээлийн бодлогыг удаа дараа баталсан боловч олгосон зээлийн зориулалт, өнөөгийн нөхцөл байдал болон активын чанаргүй байдал, тухайлсан төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт хуулийн нийцэлтэй холбон авч үзвэл хангагдаагүй, санхүүжүүлсэн төслүүдийн үр өгөөжийн талаарх судалгаа, мэдээлэл хангалтгүй байна.

Зээлийн бодлого, зарчмыг шинэчлэн тодорхойлж 2019 оны А-177 дугаар тушаалаар шинэчлэн баталсан журмын хүрээнд зээл олгох хүртэл үйл явцын үе шатны ажлуудыг гүйцэтгэхэд хангалттай хугацааг мөрдөж байсан боловч үр нөлөө хангалтгүй байжээ.

Тухайлбал, харилцагчийн зээлийн хүсэлт гаргасан хугацаанаас хойш тодорхой ажилбаруудын дараа харилцагчийн материал бүрдүүлэх, судалгаа шинжилгээ хийхэд 90 орчим хоног байгаа бол зээл эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл нийт хугацаа дунджаар 4.4 сар байна. Гэхдээ зарим зээлийг хэт богино хугацаанд шийдвэрлэсэн байх ба богино хугацаанд судлагдаж олгосон зээлүүд голчлон чанаргүй болсон байна.

Зээлийн урьдчилсан судалгаа хангалтгүй хийгдэж, журмаар зохицуулагдсан үе шатны ажилбарууд хангалттай, үр нөлөөтэй байж чадаагүй, нөгөө талаас нэмэлт өөрчлөлт оруулсан болон шинэчилсэн журам мэдэгдэхүйц чанарын ялгаа байхгүй байна.

Санхүүжүүлсэн төслүүдийн хэрэгжилт, зээлийн ашиглалт, зарцуулалт тавих дотоод хяналтын үр нөлөө сул байсан байна.

Хөгжлийн банкны гүйцэтгэх удирдлагаас тус банкны эх үүсвэрээс санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтыг хуульд заасан үндэслэлээр зорилго, хамрах хүрээг тогтоосон удирдамжийг батлан үе шаттайгаар хэрэгжүүлж, гүйцэтгэсний дараа ажлын хэсэг баталгаажуулж, шалгалтын мөрөөр авах арга хэмжээг тушаалаар албажуулж, үр дүнг дотоод нэгжүүд хариуцан ажиллаж ирсэн.

Гэвч банкны зээлийн дотоод хяналт шалгалтаар зарим зээлдэгчийн үйл ажиллагаанд зөрчилтэй байдал үүссэн, гэрээний үүргийн хэрэгжилт хангалтгүй байсан нь нотлогдож байсан ч хяналт шалгалтын ажлын үр нөлөө хангалтгүй байсан байна.

Хяналт шалгалтын ажлын гол зорилго нь "... банкны эх үүсвэрээр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд тус банкнаас төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд олгосон зээлийн зарцуулалтыг шалгаж төсөл, хөтөлбөрийн нийгэм, эдийн засгийн үр ашгийн бодит байдал, санхүүгийн нөхцөл байдлыг судалж, зээлийн зарцуулалт, эргэн төлөлт, гэрээний хэрэгжилтийг дүгнэн, зориулалт бусаар ашигласан, үр ашиггүй зарцуулсан зээлийн эх үүсвэрийг буцаан, үр ашигтай эргүүлэн хуваарилах ажлыг зохион байгуулах"-д оршиж байсан.

Гэтэл Зээлийн дотоод хяналт шалгалтыг үе шаттайгаар тодорхой удирдамжийн дор гүйцэтгэж, түүнийхээ үр дүнг тайлагнаж байсан боловч зээлийн дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлснээр зориулалт бусаар ашигласан байж болохуйц болон төслийн үр дүн хангалтгүй, зөрчилтэй зээлийн дүнг тодорхойлон зээлдэгчийн үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгч, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон шийдвэр гаргасан ч хэрэгжилт хангалтгүй байсан.

Энэ нь Хөгжлийн банкны ТУЗ-ийн дэргэдэх болон гүйцэтгэх удирдлага, зохион байгуулалт дахь хяналт шалгалтын чиг үүрэг бүхий нэгжийн чиг үүргийн хэрэгжилт, бүхэлдээ дотоод хяналтын тогтолцоо сул байсантай холбоотой байна.

Хөгжлийн банкны үйл ажиллагаанд гарсан алдаа, дутагдалд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна:

- Сүүлийн 20 гаруй жилд "хэт ойртсон", зааг ялгаагүй, хаалттай, улс төр-бизнес-банк санхүүгийн санхүүжилтийн тогтолцоо Монгол Улсад нутагшиж, тэр нь Хөгжлийн банкны засаглал, хүний нөөц, шийдвэр гаргалтад гүнзгий нэвтэрсэн;
- Засаглалын хувьд зохистой зарчим хэрэгжээгүй, шийдвэр гаргалт улс төрийн нөлөөллөөс ангид, тогтвортой, мэргэжлийн байж чадаагүй;
- Банкны үндсэн бизнесийн загвар нь тооцоолол судалгаа, шинжилгээнд бүрэн суурилаагүй, орлого олох, эх үүсвэрийн болон үйл ажиллагааны зардлыг нөхөх үйл ажиллагааны чиглэл хангалтгүй;
- Нийт зээлийн санхүүжилтийн дийлэнх нь үндсэн зорилгодоо нийцээгүй;
- Зээлийн зарцуулалт, үр дүнд хийх хяналт сул, хариуцлагын тогтолцоо байхгүй;

Хөгжлийн банканд өнгөрсөн хугацаанд төрийн бүх шатны байгууллагуудаас хийгдсэн хяналт, шалгалтуудын дүгнэлтүүдээс үзэхэд одоогийн эрх зүйн орчинтойгоор, ийм

засаглалтайгаар, ийм үйл ажиллагааны чиглэл, ийм санхүүгийн үзүүлэлтэйгээр цаашид үйл ажиллагаагаа хэвийн гүйцэтгэх боломжгүй гэж дүгнэж байна.

Иймд Хөгжлийн банкнийг олон улсын жишигт нийцсэн үйл ажиллагаатай, эдийн засгийг төрөлжүүлэх зорилтот салбарын төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжилтээр ханган нийгэм, эдийн засагт дэмжлэг үзүүлэх бодлогын банк байх үндсэн зорилго, зорилтыг биелүүлэхэд дараах шийдлүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Нэгт, Банкны үйл ажиллагааны чиглэлийг олон улсын сайн туршлагад нийцүүлж, балансын бүтцийн өөрчлөлтийн болон бизнес загварын хувьд дахин өөрчлөн байгуулалт хийх, үйл ажиллагааг төрөлжүүлэх төлөвлөгөө гаргах;

Хоёрт, Компанийн засаглалын зохистой зарчмыг хэрэгжүүлж, улс төрийн томилгоог халж, мэргэжлийн ТУЗ-ийн багийг сонгон шалгаруулж, хараат бус гишүүдийн тоог нэмэх;

Гуравт, Банкны хяналт шалгалтын тогтолцоог олон улсын банк, санхүүгийн стандарттай нийцүүлэх, аливаа зохицуулалтын хувьд стандарт, дүрэм журмын дагуу тогтоодог байх;

Дөрөвт, Дээрх гурван зөвлөмжийг хангах хүрээнд холбогдох хууль тогтоомж, бодлого, заавар, журамд өөрчлөлтүүдийг хийж, шинэчлэн найруулах;

Тавд, Санхүүгийн өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт хийх, активын чанарын үнэлгээг гаргах, эх үүсвэрийн эргэн төлөлт, балансын бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг боловсруулан, шаардлагатай судалгааг хийсний үндсэн дээр Хөгжлийн банкны үйл ажиллагааны чиглэлийг олон улсын сайн туршлагад нийцүүлж, бизнес загварын хувьд дахин өөрчлөн байгуулалт хийх;

Зургаад, Хөгжлийн банкны засаглал, удирдлагын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх Банкны хяналтын Базелийн хорооноос 2015 онд баталсан “Банканд зориулсан Компанийн засаглал зарчмууд”, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (OECD)-аас гаргасан “Компанийн засаглалын зарчмууд”, “Төрийн өмчит компанийн засаглал”-ын баримт бичгүүдэд засаглал, удирдлагын тогтолцооны үе шат бүхэнд баримтлах зарчмууд, дотоод хяналт ба эрсдэлийн удирдлагын тогтолцооны бүтэц, эрх хэмжээг тусгасан засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй тайлбарыг тусгасан байгаа тул эдгээр баримт бичгүүдэд үндэслэн Банкны засаглалын бодлого, Эрсдэлийн бодлогыг боловсруулан баталж, хэрэгжүүлэх болон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;

#### 4.2.Зөвлөмж

2017 онд батлагдсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг судалсны үндсэн дээр дараах агуулгаар хуулийг шинэчлэн найруулах нь зүйтэй гэсэн зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Хуулийн Нэгдүгээр бүлэгт хуульд хэрэглэгдэх санхүүгийн ажил, үйлчилгээний талаарх ойлголтыг энэ хуульд хэрэглэх нэр томъёоны 4 дүгээр зүйлээр нэмж тодорхойлох;
2. Монгол Улсын Хөгжлийн банкны эрх зүйн байдлыг тодорхойлсон хуулийн 5 дугаар зүйлд банкны эрх зүйн статус, банкны үйл ажиллагаа явуулах хэлбэрийг тодорхойлох;
3. Монгол Улсын Хөгжлийн банкны зорилт, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, эрх хэмжээг хуульчлах;
4. Монгол Улсын Хөгжлийн банкны зарчим, хориглох үйл ажиллагаа, Хөгжлийн банканд тавигдах шаардлагыг шинээр хуульчлах;
5. Хөгжлийн банкны эрхлэх санхүүгийн ажил үйлчилгээг банкны зорилго, зорилттой нийцүүлэн шинэчлэн тодорхойлох;
6. Хөгжлийн банкны үйл ажиллагаанд засаглалын тогтвортой байдал, шийдвэр гаргалтын эрх хэмжээг зөв хуваарилах, үүрэг, хариуцлагыг тодорхой зааж өгөх зорилгоор Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, тэдгээрийг томилох чөлөөлөх асуудал, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тавигдах шалгуурыг өөрчлөх, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг шинэчлэн найруулж, төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны талаар нэмэлт оруулах;

7. Гүйцэтгэх захирлын хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх асуудлыг хуульчлах, гүйцэтгэх захиралд тавигдах шалгуурыг өөрчилж, гүйцэтгэх захирлын эрх, үүргийг шинэчлэн найруулах;
8. Хөгжлийн банкны үйл ажиллагаанд Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх, Засгийн газрын бүрэн эрх, Монголбанкны хяналтыг ойлгомжтой болгох зорилгоор Хөгжлийн банкнаас бусадтай харилцах зарчмыг ойлгомжтой болгож өөрчлөх;
9. Хөгжлийн банк чанаргүй активын эрсдэлийг бууруулах зорилгоор эрсдэлтэй активт бүтцийн өөрчлөлт хийх, банкны мэргэжлийн байгууллагуудын ашигладаг арга хэрэгслийг ашиглах талаар нэмэлт оруулах;
10. Банкнаас санхүүжүүлсэн, санхүүжүүлэх төслийн үйл явц, хэрэгжилтийн байдал, санхүүжилтийн талаарх мэдээллийг нээлттэй, ил тод болгох зохицуулалтыг нэмэх

Дээрх зөвлөмжийн хүрээнд Хөгжлийн банкныг иж бүрэн өөрчлөн зохион байгуулах бүтцийн өөрчлөлт хийх, холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзлээ.

--- оОо ---